

**ЭДИЙН ЗАСГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ
МОНГОЛ УЛС, ЯПОН УЛС
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Агуулга

Оршил

1 дүгээр бүлэг Ерөнхий зүйл

| | |
|------------------|-------------------------------|
| 1.1 дүгээр зүйл | Зорилго |
| 1.2 дугаар зүйл | Ерөнхий тодорхойлолт |
| 1.3 дугаар зүйл | Ил тод байдал |
| 1.4 дүгээр зүйл | Олон нийтийн санал авах журам |
| 1.5 дугаар зүйл | Захиргааны журам |
| 1.6 дугаар зүйл | Хянан үзэх ба давж заалдах |
| 1.7 дугаар зүйл | Авлигын эсрэг арга хэмжээ |
| 1.8 дугаар зүйл | Нууц мэдээлэл |
| 1.9 дүгээр зүйл | Татвар |
| 1.10 дугаар зүйл | Үл хэрэглэх тохиолдол |
| 1.11 дүгээр зүйл | Бусад хэлэлцээрт хамаарах нь |
| 1.12 дугаар зүйл | Хэрэгжүүлэх хэлэлцээр |
| 1.13 дугаар зүйл | Хамтарсан хороо |
| 1.14 дүгээр зүйл | Дэд хороо |
| 1.15 дугаар зүйл | Харилцаа холбоо |

2 дугаар бүлэг Барааны худалдаа

| 1 дүгээр хэсэг | Ерөнхий дүрэм |
|------------------|---|
| 2.1 дүгээр зүйл | Тодорхойлолт |
| 2.2 дугаар зүйл | Барааны ангилал |
| 2.3 дугаар зүйл | Үндэсний нөхцөл |
| 2.4 дүгээр зүйл | Гаалийн татварыг тэглэх, эсхүл бууруулах |
| 2.5 дугаар зүйл | Гаалийн үнэлгээ |
| 2.6 дугаар зүйл | Экспортын татаас |
| 2.7 дугаар зүйл | Импортын болон экспортын хязгаарлалт |
| 2 дугаар хэсэг | Хамгаалалтын арга хэмжээ |
| 2.8 дугаар зүйл | Хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх нь |
| 2.9 дүгээр зүйл | Нөхцөл болон хязгаарлалт |
| 2.10 дугаар зүйл | Мөрдөн шалгалт |
| 2.11 дүгээр зүйл | Мэдэгдэх болон зөвлөлдөх |
| 2.12 дугаар зүйл | Нөхөн олговор |
| 2.13 дугаар зүйл | Хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээ |
| 2.14 дүгээр зүйл | ДХБ-ын тухай хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээтэй хамаарах нь |
| 2.15 дугаар зүйл | Харилцаа холбоо |
| 2.16 дугаар зүйл | Хяналт |

3 дугаар хэсэг

Бусад заалт

- | | |
|------------------|--|
| 2.17 дугаар зүйл | Демпингийн эсрэг болон саармагжуулах арга хэмжээ |
| 2.18 дугаар зүйл | Төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор авах арга хэмжээ |
| 2.19 дүгээр зүйл | Барааны худалдааны дэд хороо |
| 2.20 дугаар зүйл | Барааны худалдааны талаарх үйл ажиллагааны журам |
| 2.21 дүгээр зүйл | Экспорттой холбоотой хамтын ажиллагаа |

3 дугаар бүлэг Гарал үүслийн дүрэм

- | | |
|------------------|---|
| 3.1 дүгээр зүйл | Тодорхойлолт |
| 3.2 дугаар зүйл | Зохих гарал үүсэлтэй бараа |
| 3.3 дугаар зүйл | Бүрэн гарал үүсэлтэй бараа |
| 3.4 дүгээр зүйл | Өртгийн агууламжийн шаардлага |
| 3.5 дугаар зүйл | Нийлмэл гарал үүсэл |
| 3.6 дугаар зүйл | <i>De Minimis (Үл тооцох хувь)</i> |
| 3.7 дугаар зүйл | Үл хамаарах ажиллагаа |
| 3.8 дугаар зүйл | Тээвэрлэлтийн шалгуур |
| 3.9 дүгээр зүйл | Угсраагүй буюу задалсан бараа |
| 3.10 дугаар зүйл | Орлох бараа болон материал |
| 3.11 дүгээр зүйл | Туслах материал |
| 3.12 дугаар зүйл | Дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл болон багаж хэрэгсэл |

| | |
|------------------|---|
| 3.13 дугаар зүйл | Жижиглэн худалдах барааны савлагаа, баглаа боодлын материал болон хайрцаг сав |
| 3.14 дүгээр зүйл | Бараа тээвэрлэх болон ачих зориулалттай савлагаа, баглаа боодлын материал болон хайрцаг сав |
| 3.15 дугаар зүйл | Тарифын хөнгөлөлт эдлэх хүсэлт |
| 3.16 дугаар зүйл | Гарал үүслийн гэрчилгээ |
| 3.17 дугаар зүйл | Экспортын үйл ажиллагаатай холбогдуулан хүлээх үүрэг |
| 3.18 дугаар зүйл | Гарал үүслийн гэрчилгээг шалгах хүсэлт |
| 3.19 дүгээр зүйл | Газар дээр нь очиж шалгах |
| 3.20 дугаар зүйл | Гарал үүслийг тодорхойлох асуудал болон тарифын хөнгөлөлт |
| 3.21 дүгээр зүйл | Мэдээллийн нууцыг хамгаалах |
| 3.22 дугаар зүйл | Жижиг алдаа |
| 3.23 дугаар зүйл | Худал мэдүүлэг өгсөн тохиолдолд хүлээлгэх шийтгэл, авах арга хэмжээ |
| 3.24 дүгээр зүйл | Бусад заалт |
| 3.25 дугаар зүйл | Гарал үүслийн дүрмийн дэд хороо |
| 3.26 дугаар зүйл | Гарал үүслийн үйл ажиллагааны журам |

4 дүгээр бүлэг Гаалийн үйл ажиллагаа болон худалдааг хөнгөвчлөх

| | |
|-----------------|----------------------------|
| 4.1 дүгээр зүйл | Хамрах хүрээ болон зорилго |
| 4.2 дугаар зүйл | Тодорхойлолт |
| 4.3 дугаар зүйл | Ил тод байдал |

| | |
|-----------------|--|
| 4.4 дүгээр зүйл | Гаалийн бүрдүүлэлт |
| 4.5 дугаар зүйл | Түр хугацаагаар оруулах болон дамжин өнгөрөх бараа |
| 4.6 дугаар зүйл | Урьдчилан шийдвэрлэх |
| 4.7 дугаар зүйл | Хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох |
| 4.8 дугаар зүйл | Гаалийн үйл ажиллагааны болон худалдааг хөнгөвчлөх дэд хороо |

5 дугаар бүлэг Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ

| | |
|-----------------|---|
| 5.1 дүгээр зүйл | Хамрах хүрээ |
| 5.2 дугаар зүйл | Эрх болон үүргээ дахин баталгаажуулах |
| 5.3 дугаар зүйл | Уялдуулан зохицуулах |
| 5.4 дүгээр зүйл | Адилтган үзэх |
| 5.5 дугаар зүйл | Мэдээлэл, лавлагааны төв |
| 5.6 дугаар зүйл | Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн хорио цээрийн арга хэмжээний дэд хороо |
| 5.7 дугаар зүйл | 16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай |

6 дугаар бүлэг Техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журам

| | |
|-----------------|---------------------------|
| 6.1 дүгээр зүйл | Хамрах хүрээ |
| 6.2 дугаар зүйл | Зорилго |
| 6.3 дугаар зүйл | Тодорхойлолт |
| 6.4 дүгээр зүйл | Эрх, үүргийг дахин нотлох |
| 6.5 дугаар зүйл | Олон улсын стандарт |

| | |
|------------------|--|
| 6.6 дугаар зүйл | Техникийн зохицуулалт |
| 6.7 дугаар зүйл | Тохирлын үнэлгээний журмын үр дүнг хүлээн зөвшөөрөх |
| 6.8 дугаар зүйл | Мэдээлэл, лавлагааны төв |
| 6.9 дүгээр зүйл | Техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмын дэд хороо |
| 6.10 дугаар зүйл | 16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай |

7 дугаар бүлэг Үйлчилгээний худалдаа

| | |
|------------------|---|
| 7.1 дүгээр зүйл | Хамрах хүрээ |
| 7.2 дугаар зүйл | Тодорхойлолт |
| 7.3 дугаар зүйл | Үндэсний нөхцөл |
| 7.4 дүгээр зүйл | Нэн тааламжтай үндэстний нөхцөл |
| 7.5 дугаар зүйл | Зах зээлд нэвтрэх |
| 7.6 дугаар зүйл | Нэмэлт үүрэг, амлалт |
| 7.7 дугаар зүйл | Тусгай үүрэг амлалтын жагсаалт |
| 7.8 дугаар зүйл | Дотоодын зохицуулалт |
| 7.9 дүгээр зүйл | Хүлээн зөвшөөрөх |
| 7.10 дугаар зүйл | Дангаар ноёрхол ба онцгой үйлчилгээ үзүүлэгчид |
| 7.11 дүгээр зүйл | Бизнесийн үйл ажиллагаа |
| 7.12 дугаар зүйл | Төлбөр болон шилжүүлэг |
| 7.13 дугаар зүйл | Төлбөрийн тэнцлийг хамгаалах зорилгоор хийх хязгаарлалт |

| | |
|------------------|-----------------------------------|
| 7.14 дүгээр зүйл | Ил тод байдал |
| 7.15 дугаар зүйл | Ашгаас татгалзах |
| 7.16 дугаар зүйл | Үйлчилгээний худалдааны дэд хороо |
| 7.17 дугаар зүйл | Үүрэг амлалтыг хянан үзэх |

8 дугаар бүлэг Хувь хүний шилжилт хөдөлгөөн

| | |
|-----------------|--|
| 8.1 дүгээр зүйл | Ерөнхий зарчим |
| 8.2 дугаар зүйл | Хамрах хүрээ |
| 8.3 дугаар зүйл | Тодорхойлолт |
| 8.4 дүгээр зүйл | Тусгай үүрэг амлалт |
| 8.5 дугаар зүйл | Шаардлага болон журам |
| 8.6 дугаар зүйл | Хувь хүний шилжилт хөдөлгөөний дэд хороо |
| 8.7 дугаар зүйл | Маргаан шийдвэрлэх |

9 дүгээр бүлэг Цахим худалдаа

| | |
|-----------------|---|
| 9.1 дүгээр зүйл | Ерөнхий заалт |
| 9.2 дугаар зүйл | Тодорхойлолт |
| 9.3 дугаар зүйл | Гаалийн татвар |
| 9.4 дүгээр зүйл | Тоон бүтээгдэхүүнийг үл ялгаварлах нөхцөл |
| 9.5 дугаар зүйл | Цахим гарын үсэг |
| 9.6 дугаар зүйл | Хэрэглэгчийг хамгаалах |
| 9.7 дугаар зүйл | Худалдааны сайн дурын цахим шуудан |
| 9.8 дугаар зүйл | Цаасгүй худалдаа удирдан явуулах |
| 9.9 дүгээр зүйл | Дотоодын зохицуулалт |

| | |
|------------------|--|
| 9.10 дугаар зүйл | Тооцооллын хэрэгслийн байршилд хамаарах шаардлагад хориглох зүйл |
| 9.11 дүгээр зүйл | Эх код |
| 9.12 дугаар зүйл | Хамтын ажиллагаа |
| 9.13 дугаар зүйл | Цахим худалдааны дэд хороо |

10 дугаар бүлэг Хөрөнгө оруулалт

| | |
|-------------------|---|
| 10.1 дүгээр зүйл | Хамрах хүрээ |
| 10.2 дугаар зүйл | Тодорхойлолт |
| 10.3 дугаар зүйл | Үндэсний нөхцөл |
| 10.4 дүгээр зүйл | Нэн тааламжтай үндэстний нөхцөл |
| 10.5 дугаар зүйл | Ерөнхий нөхцөл |
| 10.6 дугаар зүйл | Шүүхэд хандах боломж |
| 10.7 дугаар зүйл | Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг |
| 10.8 дугаар зүйл | Үл нийцэх арга хэмжээ |
| 10.9 дүгээр зүйл | Албадан хураах болон нөхөн төлбөр олгох |
| 10.10 дугаар зүйл | Мөргөлдөөнөөс хамгаалах |
| 10.11 дүгээр зүйл | Шилжүүлэг |
| 10.12 дугаар зүйл | Даатгагдсан төлөөлөл |
| 10.13 дугаар зүйл | Нэг Тал болон нөгөө Талын хөрөнгө оруулагч хоорондын хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг шийдвэрлэх |
| 10.14 дүгээр зүйл | Түр хамгаалах арга хэмжээ |
| 10.15 дугаар зүйл | Урьдчилан сэргийлэх арга хэмжээ |

| | |
|-------------------|---|
| 10.16 дугаар зүйл | Ашгаас татгалзах |
| 10.17 дугаар зүйл | Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хүрээлэн буй орчны арга хэмжээ болон Хөдөлмөрийн стандарт |
| 10.18 дугаар зүйл | Хөрөнгө оруулалтын дэд хороо |
| 10.19 дүгээр зүйл | Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрт хамаарах байдал |
| 10.20 дугаар зүйл | Үргэлжлэх хугацаа болон хүчингүй болгох хугацаа |

11 дүгээр бүлэг Өрсөлдөөн

| | |
|------------------|---|
| 11.1 дүгээр зүйл | Өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа |
| 11.2 дугаар зүйл | Өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хамтран ажиллах |
| 11.3 дугаар зүйл | Үл ялгаварлах |
| 11.4 дүгээр зүйл | Журмын шударга байдал |
| 11.5 дугаар зүйл | Ил тод байдал |
| 11.6 дугаар зүйл | 1.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай |

12 дугаар бүлэг Оюуны өмч

| | |
|------------------|-----------------|
| 12.1 дүгээр зүйл | Ерөнхий заалт |
| 12.2 дугаар зүйл | Тодорхойлолт |
| 12.3 дугаар зүйл | Үндэсний нөхцөл |
| 12.4 дүгээр зүйл | Журмын асуудал |
| 12.5 дугаар зүйл | Ил тод байдал |

| | |
|-------------------|---|
| 12.6 дугаар зүйл | Оюуны өмчийг хамгаалах талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх |
| 12.7 дугаар зүйл | Патент |
| 12.8 дугаар зүйл | Бүтээгдэхүүний загвар |
| 12.9 дүгээр зүйл | Барааны тэмдэг |
| 12.10 дугаар зүйл | Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрх |
| 12.11 дүгээр зүйл | Газар зүйн заалт |
| 12.12 дугаар зүйл | Шударга бус өрсөлдөөн |
| 12.13 дугаар зүйл | Хаалттай мэдээллийг хамгаалах |
| 12.14 дүгээр зүйл | Хэрэгжилтийг хангах – Хил дээр авах арга хэмжээ |
| 12.15 дугаар зүйл | Хэрэгжилтийг хангах – Иргэний арга хэмжээ |
| 12.16 дугаар зүйл | Хэрэгжилтийг хангах – Эрүүгийн арга хэмжээ |
| 12.17 дугаар зүйл | Хэрэгжилтийг цахим орчинд хангах |
| 12.18 дугаар зүйл | Оюуны өмчийн дэд хороо |
| 12.19 дүгээр зүйл | Аюулгүй байдалтай холбоотой үл хэрэглэх тохиолдол |

13 дугаар бүлэг Засгийн газрын худалдан авах ажиллагаа

| | |
|------------------|----------------------------------|
| 13.1 дүгээр зүйл | Худалдан авах ажиллагааны зарчим |
| 13.2 дугаар зүйл | Мэдээлэл солилцох |
| 13.3 дугаар зүйл | Нэмэлт хэлэлцээ |
| 13.4 дүгээр зүйл | Үл ялгаварлах талаарх хэлэлцээ |

13.5 дугаар зүйл Засгийн газрын худалдан авах ажиллагааны дэд хороо

14 дүгээр бүлэг Бизнесийн орчныг сайжруулах

14.1 дүгээр зүйл Үндсэн зарчим

14.2 дугаар зүйл Бизнесийн орчныг сайжруулах дэд хороо

14.3 дугаар зүйл Харилцах газар

14.4 дүгээр зүйл 16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай

15 дугаар бүлэг Хамтын ажиллагаа

15.1 дүгээр зүйл Үндсэн зарчим

15.2 дугаар зүйл Хамтын ажиллагааны салбар болон хэлбэр

15.3 дугаар зүйл Хамтын ажиллагааны зардал

15.4 дүгээр зүйл Хамтын ажиллагааны дэд хороо

15.5 дугаар зүйл 16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай

16 дугаар бүлэг Маргаан шийдвэрлэх

16.1 дүгээр зүйл Хамрах хүрээ

16.2 дугаар зүйл Ерөнхий зарчим

16.3 дугаар зүйл Шүүхийн сонголт

16.4 дүгээр зүйл Зөвлөлдөх

16.5 дугаар зүйл Сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх буюу зуучлах

16.6 дугаар зүйл Арбитрын шүүх байгуулах

16.7 дугаар зүйл Арбитрын шүүхийн бүрэлдэхүүн

16.8 дугаар зүйл Арбитрийн шүүхийн чиг үүрэг

| | |
|-------------------|---|
| 16.9 дүгээр зүйл | Арбитрийн шүүхийн үйл ажиллагаа |
| 16.10 дугаар зүйл | Арбитрын шүүхийн үйл ажиллагааг зогсоох |
| 16.11 дүгээр зүйл | Шийдвэр хэрэгжүүлэх |
| 16.12 дугаар зүйл | Хугацаанд өөрчлөлт оруулах |
| 16.13 дугаар зүйл | Зардал |
| 16.14 дүгээр зүйл | Хэл |

17 дугаар бүлэг Төгсгөлийн заалт

| | |
|------------------|--------------------------|
| 17.1 дүгээр зүйл | Агуулга болон гарчиг |
| 17.2 дугаар зүйл | хавсралт болон тайлбар |
| 17.3 дугаар зүйл | Нэмэлт, өөрчлөлт оруулах |
| 17.4 дүгээр зүйл | Хүчин төгөлдөр болох |
| 17.5 дугаар зүйл | Цуцлах |
| 17.6 дугаар зүйл | Хүчинтэй эх бичвэр |

| | |
|---|---|
| 2 дугаар бүлэгт дурдсан 1 дүгээр хавсралт | 2.4 дүгээр зүйлтэй холбоотой жагсаалт |
| 3 дугаар бүлэгт дурдсан 2 дугаар хавсралт | Бүтээгдэхүүний тусгай дүрэм |
| 3 дугаар бүлэгт дурдсан 3 дугаар хавсралт | Гарал үүслийн гэрчилгээнд тусгагдах үндсэн мэдээлэл |
| 7 дугаар бүлэгт дурдсан 4 дүгээр хавсралт | Санхүүгийн үйлчилгээ |
| 7 дугаар бүлэгт дурдсан 5 дугаар хавсралт | Цахилгаан холбооны үйлчилгээ |

| | |
|---|---|
| 7 дугаар бүлэгт дурдсан 6 дугаар хавсралт | Тусгай үүрэг амлалтын жагсаалт болон Нэн тааламжтай үндэстний нөхцөлөөс чөлөөлөх жагсаалт |
| 8 дугаар бүлэгт дурдсан 7 дугаар хавсралт | Хувь хүний шилжилт хөдөлгөөний талаарх Тусгай үүрэг амлалт |
| 10 дугаар бүлэгт дурдсан 8 дугаар хавсралт | 10.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хадгалах арга хэмжээ |
| 10 дугаар бүлэгт дурдсан 9 дүгээр хавсралт | 10.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дурдсан хадгалах арга хэмжээ |
| 10 дугаар бүлэгт дурдсан 10 дугаар хавсралт | Албадан хураалт |

Оршил

Монгол Улс болон Япон Улс нь,

Талууд хоорондын дотно харилцаа болон худалдаа, хөрөнгө оруулалт, түүнчлэн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлснээр бий болсон эдийн засаг, улс төрийн бат бөх холбоог ухамсарлан,

Даяаршил болон дэлхийн эдийн засгийн интеграцчиллын үр дүнд дэлхийн хурдацтай өөрчлөгдөж байгаа орчин нь эдийн засгийн шинэ сорилт, боломжийг Талуудад бий болгож байгааг харгалзан,

Талуудын эдийн засаг харилцан бие биеэ нөхөх боломжтой бөгөөд энэхүү боломж нь өөрсдийн эдийн засгийн хүчийг ашиглан хоёр талын худалдаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаар дамжуулан эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулна гэдгийг харгалзан,

Талуудын эдийн засгийн хөгжлийн түвшингийн ялгаатай байдлыг харгалзан,

Талууд хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтыг зохицуулах харилцан ашигтай дүрэм, журам бий болгох замаар худалдаа, хөрөнгө оруулалтын хүрээг тодорхой, баталгаатай болгохыг эрмэлзэн,

Талуудын эдийн засгийн өрсөлдөх чадвар болон нийлүүлэлтийн чадавхийг бэхжүүлэх, тэдгээрийн зах зээлийг илүү үр ашигтай, идэвхтэй болгох, хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтыг цаашид нэмэгдүүлэхэд худалдааны урьдчилан таамаглах боломжтой орчин бүрдүүлэх, түүнчлэн Талуудын эдийн засгийн цаашдын үр ашиг, өсөлтөд хувь нэмэр оруулахыг дахин эрмэлзэн,

Талууд хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэхэд хувийн хэвшлийн гүйцэтгэх үүргийг тэмдэглэн энэхүү хэлэлцээрээр хувийн хэвшилд худалдаа, хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг бий болгоно гэдгийг тэмдэглэн,

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлснээр хүний нөөцийг хөгжүүлэн ажлын байрны шинэ болон илүү боломжуудыг бий болгоход хувь нэмэр оруулж, улмаар Талуудын хүн амын амьжиргааны түвшин, үүний дотор хэрэглэгчийн сайн сайхан байдлыг дээшлүүлнэ гэдэгт итгэж,

Энэхүү хэлэлцээр нь Талууд хоорондын өнөөгийн улс төр, эдийн засгийн холбоог бэхжүүлээд зогсохгүй Монгол Улс, Япон Улсын хооронд “стратегийн түншлэл”-ийг бий болгоход нэгэн чухал алхам болно гэдэг итгэл үнэмшлийг дахин нотолж,

1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 24 дүгээр зүйл болон Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн 5 дугаар зүйлийг тус тус эргэн санаж,

Энэхүү хэлэлцээр Талууд хоорондын харилцаанд шинэ эрин авч ирнэ гэдэгт итгэж, түүнчлэн

Талууд хоорондын эдийн засгийн түншлэлийг бэхжүүлэх эрх зүйн хүрээг тодорхойлох шийдвэр төгс байж,

Дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр бүлэг Ерөнхий зүйл

1.1 дүгээр зүйл Зорилго

Энэхүү хэлэлцээрийн зорилго нь Талуудын хөгжлийн үе шат, эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан дараахь зорилтыг хэрэгжүүлэх замаар эдийн засагт түлхэц үзүүлэхэд оршино:

- (a) Талууд хоорондын бараа болон үйлчилгээний худалдааг чөлөөлөх болон хөнгөвчлөх;
- (b) Талууд хоорондын хувь хүний шилжилт хөдөлгөөнийг хөнгөвчлөх;
- (c) хөрөнгө оруулалтын боломжуудыг нэмэгдүүлэх, мөн Талуудын хөрөнгө оруулалт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны хамгаалалтыг бэхжүүлэх;
- (d) оюуны өмчийн хамгаалалтыг сайжруулах;
- (e) Талуудын өрсөлдөөний хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагаа, уялдааг дэмжих;
- (f) худалдаа, хөрөнгө оруулалтад хамааралтай бүх салбарт хоёр талын хамтын ажиллагааг цаашид эрчимжүүлэх, өргөтгөн гүнзгийрүүлж, бизнесийн орчныг сайжруулах хүрээг тодорхойлох;
- (g) энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, маргаанаас сэргийлэх, маргааныг шийдвэрлэх үр дүнтэй журмыг бий болгох зэрэг орно.

1.2 дугаар зүйл Ерөнхий тодорхойлолт

Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол хэлэлцээрийн зорилгоор:

- (a) “Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь Дэлхийн Худалдааны Байгууллагын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн 7 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (b) “нутаг дэвсгэр” гэх нэр томьёо нь:

(i) Япон Улсын хувьд, Япон Улсын нутаг дэвсгэр болон олон улсын эрх зүйн дагуу Япон Улс өөрийн бүрэн эрх, эсхүл шүүхийн эрх мэдлээ хэрэгжүүлж байгаа эдийн засгийн онцгой бүс болон эх газрын хормой;

(ii) Монгол Улсын хувьд, Монгол Улсын нутаг дэвсгэрийг хэлнэ;

Тайлбар: Энэхүү заалт нь олон улсын эрх зүйн хүрээнд Талуудын хүлээсэн эрх, үүрэг, үүний дотор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Далайн эрх зүйн тухай конвенцоор хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.

(c) “арилжааны төлөөлөл” гэх нэр томьёо нь аль нэг Талын нутаг дэвсгэрт бизнесийн, эсхүл мэргэжлийн байгууллагын үйлчилгээ үзүүлэх зорилгоор:

(i) байгуулсан, худалдан авсан, ажиллуулж буй хуулийн этгээдийг;

(ii) байгуулсан буюу ажиллуулж буй салбар, төлөөлөгчийн газар зэргийг хэлнэ;

(d) “гаалийн байгууллага” гэх нэр томьёо нь Талуудын болон энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хуулийн дагуу гаалийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй эрх бүхий байгууллага буюу:

(i) Япон Улсын хувьд Сангийн яам, эсхүл түүний залгамжлагч;

(ii) Монгол Улсын хувьд Гаалийн ерөнхий газар, эсхүл түүний залгамжлагчийг хэлнэ;

(e) “хоног” гэх нэр томьёо нь амралт болон баярын өдрүүдийг оролцуулан хуанлийн өдрийг хэлнэ;

(f) “аж ахуйн нэгж” гэх нэр томьёо нь тохирох хууль тогтоомжийн дагуу байгуулсан, эсхүл зохион байгуулсан ашгийн болон ашгийн бус, хувийн, эсхүл төрийн өмчит, эсхүл тэдгээрийн хяналтад байгаа корпораци, сан, нөхөрлөл, ганцаар өмчлөл, хамтарсан компани, нэгдэл, байгууллага, эсхүл компани зэрэг аливаа хуулийн этгээд буюу аж ахуйн нэгжийг хэлнэ;

- (g) “аль нэг Талын аж ахуйн нэгж” гэх нэр томьёо нь тухайн Талын холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, эсхүл зохион байгуулсан аж ахуйн нэгжийг хэлнэ;
- (h) “ҮХЕХ” гэх нэр томьёо нь Дэлхийн Худалдааны Байгууллагын тухай хэлэлцээрийн 1В хавсралт дахь Үйлчилгээний худалдааны тухай ерөнхий хэлэлцээрийг хэлнэ;
- (i) “1994 оны ТХЕХ” гэх нэр томьёо нь Дэлхийн Худалдааны Байгууллагын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь 1994 оны Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийг хэлнэ. Энэхүү хэлэлцээрийн зорилгоор 1994 оны ТХЕХ зүйлийн тайлбар мөн хамаарна;
- (j) “Уялдуулсан систем”, эсхүл “УС” гэх нэр томьёо нь Барааг тодорхойлон кодлох уялдуулсан системийн тухай олон улсын конвенцийн хавсралтад заасан бөгөөд Талууд батлан өөрсдийн хуулийн хүрээнд хэрэгжүүлж байгаа Барааг тодорхойлон кодлох уялдуулсан системийг хэлнэ;
- (k) “хөрөнгө оруулалт” гэх нэр томьёо нь хөрөнгө оруулагчийн шууд, эсхүл шууд бус эзэмшилд, эсхүл хяналтад байгаа дараахь хөрөнгийг хэлнэ. Үүнд:
- (i) аж ахуйн нэгж болон аж ахуйн нэгжийн салбар;
 - (ii) хувьцаа, эсхүл түүний дотор аж ахуйн нэгжийн өмчийн оролцооны бусад хэлбэр тэдгээртэй холбогдсон эрх;
 - (iii) үнэт цаас, өрийн бичиг, зээл болон түүний дотор тэдгээртэй холбогдсон эрх зэрэг өрийн бусад хэлбэрийг хамарна;
 - (iv) гэрээгээр үүсэх эрх түүний дотор түлхүүр гардуулах, барилга, менежментийн, бүтээгдэхүүн, эсхүл ашиг хуваах зэрэг эрхийг хамарна;
 - (v) санхүүгийн үнэ цэнэтэй аливаа гэрээнээс үүсэх мөнгөний болон үүргийн биелэлтийг шаардах нэхэмжлэл;
 - (vi) оюуны өмч;

Тайлбар: Оюуны өмч гэх нэр томъёо нь 12.2 дугаар зүйлд заасныг хэлнэ.

(vii) хууль тогтоомж, эсхүл гэрээний дагуу олгогдсон концесс, лиценз, эрх олгох болон зөвшөөрлийн эрх, түүний дотор санхүү, харилцаа холбооны үйлчилгээ үзүүлэх, цөмийн эрчим хүчний үйлдвэрлэл болон байгалийн баялгийг олборлох, ашиглах зэрэг болон эдгээрээр үл хязгаарлагдах эрхийг хамруулан;

(viii) аливаа бусад биет болон биет бус, хөдлөх болон үл хөдлөх өмч болон түрээс, ипотека, хөрөнгө барьцаалах болон үүрэг хүлээх зэрэг аливаа хөрөнгөтэй холбоотой эрх;

Тайлбар: Хөрөнгө оруулалт нь хөрөнгө оруулалтаар оруулсан дүнг тухайлбал ашиг, хүү, хөрөнгийн үр ашиг, ногдол ашиг, роялти болон хураамжийг багтаана. Хөрөнгө оруулалтын хэлбэрийг өөрчлөх нь хөрөнгө оруулалтын шинж чанарыг өөрчлөхгүй.

(l) “аль нэг Талын хөрөнгө оруулагч” гэх нэр томъёо нь нөгөө Талын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалт хийх гэж байгаа, эсхүл хийж байгаа буюу хийсэн:

(i) тухайн Талын хуулийн дагуу иргэн нь болох хувь хүнийг;

(ii) тухайн Талын аж ахуйн нэгжийг хэлнэ.

(m) “хуулийн этгээд” гэх нэр томъёо нь тохирох хуулийн дагуу байгуулсан, эсхүл зохион байгуулсан ашгийн болон ашгийн бус, хувийн болон төрийн өмчийн корпораци, сан, нөхөрлөл, хамтарсан компани, ганцаар өмчлөл, эсхүл нэгдэл зэрэг аливаа хуулийн этгээдийг хэлнэ;

(n) хуулийн этгээд нь:

(i) хэрэв хөрөнгө оруулагч түүний хувь нийлүүлсэн хөрөнгийн 50-иас дээш хувийг эзэмшдэг бол тухайн этгээдийн “эзэмшлийн”;

(ii) хэрэв хөрөнгө оруулагч түүний захирлуудын дийлэнх олонхыг томилох, эсхүл хуулийн дагуу түүний үйл ажиллагааг чиглүүлэх эрх мэдэлтэй бол тухайн этгээдийн “хяналтын” байна;

- (o) “зохих гарал үүсэлтэй бараа” гэх нэр томьёо нь гарал үүсэл нь 3 дугаар бүлгийн заалтын дагуу тодорхойлсон барааг хэлнэ;
- (p) “Талууд” гэх нэр томьёо нь Монгол Улс болон Япон Улсыг, “Тал” гэдэг нь Монгол Улс, эсхүл Япон Улсыг хэлнэ;
- (q) “этгээд” гэх нэр томьёо нь тухайн нөхцөлөөс хамааран хувь хүн, эсхүл аж ахуйн нэгж/хуулийн этгээдийг хэлнэ;
- (r) “үйлчилгээ үзүүлэгч” гэх нэр томьёо нь аливаа үйлчилгээ үзүүлж байгаа, эсхүл үзүүлэх этгээдийг хэлнэ;

Тайлбар: Үйлчилгээг хуулийн этгээд шууд үзүүлж байгаа, эсхүл үзүүлэх бус, харин салбар, төлөөлөгчийн газар зэрэг арилжааны зорилго бүхий аливаа байгууллагын бусад хэлбэрээр үзүүлж байгаа, эсхүл үзүүлэх бол үйлчилгээ үзүүлэгчдэд (өөрөөр хэлбэл хуулийн этгээд) 7 дугаар бүлгийн дагуу энэхүү арилжааны төлөөлөл бүхий байгууллагаар дамжуулан олгох нөхцөлийг олгоно. Ийм нөхцөлийг үйлчилгээ үзүүлж байгаа, эсхүл үзүүлэх арилжааны төлөөлөл бүхий байгууллагад олгох ба үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээ үзүүлж байгаа, эсхүл үзүүлэх тухайн Талын нутаг дэвсгэрээс гадуур орших хэсэгт олгох шаардлагагүй.

- (s) “ЭАУЭААХХ тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь Дэлхийн Худалдааны Байгууллагын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (t) “төрийн өмчит аж ахуйн нэгж” гэх нэр томьёо нь аль нэг Талын өмч, эсхүл хяналтад байгаа хуулийн этгээдийг хэлнэ;
- (u) “ОӨЭХХА-ын тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь Дэлхийн Худалдааны Байгууллагын тухай хэлэлцээрийн 1С хавсралт дахь Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (v) “НҮБДЭЗК” гэх нэр томьёо нь 1982 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Монтего буланд байгуулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын Далайн эрх зүйн тухай конвенцийг хэлнэ;

(w) “ДХБ-ын тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь 1994 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Марракеш хотноо байгуулсан Дэлхийн Худалдааны Байгууллагыг байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийг хэлнэ.

1.3 дугаар зүйл

Ил тод байдал

1. Тал бүр өөрийн нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомж болон шүүхийн шийдвэр, түүнчлэн энэхүү хэлэлцээрт хамаарал бүхий аливаа асуудлын тухайд нэгдэн орсон олон улсын хэлэлцээрийг даруй нийтлэх, эсхүл ямар нэг байдлаар олон нийтэд нээлттэй болгоно.

2. Тал бүр 1 дүгээр хэсэгт заасан хууль тогтоомжийг хариуцаж байгаа эрх бүхий байгууллагын нэр, хаягийг олон нийтэд нээлттэй байлгана.

3. 1 дүгээр хэсэгт заасан асуудлын тухайд аль нэг Тал хүсэлт гаргавал нөгөө Тал нь тавьсан тодорхой асуултад боломжтой хугацаанд өөрийн боломжийн хэрээр англи хэлээр хариу өгч, мэдээллээр хангана.

4. Аль нэг Тал энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтэд онцгой нөлөө үзүүлэх хууль тогтоомжийг шинээр гаргах, эсхүл өөрчлөх тохиолдолд тухайн Тал онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдол болон дотоодын хуулийн хүрээнд эдгээр хууль тогтоомжийг нийтлэх, эсхүл олон нийтэд нээлттэй болгох болон тэдгээрийн хүчин төгөлдөр үйлчилж эхлэх хугацааны хооронд боломжит хугацаа олгох талаар чармайна.

1.4 дүгээр зүйл

Олон нийтийн санал авах журам

Тал бүр энэхүү хэлэлцээрт хамаарал бүхий аливаа асуудлаар олон нийтийн санал авах журмыг өөрийн хууль тогтоомжийн дагуу болон боломжийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1.5 дугаар зүйл

Захиргааны журам

1. Аль нэг Талын эрх бүхий байгууллага энэхүү хэлэлцээрт хамаарал бүхий, эсхүл түүний хэрэгжилтэд нөлөө үзүүлэхүйц захиргааны шийдвэр гаргуулахаар гаргасан этгээдийн өргөдлийг хүлээн авсан бол өөрийн хууль тогтоомжийн дагуу:

(a) өргөдлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн гэж үзэж, хүлээн авснаас хойш гарсан шийдвэрийн талаар өргөдөл гаргагчид боломжийн хугацаанд мэдээлэх ба чингэхдээ 3 дугаар хэсэгт заасны дагуу тогтоосон хугацааг харгалзан үзнэ;

(b) өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу өргөдлийн шийдвэрлэх явцын талаарх мэдээллийг боломжийн хугацаанд өгнө.

2. Талуудын эрх бүхий байгууллагууд 1 дүгээр хэсэгт заасан өргөдлийг хянан үзэх шалгуурыг өөрийн хууль тогтоомжийн дагуу тогтооно. Эрх бүхий байгууллагууд нь эдгээр шалгуурыг:

(a) аль болох тодорхой;

(b) тухайн Талд захиргааны онцгой хүндрэл учруулахаас бусад тохиолдолд олон нийтэд нээлттэй болгоно.

3. 1 дүгээр хэсэгт заасан өргөдлийг хянан үзэх зорилгоор Талуудын эрх бүхий байгууллага өөрийн хууль тогтоомжийн дагуу:

(a) өргөдлийг хүлээн авах болон түүний талаар шийдвэр гаргах хооронд стандарт хугацаа тогтоох талаар чармайна;

(b) дээрх хугацааг тогтоосон бол олон нийтэд нээлттэй болгоно.

4. Талуудын эрх бүхий байгууллага өөрийн хууль тогтоомжийн дагуу этгээдэд үүрэг хүлээлгэх, эсхүл тухайн этгээдийн хууль ёсны эрхийг хязгаарлах талаар эцсийн шийдвэр гаргахын өмнө тухайн этгээдийг дараахь зүйлээр хангахыг эрмэлзэнэ:

(a) боломжит мэдэгдэл түүний дотор арга хэмжээний төрөл, түүний үндэслэл болох хуулийн заалт болон арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүргэсэн баримтыг хамрах;

(b) өөрийн байр суурийг хамгаалах баримт, нотолгоог танилцуулах бодит боломж.

1.6 дугаар зүйл

Хянан үзэх ба давж заалдах

1. Тал бүр энэхүү хэлэлцээрт хамаарал бүхий асуудлаар захиргааны үйл ажиллагааг нэн даруй хянан үзэх, үндэслэлтэй гэж үзвэл засах зорилгоор шүүх, эсхүл журамтай байна. Эдгээр шүүх, эсхүл журам нь дээрх үйл ажиллагааг захиргааны хувьд хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагаас ангид, бие даасан байна.

2. Тал бүр ийм журам, шүүхийн ажиллагаанд оролцогчдыг дараахь эрхээр хангана:

- (a) өөрсийн байр суурийг дэмжих, эсхүл хамгаалах боломж;
- (b) нотлох баримт болон тэмдэглэлд үндэслэн шийдвэр гаргуулах.

3. Тал бүр өөрийн хууль тогтоомжийн дагуу давж заалдах, эсхүл цаашид хянан үзэх нөхцөлийн дагуу тухайн захиргааны үйл ажиллагаатай холбоотойгоор гарсан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллага хэрэгжүүлэх явдлыг хангана.

1.7 дугаар зүйл

Авлигын эсрэг арга хэмжээ

Тал бүр энэхүү хэлэлцээрт хамаарах асуудлаар өөрийн хууль тогтоомжийн дагуу төрийн албан хаагчдыг авлигаас сэргийлэх болон авлигатай тэмцэх зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

1.8 дугаар зүйл

Нууц мэдээлэл

1. Тал бүр энэхүү хэлэлцээрийн дагуу нөгөө Талын итгэл үзүүлж өгсөн мэдээллийн нууцлалыг өөрийн хууль тогтоомжийн дагуу хадгална.

2. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол нууц мэдээллийг задруулсны улмаас хууль тогтоомжоо хэрэгжүүлэхэд нь саад учруулах, эсхүл ямар нэг байдлаар нийтийн ашиг сонирхолд харшлах, эсхүл улсын болон хувийн тодорхой аж ахуйн нэгжийн хууль ёсны арилжааны ашиг сонирхолд хохирол учруулж болохуйц нууц мэдээлэл гаргаж өгөхийг энэхүү хэлэлцээрийн аль ч заалт аль нэг Талаас шаардахгүй.

1.9 дүгээр зүйл Татвар

1. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол хэлэлцээрийн заалтууд татварын аливаа арга хэмжээнд хамаарахгүй.

2. Энэхүү хэлэлцээр нь аль нэг Талын татварын аливаа конвенцоор хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй. Ийм конвенц энэхүү хэлэлцээрт үл нийцэх тохиолдолд нийцэхгүй байгаа хэмжээгээр тухайн конвенцийг дагаж мөрдөнө.

3. Энэхүү хэлэлцээрийн заалтууд нь татварын арга хэмжээнд хамаарах хэмжээгээр 1.3 болон 1.8 дугаар зүйлийг эдгээр татварын арга хэмжээнд хэрэглэнэ.

1.10 дугаар зүйл Үл хэрэглэх тохиолдол

1. 7, 8, 12 дугаар бүлгээс бусад бүлгийн хувьд болон энэхүү хэлэлцээрийн зорилгоор 1994 оны ТХЕХ-ийн 20, 21 дүгээр зүйл энэхүү хэлэлцээрийн нэгэн хэсэг болж, тэдгээрийг *mutatis mutandis* зарчмаар хэрэглэнэ.

2. 7, 8, 9, 10 дугаар бүлгийн зорилгоор ҮХЕХ-ийн 14, 14 bis дүгээр зүйлүүд энэхүү хэлэлцээрийн нэгэн хэсэг болж, тэдгээрийг *mutatis mutandis* зарчмаар хэрэглэнэ.

3. Талууд дараахь нөхцөл байдалтай холбоотой асуудлаар зөвлөлдөж болно:

- (a) эдийн засаг нь цөөн нэр төрлийн түүхий эдээс хамаарал бүхий Талын экспортын орлого эдгээр түүхий эдийн борлуулалт, эсхүл дэлхийн зах зээлийн үнэ буурснаас буурах;
- (b) аль нэг Тал өөрийн хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилгоор аливаа тодорхой үйлдвэрлэлийг байгуулахад дэмжлэг үзүүлэх шаардлага бий болсон.

Тайлбар: Энэ зүйлийн зорилгоор 1994 оны ТХЕХ-ийн 20 дугаар зүйлийн (b), ҮХЕХ-ийн 14 дүгээр зүйлийн (b) дэд хэсэг нь хүн, амьтан, ургамлын амьдрал, эсхүл эрүүл мэндийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээнд байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хамруулж ойлгоно. Түүнчлэн 1994 оны ТХЕХ-ийн 20 дугаар зүйлийн (g) дэд хэсэгт амьд болон амьгүй байгалийн шавхагдах нөөцийг хамгаалах арга хэмжээнд хамаарна.

1.11 дүгээр зүйл

Бусад хэлэлцээрт хамаарах нь

1. Талууд ДХБ-ын тухай хэлэлцээр, эсхүл Талуудын нэгдэн орсон аливаа бусад хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргээ дахин нотолж байна.

2. Энэхүү хэлэлцээр нь ДХБ-ын тухай хэлэлцээрт нийцэхгүй тохиолдолд нийцэхгүй байгаа хэмжээгээр ДХБ-ын тухай хэлэлцээрийг дагаж мөрдөнө.

3. Энэхүү хэлэлцээр нь ДХБ-ын тухай хэлэлцээрээс бусад Талуудын нэгдэн орсон аливаа бусад хэлэлцээрт нийцэхгүй тохиолдолд Талууд харилцан тааламжтай шийдэлд хүрэх зорилгоор олон улсын эрх зүйн нийтлэг зарчмыг харгалзан даруй зөвлөлдөнө.

1.12 дугаар зүйл

Хэрэгжүүлэх хэлэлцээр

Талуудын Засгийн газар энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор мэдээлэл болон журмыг тодорхойлсон хэлэлцээр (цаашид “Хэрэгжүүлэх хэлэлцээр” гэх)-ийг тусад нь байгуулах бөгөөд энэ нь энэхүү хэлэлцээрийн нэмэлт болно.

1.13 дугаар зүйл

Хамтарсан хороо

1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд Талууд Хамтарсан хороог үүгээр байгуулав.

2. Хамтарсан хороо нь дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэхүү хэлэлцээрийн хэрэгжилт болон үйл ажиллагааг судалж үзэх болон хянан шалгах, шаардлагатай бол Талуудад холбогдох зөвлөмж өгөх;
- (b) энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг авч үзэх, Талуудад зөвлөмж өгөх;
- (c) энэхүү хэлэлцээрийн дагуу байгуулсан бүх дэд хорооны үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, зохицуулах;
- (d) дараахь зүйлийг батлах:
 - (i) 2.20 болон 3.26 дугаар зүйлд тус тус дурдсан Барааны худалдааны талаарх Үйл ажиллагааны журам, Гарал үүслийн талаарх Үйл ажиллагааны журам;
 - (ii) шаардлагатай бусад шийдвэр;
- (e) Талуудын тохиролцсоны дагуу бусад чиг үүргийг гүйцэтгэх.

3. Хамтарсан хороо нь:

- (a) Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ;
- (b) 1.14 дүгээр зүйлд зааснаас бусад дэд хороо байгуулж болно;
- (c) өөрийн үүргийг дэд хороонд даалгаж болно.

4. Хамтарсан хороо нь өөрийн үйл ажиллагааны дүрэм болон журмыг тогтооно.

5. Хамтарсан хороо нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдөр анхны хуралдаанаа хийж, цаашид Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

1.14 дүгээр зүйл Дэд хороо

1. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдөр дараахь дэд хороог байгуулна:

- (a) 2.19 дүгээр зүйлд заасны дагуу Барааны худалдааны дэд хороо;
- (b) 3.25 дугаар зүйлд заасны дагуу Гарал үүслийн дүрмийн дэд хороо;
- (c) 4.8 дугаар зүйлд заасны дагуу Гаалийн үйл ажиллагааны болон худалдааг хөнгөвчлөх дэд хороо;
- (d) 5.6 дугаар зүйлд заасны дагуу Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний дэд хороо;
- (e) 6.9 дүгээр зүйлд заасны дагуу Техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмын дэд хороо;
- (f) 7.16 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний худалдааны дэд хороо;
- (g) 8.6 дугаар зүйлд заасны дагуу Хувь хүний шилжилт хөдөлгөөний дэд хороо;
- (h) 9.13 дугаар зүйлд заасны дагуу Цахим худалдааны дэд хороо;
- (i) 10.18 дугаар зүйлд заасны дагуу Хөрөнгө оруулалтын дэд хороо;
- (j) 12.18 дугаар зүйлд заасны дагуу Оюуны өмчийн дэд хороо;
- (k) 13.5 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагааны дэд хороо;
- (l) 14.2 дугаар зүйлд заасны дагуу Бизнесийн орчныг сайжруулах дэд хороо;
- (m) 15.4 дүгээр зүйлд заасны дагуу Хамтын ажиллагааны дэд хороо.

2. Дэд хороод нь 1 дэх хэсэгт дурьдсан холбогдох зүйлд тодорхойлсон чиг үүргийг гүйцэтгэнэ.

1.15 дугаар зүйл Харилцаа холбоо

Энэхүү хэлэлцээртэй холбоотой аливаа асуудлаарх харилцааг дэмжих зорилгоор Тал бүр харилцах этгээдийг томилно.

2 дугаар бүлэг Барааны худалдаа

1 дүгээр хэсэг Ерөнхий дүрэм

2.1 дүгээр зүйл Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор:

- (a) “хөдөө аж ахуйн тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь ДХБ-ын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (b) “демпингийн эсрэг арга хэмжээний тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь ДХБ-ын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь 1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйлийг хэрэгжүүлэх тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (c) “хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь ДХБ-ын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (d) “татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь ДХБ-ын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (e) “хоёр талын хамгаалалтын арга хэмжээ” гэх нэр томьёо нь 2.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэлнэ;
- (f) “гаалийн татвар” гэх нэр томьёо нь барааг импортлохтой холбоотойгоор ногдуулах гаалийн, эсхүл импортын аливаа татварыг хэлэх боловч дараахь зүйлийг хамруулахгүй:
 - (i) 1994 оны ТХЕХ-ийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нийцүүлэн ногдуулах дотоодын татвартай тэнцэх хураамж;

- (ii) аль нэг Талын хууль болон 1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйл, Демпингийн эсрэг арга хэмжээний тухай болон Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлэх демпингийн эсрэг, эсхүл саармагжуулах татвар;
- (iii) үзүүлсэн үйлчилгээний өртөгтэй дүйцэх шимтгэл, эсхүл хураамж;
- (g) “барааны гаалийн үнэлгээ” гэх нэр томьёо нь импортын бараанд гаалийн татварын хувь ногдуулах зорилгоор бараанд тогтоосон үнэлгээг хэлнэ;
- (h) “дотоодын үйлдвэрлэл” гэх нэр томьёо нь аль нэг Талд үйл ажиллагаа явуулж байгаа ижил, эсхүл шууд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэгчдийг, эсхүл ижил, эсхүл шууд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн нийлбэр нь тухайн бүтээгдэхүүний үндэсний үйлдвэрлэлийн үндсэн хэсгийг бүрдүүлж байгаа үйлдвэрлэгчдийг хэлнэ;
- (i) “хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээ” гэх нэр томьёо нь 2.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээг хэлнэ;
- (j) “ноцтой хохирол” гэх нэр томьёо нь дотоодын үйлдвэрлэлийн ерөнхий нөхцөл байдал илэрхий доройтохыг;
- (k) “ноцтой хохирол учруулах аюул” гэх нэр томьёо нь зөвхөн мэдэгдэл, таамаглал, цаашдын боломжоор бус, харин бодит баримтад үндэслэн тогтоосон ноцтой хохирол учруулах нь зайлшгүй гэдэг нь тодорхой байдлыг хэлнэ.

2.2 дугаар зүйл Барааны ангилал

Талууд хоорондын худалдаанд хамаарах барааны ангиллыг Уялдуулсан системтэй нийцүүлсэн байна.

2.3 дугаар зүйл Үндэсний нөхцөл

Тал бүр 1994 оны ТХЕХ-ийн 3 дугаар зүйлийн дагуу нөгөө Талын бараанд үндэсний нөхцөл олгох бөгөөд энэ зорилгоор 1994 оны ТХЕХ-ийн 3 дугаар зүйл *mutatis mutandis* зарчмаар энэхүү хэлэлцээрийн бүрэлдэхүүн хэсэг байна.

2.4 дүгээр зүйл Гаалийн татварыг тэглэх, эсхүл бууруулах

1. Энэхүү хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Тал бүр нөгөө Талын зохих гарал үүсэлтэй бараанд ногдуулах гаалийн татварыг 1 дүгээр хавсралт дахь жагсаалтын дагуу тэглэх, эсхүл бууруулна.

2. Аль нэг Тал хүсэлт гаргавал 1 дүгээр хавсралт дахь жагсаалтын дагуу Талуудын хэлэлцэхээр тохиролцсон гарал үүсэлтэй барааг зах зээлд нэвтрүүлэх нөхцөлийг сайжруулах зэрэг асуудлаар Талууд жагсаалтад заасан нөхцөлийн дагуу хэлэлцэнэ.

3. 1994 оны ТХЕХ-ийн 2 дугаар зүйлийн 1(b) дэд хэсэгт заасны дагуу Талуудын хооронд худалдаалж байгаа барааг импортлох, эсхүл импортлохтой холбоотойгоор ногдуулах татвар, эсхүл хураамжаас чөлөөлнө.

4. Энэ зүйлийн аль ч заалт нь нөгөө талын аливаа барааг импортлоход 2.1 дүгээр зүйлийн (f) (i) дэд хэсгээс (iii) хүртэл дурдсан дотоодын татвартай тэнцэх хураамж, демпингийн эсрэг, эсхүл саармагжуулах татвар, эсхүл бусад татвар, хураамжийг ямар ч үед ногдуулахад аль нэг Талд саад болохгүй.

5. Тодорхой бараанд ногдуулж байгаа үндэстний нэн тааламжтай тарифын хэмжээ 1 дэх хэсгийн дагуу нөгөө Талын гарал үүсэлтэй, тухайн ижил код бүхий бараанд ногдуулах тарифын хэмжээтэй тэнцэх, эсхүл түүнээс бага хэмжээтэй болох тохиолдолд Тал бүр хугацаа алдалгүйгээр ийнхүү тэглэсэн, эсхүл бууруулсан талаар нөгөө Талдаа мэдэгдэнэ.

6. Тодорхой бараанд ногдуулж буй гаалийн татварын хэмжээнд үндэстний нэн тааламжтай нөхцөл үйлчилсний дүнд татварын хэмжээ 1 дэх хэсэгт заасны дагуу ижил тарифын баганаар ангилагдсан гарал үүсэлтэй бараанд үйлчилж байгаа гаалийн татварын хэмжээнээс бага болсон тохиолдолд, Тал бүр тэрхүү гарал үүсэлтэй холбоотой бараанд бага хэмжээг нь хэрэглэнэ.

2.5 дугаар зүйл

Гаалийн үнэлгээ

Талуудын хооронд худалдаалж буй барааны гаалийн үнэлгээг тодорхойлох зорилгоор Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээрийн 1 дүгээр хэсгийг *mutatis mutandis* зарчмаар мөрдөнө.

2.6 дугаар зүйл

Экспортын татаас

Аль ч Тал ДХБ-ын тухай хэлэлцээрт үл нийцэх экспортын аливаа татаасыг Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн 1 дүгээр хавсралт дахь жагсаалт бүхий хөдөө аж ахуйн аливаа бараанд шинээр олгохгүй буюу хэрэгжүүлэхгүй.

2.7 дугаар зүйл

Импортын болон экспортын хязгаарлалт

1. Аль нэг Тал нөгөө Талын аливаа барааг импортлох, эсхүл нөгөө Талд экспортлох, эсхүл экспортлох зорилгоор худалдахад гаалийн татвараас бусад ДХБ-ын тухай хэлэлцээрийн холбогдох хэсгийн дагуу хүлээсэн үүрэгт үл нийцэх аливаа хориг, эсхүл хязгаарлалт шинээр тогтоохгүй буюу хэрэгжүүлэхгүй.

2. Талуудын тохиролцох барааны хувьд нөгөө Талаас импортлох, эсхүл экспортлохтой холбоотой ДХБ-ын хэлэлцээрийн заалтад нийцүүлсэн гаалийн татвараас бусад хориг, эсхүл хязгаарлалтыг Аль нэг Тал нэвтрүүлсэн тохиолдолд нөгөө Талын холбогдох хууль тогтоомжид нийцэхүйцээр, тийм хориг, эсхүл хязгаарлалтыг нэвтрүүлэхээс өмнө, эсхүл түүнээс хойш нэн даруй нэг Тал нөгөө Талдаа холбогдох мэдээллийг нээлттэй байлгах болон мэдээллэхийг эрмэлзэнэ. Хориг, хязгаарлалт тогтоосон Тал мэдээллийг хуваалцах нь нийтийн ашиг сонирхолд үл нийцнэ хэмээн үзсэн тохиолдолд энэ заалт хэрэгжихгүй.

Тайлбар: Энэ заалтыг хэрэгжүүлэхдээ аль нэг Тал нөгөө Талдаа хүргүүлэх мэдээллийг ДХБ-ын тухай хэлэлцээрийн холбогдох журмын дагуу хүргүүлж болно.

2 дугаар хэсэг Хамгаалалтын арга хэмжээ

2.8 дугаар зүйл Хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх нь

1. Энэ хэсгийн заалтыг хангахад аль нэг Тал нөгөө Талын гарал үүсэлтэй бараанд ногдуулж байгаа гаалийн татварыг 2.4 дүгээр зүйлийн дагуу тэглэх, эсхүл бууруулсны үр дүнд тэрхүү барааны импорт нь тухайн Талын дотоодын үйлдвэрлэлд үнэмлэхүй, эсхүл харьцангуй тоо хэмжээгээр нэмэгдэж, түүнчлэн тэрхүү гарал үүсэлтэй барааны импорт дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулах, эсхүл ийм хохирол учруулах аюулыг бий болгох нөхцөлд хоёр талын хамгаалалтын арга хэмжээг дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учрахаас сэргийлэх, эсхүл учирсан хохирлыг нөхөх, улмаар зохицуулалтыг хялбарчлахад зайлшгүй шаардлагатай хамгийн бага хэмжээтэй хэрэгжүүлж болно.

2. Аль нэг Тал хоёр талын хамгаалалтын арга хэмжээг:

- (a) энэхүү бүлэгт заасны дагуу гарал үүсэлтэй бараанд ногдуулж байгаа гаалийн татварыг цаашид бууруулахгүй байх;
- (b) гарал үүсэлтэй бараанд ногдуулж байгаа гаалийн татварын хэмжээг дараагийн аль багаас нь илүү гаргахгүйгээр нэмэгдүүлэх:
 - (i) хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх өдөр үйлчилж буй үндэстний нэн тааламжтай тариф;
 - (ii) энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрийн өмнөх өдөр үйлчилж буй үндэстний нэн тааламжтай тариф.

2.9 дүгээр зүйл

Нөхцөл болон хязгаарлалт

1. Ноцтой хохирлоос сэргийлэх, эсхүл ийм хохирлыг багасгах болон зохицуулалтыг хялбарчлахад шаардлагатай хэмжээ, хугацаанд хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд хоёр талын хамгаалалтын арга хэмжээ авахгүй ба тухайн хугацаа 3 жилээс хэтрэхгүй байна. Гэвч, нэн онцгой нөхцөлд хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг сунгаж болох бөгөөд хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх нийт хугацаа сунгасан хугацааг оролцуулан 6 жилээс хэтрэхгүй байна. Хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа 1 жилээс илүү байх нөхцөлд шаардлагатай зохицуулалтыг хийх зорилгоор уг арга хэмжээг хэрэгжүүлж байгаа Тал нь арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд түүнийг тогтмол хугацаагаар аажмаар чөлөөлнө.

2. Тодорхой гарал үүсэлтэй барааны импортод хоёр талын хамгаалалтын арга хэмжээг тухайн бараанд хэрэгжүүлсэн хоёр талын хамгаалалтын арга хэмжээний хугацаатай тэнцэх, эсхүл 1 жилийн хугацаанд буюу эдгээрийн аль урт хугацаанд нь дахин хэрэгжүүлэхгүй.

3. Хоёр талын хамгаалалтын арга хэмжээ дуусахад гарал үүсэлтэй тухайн бараанд ногдуулах гаалийн татварын хэмжээ хоёр талын хамгаалалтын арга хэмжээ аваагүй тохиолдолд үйлчлэх хэмжээ байна.

4. Экспортлогч Талын гарал үүсэлтэй бараа импортлогч Талын тухайн барааны импортод 3 хувиас хэтрэхгүй хувийг эзэлж байвал хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхгүй.

5. Талууд хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг тэнцвэртэй, шаардлагатай цаг үед нь, ил тод болон үр дүнтэй байдлаар хэрэгжүүлнэ.

2.10 дугаар зүйл

Мөрдөн шалгалт

1. Талууд хоёр талын хамгаалалтын арга хэмжээг зөвхөн эрх бүхий байгууллагаас Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээрийн 3 болон 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу мөрдөн шалгалт хийсний дараа хэрэгжүүлнэ.

2. Онцгой нөхцөл байдлаас бусад тохиолдолд 1 дэх хэсэгт дурдсан мөрдөн шалгалт эхэлсэн өдрөөс хойш 1 жилийн дотор дуусгах ба ямар ч тохиолдолд 18 сараас хэтрүүлэхгүй.

2.11 дүгээр зүйл Мэдэгдэх болон зөвлөлдөх

1. Аль нэг Тал:

- (a) 2.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан ноцтой хохирол, эсхүл ноцтой хохирол үүсэх аюул, үүний шалтгаантай холбоотой мөрдөн шалгалтыг эхлүүлэх;
- (b) хоёр талын хамгаалалтын арга хэмжээ авах, эсхүл сунгах болсон тухай шийдвэрийн талаарх мэдээллийг бичгээр нөгөө Талд шуурхай мэдэгдэнэ.

2. 1 дэх хэсэгт дурдсан бичгээр мэдээлэл өгөх Тал нь нөгөө Талдаа дараахийг багтаасан холбогдох бүх мэдээллийг хүргүүлнэ.

- (a) 1(a) дэд хэсэгт дурдсан бичгээр өгөх мэдээлэлд мөрдөн шалгалт хийх шалтгаан, мөрдөн шалгалтад хамруулах зохих гарал үүсэлтэй барааны тодорхой тайлбар, Уялдуулсан систем дахь код, мөрдөн шалгалт хийх хугацаа болон эхлүүлэх огноо;
- (b) 1(b) дэд хэсэгт дурдсан бичгээр өгөх мэдээлэлд зохих гарал үүсэлтэй барааны импортын хэт өсөлтийн улмаас үүсэх ноцтой хохирол, эсхүл ийм хохирол учруулах аюулын талаар нотлох баримт, хоёр талын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх зохих гарал үүсэлтэй барааны тодорхой тайлбар болон Уялдуулсан систем дахь код, хэрэгжүүлэх хоёр талын хамгаалалтын арга хэмжээний талаарх тодорхой тайлбар, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх огноо болон үргэлжлэх хугацаа зэрэг орно.

3. Хоёр талын хамгаалалтын арга хэмжээ авах, эсхүл сунгах санал гаргасан Тал 2.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан мөрдөн шалгалтын үр дүнд гарах мэдээллийг үнэлж дүгнэх, хоёр талын хамгаалалтын арга хэмжээний талаар санал солилцох, 2.12 дугаар зүйлд заасан нөхөн олговрын талаар тохиролцох зорилгоор нөгөө Талтай урьдчилан зөвлөлдөх боломжоор хангана.

2.12 дугаар зүйл Нөхөн олговор

1. Хоёр талын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх, эсхүл сунгах санал гаргаж байгаа Тал нь худалдааны нөхөн олговор олгох арга замын талаар тохиролцож болно. Энэхүү нөхөн олговор хоёр талын хамгаалалтын арга хэмжээний үр дүнд ногдуулах гаалийн нэмэлт татварын хэмжээтэй бодит байдлаар тэнцүү байна.

2. Талууд 2.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн дагуу зөвлөлдөөн эхэлснээс хойш 30 хоногийн дотор нөхөн олговрын талаар тохиролцоонд хүрч чадахгүй тохиолдолд хоёр талын хамгаалалтын арга хэмжээнд хамрагдаж байгаа барааны гарал үүслийн Тал энэхүү хэлэлцээрийн дагуу гаалийн татварын хөнгөлөлтийг хоёр талын хамгаалалтын арга хэмжээтэй бодитоор тэнцэхүйц хэмжээгээр түдгэлзүүлж болно. Ийнхүү түдгэлзүүлэх эрх эдэлж буй Тал нь гаалийн татварын хөнгөлөлтийг гагцхүү тэнцэхүйц нөлөөнд хүрэхэд шаардлагатай хамгийн бага хугацаагаар болон гагцхүү хоёр талын хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаагаар түдгэлзүүлж болно.

2.13 дугаар зүйл Хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээ

1. Хоёр талын хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэх хугацааг удаашруулах нь хор уршгийг засахад хүнд байдал үүсгэх онцгой нөхцөл байдалд аль нэг Тал хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээг хэрэгжүүлж болно. Арга хэмжээг 2.8 дугаар зүйлийн 2(a), эсхүл 2(b) дэд хэсэгт заасан хэлбэрт нийцүүлэх ба нөгөө Талын зохих гарал үүсэлтэй барааны импортын өсөлт дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан буюу учруулах аюулын гарцаагүй нотолгоог урьдчилан тодорхойлсоны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

2. Аль нэг Тал хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээ хэрэгжүүлэхээс өмнө нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ. Хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээг хэрэгжүүлж эхэлмэгц арга хэмжээний талаар Талууд зөвлөлдөнө.

3. Хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээ 200 хоногоос хэтрэхгүй. Энэ хугацаанд 2.10 дугаар зүйлд заасан зохих шаардлагыг биелүүлнэ. Хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг 2.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан хугацаанд оруулж тооцно.

4. Хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээг 2.9 дүгээр зүйлийн 3-аас 5 дахь хэсэгт *mutatis mutandis* зарчмаар нийцүүлнэ. 2.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөрдөн шалгалтаар нөгөө Талын гарал үүсэлтэй барааны импорт дотоодын үйлдвэрлэлд ноцтой хохирол учруулсан, эсхүл учруулах аюултай эсэх нь тогтоогдоогүй тохиолдолд хоёр талын хамгаалалтын түр арга хэмжээний үр дүнд ногдуулсан гаалийн татварыг нөхөн олгоно.

2.14 дүгээр зүйл
ДХБ-ын тухай хэлэлцээрийн дагуу хэрэгжүүлэх хамгаалалтын
арга хэмжээтэй хамаарах нь

1. Аль нэг Тал:

- (a) 1994 оны ТХЕХ-ийн 19 дүгээр зүйл болон Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр;
- (b) хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн дагуу нөгөө Талын зохих гарал үүсэлтэй бараанд хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэхэд энэ хэсэг саад болохгүй.

2. 1994 оны ТХЕХ-ийн 19 дүгээр зүйл болон Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр, эсхүл Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн дагуу аль нэг Тал нөгөө Талын зохих гарал үүсэлтэй барааны импортод хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж байгаа бол тэрхүү импортод энэ хэсгийн дагуу хоёр талын хамгаалалтын арга хэмжээг нэг зэрэг хэрэгжүүлэхгүй.

3. Аль нэг Тал нөгөө Талын зохих гарал үүсэлтэй барааны импортод энэхүү бүлгийн дагуу хоёр талын хамгаалалтын арга хэмжээг 1994 оны ТХЕХ-ийн 19 дүгээр зүйл болон Хамгаалалтын арга хэмжээний тухай хэлэлцээр, эсхүл Хөдөө аж ахуйн тухай хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн дагуу хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээнээс өмнө хэрэгжүүлсэн бол энэ хамгаалалтын арга хэмжээг хоёр талын хамгаалалтын арга хэмжээний нийт хугацаанд оруулж тооцно. Энэхүү хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж дуусмагц тухайн Тал үлдсэн хугацаанд тэрхүү импортод хоёр талын хамгаалалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлж болно.

2.15 дугаар зүйл Харилцаа холбоо

2.11 дүгээр зүйлийн 1, 2.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан бичгээр өгөх мэдэгдэл болон энэ хэсгийн дагуу Талууд хоорондын аливаа харилцаа холбоог англи хэлээр гүйцэтгэнэ.

2.16 дугаар зүйл Хяналт

Талууд энэ хэсгийн заалтыг шаардлагатай бол энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдрөөс хойш 10 жилийн дараа хянаж үзнэ.

3 дугаар хэсэг Бусад заалт

2.17 дугаар зүйл Демпингийн эсрэг болон саармагжуулах арга хэмжээ

Энэхүү бүлгийг 1994 оны ТХЕХ-ийн 6 дугаар зүйл, Демпингийн эсрэг арга хэмжээний тухай, Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай хэлэлцээрийн дагуу аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд аль нэг Талд саад болохоор тайлбарлахгүй.

2.18 дугаар зүйл Төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор авах арга хэмжээ

1. Төлбөрийн тэнцлийг хангах зорилгоор аливаа арга хэмжээ авахад аль нэг Талд саад болохоор энэхүү Бүлгийг тайлбарлахгүй. Аль нэг Тал ийм арга хэмжээ авахдаа 1994 оны ТХЕХ-ийн 12 дугаар зүйл болон ДХБ-ын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь ТХЕХ-ийн төлбөрийн тэнцэлтэй холбогдсон заалтын тухай харилцан ойлголцох барим бичигт заасан нөхцөлийн дагуу хэрэгжүүлнэ.

2. Аль нэг Тал Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн зүйлд нийцүүлэн валютын хяналт, эсхүл хязгаарлалтын арга хэмжээ авахад энэ бүлгийн аль ч заалт саад болохгүй.

2.19 дүгээр зүйл

Барааны худалдааны дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд Барааны худалдааны дэд хороо (цаашид энэ зүйлд “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо нь дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэхүү бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) талуудын тохиролцсоны дагуу энэ бүлэгтэй холбоотой аливаа бусад асуудлыг авч үзэх;
- (c) 2.20 дугаар зүйлд заасан Барааны худалдаанд хамаарах үйл ажиллагааны журмыг хянах, шаардлагатай бол Хамтарсан хороонд зохих зөвлөмжийг өгөх;
- (d) дэд хорооны үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;
- (e) хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

2.20 дугаар зүйл

Барааны худалдааны талаарх үйл ажиллагааны журам

Хамтарсан хороо нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр Талуудын холбогдох байгууллагууд энэхүү бүлгийн дагуу үүргээ биелүүлэхтэй холбоотой тодорхой дэгийг тогтоосон Барааны худалдааны талаарх үйл ажиллагааны журмыг батална.

2.21 дүгээр зүйл

Экспорттой холбоотой хамтын ажиллагаа

Талууд экспортлогч Талын экспортолж байгаа хуучин автомашины талаар 15 дугаар бүлэгт заасны дагуу хамтран ажиллана.

3 дугаар бүлэг Гарал үүслийн дүрэм

3.1 дүгээр зүйл Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор:

- (a) “эрх бүхий төрийн байгууллага” гэх нэр томъёо нь Тал бүрийн хууль тогтоомжийн дагуу гарал үүслийн гэрчилгээ олгох үүрэг бүхий, эсхүл тийм гэрчилгээ олгох нэгж буюу байгууллагыг томилох үүрэг бүхий эрх бүхий байгууллагыг хэлнэ;
- (b) “экспортлогч” гэх нэр томъёо нь экспортлогч Талаас бараа экспортолж байгаа экспортлогч Талд байршилтай этгээдийг хэлнэ;
- (c) “нэг Талын үйлдвэр-хөлөг онгоц”, эсхүл “нэг Талын далайн хөлөг онгоц” гэх нэр томъёо нь дараахь нөхцөлийг хангасан үйлдвэр-хөлөг онгоц, эсхүл далайн хөлөг онгоцыг хэлнэ:
 - (i) тухайн Талд бүртгэлтэй;
 - (ii) тухайн Талын далбааг мандуулсан;
 - (iii) дараахь нөхцөлийн аль нэгийг хангасан:
 - (A) тэдгээрийн хамгийн багадаа 50 хувь нь тухайн Талуудын иргэдийн өмчлөлд байдаг;
 - (B) тэдгээр нь аль нэг Талд төвтэй, мөн тэнд үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг, түүнчлэн Тал бус улсад бүртгэлтэй аливаа тэнгисийн хөлөг, эсхүл усан онгоц өмчилдөггүй хуулийн этгээдийн өмчлөлд байдаг;
- (d) “аль нэг Талын зохих гарал үүсэл орлох бараа” буюу “аль нэг Талын зохих гарал үүсэл орлох материал” гэх нэр томъёо нь арилжааны зориулалтаараа бие биенээ орлох, тэдгээрийн мөн чанар нь үндсэндээ адилхан, аль нэг Талын гарал үүсэлтэй бараа, эсхүл материалын аль тохирохыг хэлнэ;

- (e) “нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд” гэх нэр томъёо нь тодорхой хугацаагаар тасалбар болгон эдийн засгийн эх үүсвэр, өр төлбөрийг актив, пассиваар бүртгэх, түүнд гарч буй өөрчлөлтийг хэрхэн хэмжих болон тайлагнах, ямар мэдээллийг хэрхэн толилуулах болон санхүүгийн тайланг бэлтгэх тал дээр байгууллагын хүрээнд харилцан хүлээн зөвшөөрөгдсөн болон бодитоор батлагдсан зарчмыг хэлнэ. Эдгээр стандарт нь нийтээр дагаж мөрдөх ерөнхий зарчим, түүнчлэн нарийвчилсан практик хэрэглээ болон хэмжих аргачлал байж болно;
- (f) “импортлогч” гэх нэр томъёо нь импортлогч Тал руу бараа импортолж байгаа этгээдийг хэлнэ.
- (g) “туслах материал” гэх нэр томъёо нь өөр бараа үйлдвэрлэх, турших, эсхүл шалгахад ашигласан, гэхдээ тухайн бараанд биет хэлбэрээр шингээгүй (түүний бүрдэл хэсэг болоогүй) барааг, эсхүл өөр бараа үйлдвэрлэхтэй холбогдуулан барилга байгууламжийн засварын ажилд, эсхүл тоног төхөөрөмж ажиллуулахад ашигласан барааг, түүний дотор дараахь зүйлсийг хэлнэ:
- (i) түлш болон эрчим хүч;
 - (ii) багаж хэрэгсэл, хэв болон цутгуур;
 - (iii) барилга байгууламжийн болон тоног төхөөрөмжийн засварын ажилд ашигласан сэлбэг хэрэгсэл болон бараа;
 - (iv) үйлдвэрлэлийн явцад ашигласан, эсхүл тоног төхөөрөмж ажиллуулахад болон барилга байгууламжид ашигласан тос, тослох материал, хольц болон бусад бараа;
 - (v) бээлий, хамгаалалтын нүдний шил, гутал, хувцас, аюулгүй ажиллагааны тоног хэрэгсэл болон сэлбэг;
 - (vi) барааг турших, эсхүл шалгах зориулалтаар ашигласан тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэл болон сэлбэг;
 - (vii) идэвхжүүлэгч (катализатор) болон уусгагч (бодис);
 - (viii) өөр бараанд биет хэлбэрээр шингээгүй, гэхдээ тухайн барааг үйлдвэрлэхэд түүнийг ашигласан явдал тухайн үйлдвэрлэлийн нэг дамжлага хэсэг болохыг нотлон харуулж чадах аливаа бусад бараа;

- (h) “материал” гэх нэр томьёо нь өөр бараа үйлдвэрлэхэд ашигласан барааг хэлнэ;
- (i) “зохих гарал үүсэлгүй материал” гэх нэр томьёо нь энэ бүлэгт заасан гарал үүслийн шаардлагыг хангаагүй материалыг хэлнэ;
- (j) “зохих гарал үүсэлтэй материал” гэх нэр томьёо нь энэ бүлэгт заасан гарал үүслийн шаардлагыг хангасан материалыг хэлнэ;
- (k) “бараа тээвэрлэх болон ачих зориулалттай савлагааны (баглаа боодлын) материал болон хайрцаг сав” гэх нэр томьёо нь тээвэрлэлтийн явцад барааг хамгаалах зорилгоор ашигладаг, 3.13 дугаар зүйлд заасан жижиглэн худалдах барааны савлагааны (баглаа боодлын) материал болон хайрцаг савнаас бусад барааг хэлнэ;
- (l) “тарифын хөнгөлөлт” гэх нэр томьёо нь экспортлогч Талын гарал үүсэлтэй бараанд 2.4 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дагуу хамаарах гаалийн татварын хувь хэмжээг хэлнэ;
- (m) “үйлдвэрлэгч” гэх нэр томьёо нь бараа буюу материалын үйлдвэрлэл эрхэлдэг этгээдийг хэлнэ;
- (n) “үйлдвэрлэл” гэх нэр томьёо нь бараа гаргаж авах аргыг, түүний дотор үйлдвэрлэх, угсрах, боловсруулах, өсгөх, ургуулах, үржүүлэх, ашигт малтмал олборлох, баяжуулах, ургац хураах, загас агнах, урхи тавих, түүх буюу цуглуулах, хураах, ан агнах болон амьдаар нь барихыг хэлнэ.

3.2 дугаар зүйл **Зохих гарал үүсэлтэй бараа**

Энэ бүлэгт өөрөөр заагаагүй бол аливаа нэг бараа дараахь тохиолдолд аль нэг Талын зохих гарал үүсэлтэй бараа байх шаардлагыг хангана:

- (a) тухайн бараа 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн Талд бүхэлд нь гаргаж авсан, эсхүл бүрэн үйлдвэрлэгдсэн;
- (b) тухайн барааг бүхэлд нь гагцхүү холбогдох Талын зохих гарал үүсэлтэй материалаар үйлдвэрлэсэн байх;

- (с) тухайн бараа 2 дугаар хавсралтад заасан бүтээгдэхүүний тусгай дүрэм (тарифын ангилал өөрчлөгдөх, өртгийн агууламжийн шаардлага хангах, эсхүл үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын тодорхой технологи ашигласан байх)-ийн шаардлагыг хангаж байгаа, мөн хэрэв энэхүү бүлгийн холбогдох бусад бүх шаардлагыг хангаж тухайн барааг зохих гарал үүсэлгүй материалаар холбогдох Талд бүхэлд нь үйлдвэрлэсэн.

3.3 дугаар зүйл

Бүрэн гарал үүсэлтэй бараа

3.2 дугаар зүйлийн (а) дэд хэсгийн зорилгоор дараахь барааг аль нэг Талд бүхэлд нь гаргаж авсан, эсхүл бүрэн үйлдвэрлэгдсэн гэж үзнэ:

- (а) тухайн Талд төрсөн болон өсч бойжсон амьд амьтан;
- (b) тухайн Талд ан агнах, урхи тавих, загас агнах, цуглуулах, эсхүл амьдаар нь барих замаар олж авсан амьтан;
- (с) тухайн Талд байгаа амьд амьтнаас гаргаж авсан бараа;
- (d) тухайн Талд хураасан, түүсэн, эсхүл цуглуулсан ургамал болон ургамлын гаралтай бүтээгдэхүүн;
- (e) тухайн Талд олборлосон буюу баяжуулсан, (а)-аас (d) дэд хэсэгт үл хамаарах эрдэс бүтээгдэхүүн болон байгалийн тогтоцтой бусад бодис;
- (f) тухайн Талын харьяа тэнгисээс гадна орших далай, тэнгисийн уснаас тухайн Талын хөлөг онгоцоор барьсан загас агнуурын бараа болон бусад бараа;
- (g) тухайн Талын харьяа тэнгисээс гадна орших тухайн Талын үйлдвэр-хөлөг онгоцон дээр (f) дэд хэсэгт хамаарах бараагаар үйлдвэрлэсэн бараа;
- (h) тухайн Тал НҮБДЭЗК-ийн холбогдох заалтын дагуу тухайн Талын харьяа тэнгисээс гадна орших далай, тэнгисийн ёроол буюу хөрснөөс олборлолт хийх эрхтэй байх тохиолдолд тэрхүү далай, тэнгисийн ёроол буюу хөрснөөс гаргаж авсан бараа;
- (i) тухайн Талд цуглуулсан, тухайн Талд анхны зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, сэргээх буюу засварлах ч боломжгүй болсон бөгөөд зөвхөн устгах, эсхүл эд анги буюу түүхий эд болгоход тохиромжтой бараа;

- (j) тухайн Талд явагдсан үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын үйл ажиллагааны үр дүнд, эсхүл хэрэглээний явцад бий болсон бөгөөд зөвхөн устгах, эсхүл эд анги буюу түүхий эд болгон ашиглахад тохиромжтой хаягдал буюу хог;
- (k) анхны зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон, сэргээх буюу засварлах ч боломжгүй болсон эд зүйлээр тухайн Талд сэргээн засварласан эд анги буюу түүхий эд;
- (l) зөвхөн (a)-аас (k) дэд хэсэгт заасан бараанаас гаргаж авсан буюу түүгээр үйлдвэрлэсэн бараа.

3.4 дүгээр зүйл Өртгийн агууламжийн шаардлага

1.3.2 дугаар зүйлийн (c) дэд хэсгийн зорилгоор, аливаа нэг бараа өртгийн агууламжийн шаардлага хангасан эсэхийг дараахь аргын аль нэгээр тооцно:

- (a) зохих гарал үүсэлгүй материалын өртөгт суурилсан арга (“Хасах арга”)

$$\Theta\text{АШ} = \frac{\text{ФОБ үнэ} - \text{ЗГҮ-гүй МӨ}}{\text{ФОБ үнэ}} \times 100$$

- (b) зохих гарал үүсэлтэй материалын өртөгт суурилсан арга (“Нэмэх арга”)

$$\Theta\text{АШ} = \frac{\text{ЗГҮ-тэй МӨ} + \text{Ажлын шууд зардал} + \text{Нэмэгдэл шууд зардал} + \text{Ашиг}}{\text{ФОБ үнэ}} \times 100$$

Үүнд:

ӨАШ гэдэг нь аливаа нэг барааны өртгийн агууламжийн шаардлага, хувиар илэрхийлэгдсэн болно;

ФОБ үнэ гэдэг нь, 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд, тээврийн төрлөөс үл хамааран, тухайн барааг худалдан авагчаас тухайн барааг худалдагчид төлөх тухайн барааг (тээврийн хэрэгслийн) тавцан дээр гаргаад чөлөөлөгдөх нөхцөлийн үнэ болно. Үүнд тухайн барааг экспортлох үед хасагдсан, чөлөөлсөн, эсхүл буцаан олгосон дотоодын аливаа онцгой албан татвар хамаарахгүй;

ЗГҮ-гүй МӨ гэдэг нь тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан, зохих гарал үүсэлгүй материалын өртөг болно;

ЗГҮ-тэй МӨ гэдэг нь тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан, зохих гарал үүсэлтэй материалын өртөг болно.

Тайлбар: Аливаа нэг бараа өртгийн агууламжийн шаардлага хангасан эсэхийг тооцох зорилгоор экспортлогч Талын Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг мөрдөнө.

2. 1 дэх хэсэгт дурдсан ФОБ үнэ нь дараахь үнэ байна:

- (a) хэрэв аливаа нэг барааны ФОБ үнэ байгаа боловч тэр нь тодорхой бус бөгөөд тогтоох боломжгүй бол тухайн бараанд зориулж худалдан авагчаас тухайн барааг үйлдвэрлэгчид төлсөн болохыг анх тогтоосон үнэд залруулга хийсэн үнэ;
- (b) хэрэв аливаа нэг барааны ФОБ үнэ байхгүй бол Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээрийн 1-8 дугаар зүйлийн дагуу тодорхойлсон үнэ.

3. Аливаа нэг бараа өртгийн агууламжийн шаардлага хангасан эсэхийг 1 дэх хэсгийн дагуу тооцох зорилгоор, тухайн барааг аль нэг Талд үйлдвэрлэхэд ашигласан материалын өртөг нь:

- (a) Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээрийн дагуу тодорхойлогдох бөгөөд түүнд тухайн материалыг холбогдох барааны үйлдвэрлэгч байршиж буй Талын импортын боомт хүртэл тээвэрлэхэд гарсан тээврийн зардал, мөн хэрэгцээтэй гэж үзвэл даатгалын хураамж, баглаа боодлын болон бусад бүх зардал багтсан байна;

- (b) хэрэв уг өртөг нь тодорхой бус бөгөөд тогтоох боломжгүй бол уг материалд зориулж тухайн Талд төлсөн болохыг анх тогтоосон үнэ өртөг нь тодорхой бус бөгөөд тогтоох боломжгүй бол уг агуулахаас холбогдох үйлдвэрлэгчийн байршиж буй газар хүртэл тээвэрлэхэд тухайн Талд гарсан тээврийн, даатгалын болон баглаа боодлын зэрэг бүх зардал, мөн тухайн Талд гарсан болох нь тодорхой бөгөөд тогтоож болох аливаа бусад зардлыг хасч болно.

4. Аливаа нэг бараа аль нэг Талын зохих гарал үүсэлтэй бараа болохыг тогтоохын тулд тухайн бараа өртгийн агууламжийн шаардлага хангасан эсэхийг тооцох зорилгоор:

- (a) тухайн барааны 1(a) дэд хэсэгт заасан ЗГҮ-гүй МӨ-т тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан, холбогдох Талын зохих гарал үүсэлтэй материалыг үйлдвэрлэхэд ашигласан зохих гарал үүсэлгүй материалын өртгийг тооцохгүй;
- (b) тухайн барааны 1(b) дэд хэсэгт заасан ЗГҮ-тэй МӨ-т тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан, холбогдох Талын зохих гарал үүсэлтэй материалыг үйлдвэрлэхэд ашигласан зохих гарал үүсэлгүй материалын өртгийг тооцно.

5. 2(b) болон 3(a) дэд хэсгийн зорилгоор, аливаа нэг бараа эсхүл аливаа нэг материалын өртгийг тодорхойлох үүднээс Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээрийг хэрэглэхэд дотоодын хэлцэлүүд, эсхүл тухайн бараа буюу материалд хамаарах хэлцэл байхгүй тохиолдлуудыг авч үзэхдээ Гаалийн үнэлгээний тухай хэлэлцээрийг *mutatis mutandis* зарчмын дагуу хэрэглэнэ.

3.5 дугаар зүйл **Нийлмэл гарал үүсэл**

Аливаа бараа аль нэг Талын зохих гарал үүсэлтэй бараа болох эсэхийг тогтоох зорилгоор:

- (a) аль нэг Талын зохих гарал үүсэлтэй барааг нөгөө Тал бараа үйлдвэрлэхэд материал байдлаар ашигласан тохиолдолд уг материалыг бараа үйлдвэрлэхдээ материал хэлбэрээр ашиглаж буй талын зохих гарал үүсэлтэй гэж үзэж болно;

(b) аль нэг Талд явагдсан үйлдвэрлэлийг нөгөө Талд явагдсан үйлдвэрлэл гэж үзэж болно;

(c) тухайн Талд, эсхүл нөгөө Талд нэг буюу хэд хэдэн үйлдвэрлэгчийн олон төрлийн шат дамжлага дамжсан үйлдвэрлэлийг, хэрэв холбогдох барааг зохих гарал үүсэлгүй материалаар үйлдвэрлэсэн бол харгалзан үзэж болно.

уг барааны үйлдвэрлэлийн эцсийн үйл ажиллагаа экспортлогч Талд явагдсан байхаас гадна уг үйлдвэрлэлийн ажиллагаа нь 3.7 дугаар зүйлд заасан үйл ажиллагаанаас гадна үйлдвэрлэлийн ажиллагаа хийгдсэн тохиолдолд.

3.6 дугаар зүйл

De Minimis (Үл тооцох хувь)

1.2 дугаар хавсралтад заасан бүтээгдэхүүний тусгай дүрмийг хэрэглэхийн тулд, аливаа нэг бараа үйлдвэрлэхэд ашигласан, тухайн бараанд хамаарах дүрэмд үл нийцэх, зохих гарал үүсэлгүй материалыг, уг материал нийтдээ холбогдох барааны үнэ, жин, эсхүл эзлэхүүний тодорхой хувиас хэтрээгүй бөгөөд тухайн бараанд хамаарах бүтээгдэхүүний тусгай дүрэмд тийм хувь заасан байх тохиолдолд, үл тооцно.

2.1 дэх хэсэг зохих гарал үүсэлгүй тухайн материал гарал үүслийг нь энэ зүйлийн дагуу тодорхойлж байгаа барааны мөрнөөс өөр мөрөнд заагдсан байхаас бусад тохиолдолд Уялдуулсан системийн 1-ээс 24 дүгээр бүлэгт заасан аливаа барааг үйлдвэрлэхэд ашигласан зохих гарал үүсэлгүй материалд хамаарахгүй.

3.7 дугаар зүйл

Үл хамаарах ажиллагаа

1. Аливаа барааг дараахь ердийн шалтгаанаар аль нэг Талын зохих гарал үүсэлтэй бараа гэж үзэхгүй:

(a) тээвэрлэлт болон хадгалалтын явцад бүтээгдэхүүний хэвийн байдлыг хангах ажиллагаа (хатаах, хөлдөөх, давсны уусмалд хадгалах зэрэг) болон тэдгээртэй адилтгах бусад ажиллагаа;

(b) сав, баглаа боодлыг өөрчлөх, мөн сав боодлыг задалж салгах болон нэгтгэх;

(c) задлах (задаргаа хийх);

- (d) шил, авдар, хайрцагт савлах болон тэдгээртэй адилтгах энгийн үйл ажиллагаа;
- (e) Уялдуулсан системийн ерөнхий тайлбар дүрмийн 2(а) дүрмийн дагуу аливаа бараа гэж ангилагдах эд анги болон бүрдэл хэсгүүдийг цуглуулж бөөгнүүлэх;
- (f) олон төрлийн барааг зүгээр хольж нийлүүлэн иж бүрдэл болгох;
- (g) (а)–аас (f) дэд хэсэгт дурдсан ажиллагааг аливаа байдлаар хослуулах.

2. 1 дэх хэсэг нь 2 дугаар хавсралтад заасан бүтээгдэхүүний тусгай дүрмээс давуу хүчинтэй байна.

3.8 дугаар зүйл Тээвэрлэлтийн шалгуур

1. Нөгөө Талын зохих гарал үүсэлтэй барааг дараахь тохиолдолд тээвэрлэлтийн шалгуур хангасанд тооцно:

- (a) нөгөө Талаас шууд тээвэрлэсэн;
- (b) энэхүү хэлэлцээрийн оролцогч бус нэг буюу хэд хэдэн улсаар дамжуулан өнгөрүүлэх, эсхүл тэнд байгаа агуулахад түр хадгалах зорилгоор тэдгээр улсаар дамжуулан тээвэрлэсэн, ингэхдээ тухайн барааг буулгах, дахин ачих, мөн түүний хэвийн байдлыг хангах аливаа бусад ажиллагаанаас өөр ажиллагаа хийгдээгүй байх.

2. Хэрэв нөгөө Талын зохих гарал үүсэлтэй бараа 1 дэх хэсэгт заасан тээвэрлэлтийн шалгуурыг хангаагүй бол тухайн барааг нөгөө Талын зохих гарал үүсэлтэй бараа гэж үзэхгүй.

3.9 дүгээр зүйл Угсраагүй буюу задалсан бараа

1. Хэрэв аливаа бараа 3.2-оос 3.7 дугаар зүйлийн холбогдох заалтын шаардлагыг хангаж байгаа бөгөөд нөгөө Талаас аль нэг Тал руу угсраагүй эсхүл задалсан байдлаар орж ирсэн боловч Уялдуулсан системийн ерөнхий тайлбар дүрмийн 2(а) дугаар дүрмийн дагуу угсарсан бараа буюу иж бүрдэл гэж ангилагдаж байвал тэрхүү барааг нөгөө Талын зохих гарал үүсэлтэй бараа гэж үзнэ.

2. Аль нэг Тал руу оруулсан бөгөөд Уялдуулсан системийн ерөнхий тайлбар дүрмийн 2(а) дугаар дүрмийн дагуу угсарсан бараа буюу иж бүрдэл гэж ангилсан угсраагүй буюу задалсан материалаар тухайн Талд угсарсан барааг, хэрэв тэрхүү угсраагүй буюу задалсан материалын дундаас зохих гарал үүсэлгүй материал бүрийг тухайн Тал руу угсраагүй буюу задалсан байдлаар бус салангид нь оруулсан бол тухайн бараа 3.2-оос 3.7 дугаар зүйлийн холбогдох заалтын шаардлагыг хангах байсан тохиолдолд, тухайн Талын зохих гарал үүсэлтэй бараа гэж үзнэ.

3.10 дугаар зүйл Орлох бараа болон материал

1. Аливаа бараа аль нэг Талын зохих гарал үүсэлтэй бараа болохыг тогтоох зорилгоор, хэрэв бараа материалын нөөцөд Тухайн талын зохих гарал үүсэлтэй орлох материал болон зохих гарал үүсэлгүй орлох материалыг хольж тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан бол тухайн материалын гарал үүслийг тухайн Талын нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд заасан бараа материалын нөөцийн удирдлагын аргаар тогтоож болно.

2. Хэрэв тухайн Талын зохих гарал үүсэлтэй орлох бараа болон гарал үүсэлгүй орлох барааг бараа материалын нөөцөд хольсон бөгөөд экспортоор гаргахаас өмнө тэдгээрийг хольсон Талд буулгах, дахин ачих, мөн түүний хэвийн байдлыг хангах аливаа бусад ажиллагаанаас өөр үйлдвэрлэлийн аливаа процесс буюу аливаа ажиллагаа хийгдээгүй бол тухайн барааны гарал үүслийг тухайн Талын нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд заасан бараа материалын нөөцийн удирдлагын аргаар тогтоож болно.

3.11 дүгээр зүйл Туслах материал

Туслах материалыг хаана үйлдвэрлэсэнээс үл харгалзан холбогдох барааг үйлдвэрлэсэн Талын зохих гарал үүсэлтэй материал гэж үзнэ.

3.12 дугаар зүйл

Дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл болон багаж хэрэгсэл

1. Аливаа бараа үйлдвэрлэхэд ашигласан гарал үүсэлгүй бүх материалын хувьд холбогдох тарифын ангилал өөрчлөгдсөн, эсхүл 2 дугаар хавсралтад заасан тодорхой үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын үйл ажиллагаа хийгдсэн эсэхийг тогтооход тухайн бараатай хамт нийлүүлсэн, тухайн барааны стандарт дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, эсхүл багаж хэрэгслийн бүрдэл хэсэг болох дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, эсхүл багаж хэрэгслийг дараахь тохиолдолд тооцохгүй:

- (a) тухайн дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, эсхүл багаж хэрэгслийн хувьд тэдгээрийг холбогдох үнийн нэхэмжлэх дээр тусад нь бичсэн эсэхийг үл харгалзан, тухайн бараанаас тусдаа үнийн нэхэмжлэх байхгүй байх;
- (b) тухайн дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, эсхүл багаж хэрэгслийн тоо хэмжээ болон үнэ тухайн барааны хувьд хэвийн байх.

2. Хэрэв аливаа барааны хувьд өртгийн агууламжийн шаардлага тавигдсан бол тухайн барааны өртгийн агууламжийг тооцохдоо тухайн дагалдах хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, эсхүл багаж хэрэгслийн үнийг, тухайн тохиолдлыг харгалзан, тухайн барааг үйлдвэрлэсэн Талын зохих гарал үүсэлтэй материалын, эсхүл зохих гарал үүсэлгүй материалын өртөг гэж үзнэ.

3.13 дугаар зүйл

Жижиглэн худалдах барааны савлагаа, баглаа боодлын материал болон хайрцаг сав

1. Уялдуулсан системийн ерөнхий тайлбар дүрмийн 5 дугаар дүрмийн дагуу тухайн бараатайгаа хамт ангилагдах жижиглэн худалдах барааны савлагаа, баглаа боодлын материал болон хайрцаг савыг уг барааны гарал үүслийг тодорхойлоход дор дурдсан тохиолдолд тооцохгүй:

- (a) тухайн бараа 3.2 дугаар зүйлийн (a) дэд хэсэгт зааснаар бүхэлд нь гаргаж авсан, эсхүл бүрэн үйлдвэрлэгдсэн;
- (b) тухайн барааг 3.2 дугаар зүйлийн (b) дэд хэсэгт зааснаар гагцхүү зохих гарал үүсэлтэй материалаар үйлдвэрлэсэн байх;

(с) тухайн барааны тарифын ангилал өөрчлөгдсөн байх, эсхүл түүнийг үйлдвэрлэхэд 2 дугаар хавсралтад заасан тодорхой үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын үйл ажиллагаа хийгдсэн.

2. Хэрэв аливаа барааны хувьд өртгийн агууламжийн шаардлага тавигдсан бол тухайн барааны өртгийн агууламжийг тооцохдоо жижиглэн худалдах барааны савлагаа, баглаа боодлын материал болон хайрцаг савны үнийг, тухайн тохиолдлыг харгалзан, тухайн барааг үйлдвэрлэсэн Талын зохих гарал үүсэлтэй материалын, эсхүл зохих гарал үүсэлгүй материалын өртөг гэж үзнэ.

3.14 дүгээр зүйл

Бараа тээвэрлэх болон ачих зориулалттай савлагаа, баглаа боодлын материал болон хайрцаг сав

Аливаа барааг тээвэрлэх болон ачих зориулалттай савлагаа, баглаа боодлын материал болон хайрцаг савыг тухайн барааны гарал үүслийг тогтооход тооцохгүй.

3.15 дугаар зүйл

Тарифын хөнгөлөлт эдлэх хүсэлт

1. Импортлогч Тал экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараанд гарал үүслийн гэрчилгээг үндэслэн энэ хэлэлцээрийн дагуу тарифын хөнгөлөлт олгоно.

2. 1 дэх хэсгийг үл харгалзан:

(a) импортлогч Тал Америкийн Нэгдсэн Улсын 1,500 доллараар илэрхийлэгдсэн хэмжээнээс, эсхүл тухайн импортлогч Талын түүнтэй тэнцэх хэмжээний үндэсний валютаас, эсхүл тухайн импортлогч Талаас тогтоож болох илүү өндөр хэмжээнээс хэтрээгүй гаалийн нийт үнэ бүхий, экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй барааг оруулахад холбогдох импортлогчоос гарал үүслийн гэрчилгээ шаардахгүй. Энэ тохиолдолд тухайн импорт гарал үүслийн гэрчилгээ олгох шаардлагаас зайлсхийх зорилгоор тусгайлан хийгдсэн гэж үзэж болох импортын нэг хэсэг байж болохгүй;

(b) импортлогч Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу гарал үүслийн гэрчилгээ шаардах явдлыг цуцалж болно.

3. Импортлогч Тал, зүйтэй гэж үзвэл, тухайн бараа нь экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа болохыг нотлох өөр баримт гаргаж өгөхийг холбогдох импортлогчоос шаардаж болно.

4. Экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа энэхүү хэлэлцээрийн Тал бус нэг буюу хэд хэдэн улсаар дамжин орж ирж байгаа бол, импортлогч Тал тухайн барааны хувьд тарифын хөнгөлөлт эдлэхийг хүссэн импортлогчоос дараахь зүйлийг шаардаж болно:

- (a) дамжин өнгөрөх тээврийн баримтын хувь;
- (b) тэдгээр энэхүү хэлэлцээрийн Тал бус улсад тухайн барааг буулгах, дахин ачих, мөн түүний хэвийн байдлыг хангах аливаа бусад ажиллагаанаас өөр ажиллагаа хийгдээгүй болохыг нотлон уг хэлэлцээрийн Тал бус улсын гаалийн байгууллагаас, эсхүл өөр холбогдох газраас гаргаж өгсөн гэрчилгээ, эсхүл аливаа бусад мэдээлэл.

3.16 дугаар зүйл **Гарал үүслийн гэрчилгээ**

1. 3.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гарал үүслийн гэрчилгээг экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага холбогдох экспортлогчоос, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс гаргасан хүсэлтийг үндэслэн олгоно. Гарал үүслийн тухайн гэрчилгээ нь 3 дугаар хавсралтад заасан гарал үүслийн гэрчилгээнд тусгагдах үндсэн мэдээллийг агуулсан байна.

2. Энэ зүйлийн зорилгоор, экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага гарал үүслийн гэрчилгээ олгох үүрэг бүхий бусад нэгж буюу байгууллагыг экспортлогч Талын зохих хууль тогтоомжоор олгогдсон эрхийнхээ дагуу томилж болно.

3. Экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага гарал үүслийн гэрчилгээ олгох үүрэг бүхий бусад нэгж буюу байгууллагыг томилсон бол экспортлогч Тал тийнхүү томилогдсон этгээдийн талаар нөгөө Талд бичгээр мэдэгдэнэ.

4. Энэ бүлгийн зорилгоор, энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр, Талууд Тал тус бүрт мөрдөгдөх гарал үүслийн гэрчилгээний загварыг 3.26 дугаар зүйлд заасан Гарал үүслийн талаарх үйл ажиллагааны журамд англи хэлээр тогтооно.

5. Гарал үүслийн гэрчилгээг англи хэлээр бөглөнө.

6. Гарал үүслийн гэрчилгээ нь хэвлэмэл маягттай, эсхүл Талуудын хооронд тохиролцсон өөр бусад хэлбэртэй байна.

7. Олгосон гарал үүслийн гэрчилгээ нь экспортлогч Талаас импортлогч Тал руу илгээх зохих гарал үүсэлтэй барааны нэг удаагийн импортод хамаарах бөгөөд олгосон өдрөөс хойш 12 сарын хугацаанд хүчин төгөлдөр байна.

8. Аливаа бараа экспортлогч нь экспортлогч Талд байгаа тухайн барааг үйлдвэрлэгч биш бол тухайн экспортлогч дараахь бичиг баримтыг үндэслэн гарал үүслийн гэрчилгээ хүсч болно:

(a) холбогдох бараа үйлдвэрлэгчээс экспортлогчид өгсөн мэдээллийг үндэслэн уг экспортлогчоос эрх бүхий төрийн байгууллагад, эсхүл түүнээс томилогдсон этгээдэд гаргаж өгсөн мэдүүлэг;

(b) холбогдох бараа үйлдвэрлэгчээс тухайн экспортлогчийн хүсэлтээр эрх бүхий төрийн байгууллагад, эсхүл түүнээс томилогдсон этгээдэд сайн дураараа, шууд гаргаж өгсөн мэдүүлэг.

9. Гарал үүслийн гэрчилгээг зөвхөн гарал үүслийн гэрчилгээ хүссэн экспортлогч, эсхүл экспортлогч Талд байгаа, 8(b) дэд хэсэгт дурдсан бараа үйлдвэрлэгч экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагад, эсхүл түүнээс томилогдсон этгээдэд экспортлох гэж буй бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа болох шаардлагыг хангасан болохыг нотлон харуулсны дараа олгоно.

10. Экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага тухайн эрх бүхий төрийн байгууллагын, эсхүл түүнээс томилогдсон этгээдийн ажлын байранд хэрэглэдэг гарын үсгийн загвар болон тамга, тэмдгийн дардсын загварыг импортлогч Талд хүргүүлнэ.

11. Талууд нь тэдгээрийн хууль тогтоомжийн дагуу, эрх бүхий төрийн байгууллага, эсхүл түүнээс томилогдсон этгээд олгосон гарал үүслийн гэрчилгээний бүртгэлийг тухайн гэрчилгээ олгосон өдрөөс хойш 5 жилийн хугацаанд хадгалах нөхцөлийг бүрдүүлнэ. Уг бүртгэлд экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй барааны шаардлага хангасан болохыг нотлон харуулсан дагалдах бүх бичиг баримт хавсрагдсан байна.

12. Экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага аливаа гарал үүслийн гэрчилгээ олгох шийдвэрээ цуцалсан бол тухайн гарал үүслийн гэрчилгээг эрх бүхий тухайн төрийн байгууллагад буцаан өгсөнөөс бусад тохиолдолд тийм гарал үүслийн гэрчилгээ олгогдсон экспортлогчид, мөн импортлогч Талын гаалийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

3.17 дугаар зүйл

Экспортын үйл ажиллагаатай холбогдуулан хүлээх үүрэг

Талууд, тэдгээрийн хууль тогтоомжийн дагуу, гарал үүслийн гэрчилгээ олгогдсон экспортлогч, эсхүл экспортлогч Талд байгаа, 3.16 дугаар зүйлийн 8 (b) дэд хэсэгт заасан бараа үйлдвэрлэгч дараахь үүрэг хүлээх нөхцөлийг бүрдүүлнэ:

- (a) уг экспортлогч, эсхүл үйлдвэрлэгч гарал үүслийн гэрчилгээ авсан бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа болох шаардлага хангаагүй болохыг мэдсэн бол экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагад, эсхүл түүнээс томилогдсон этгээдэд нэн даруй бичгээр мэдэгдэх;
- (b) холбогдох зохих гарал үүсэлтэй бараатай холбогдсон баримт бүртгэлийг гарал үүслийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш 5 жилийн хугацаанд хадгалах.

3.18 дугаар зүйл

Гарал үүслийн гэрчилгээг шалгах хүсэлт

1. Энэхүү бүлгийг зөв мөрдөх явдлыг хангах үүднээс, Талууд аливаа гарал үүслийн гэрчилгээтэй холбоотой мэдээллийг шалгахад энэ хэлэлцээр, мөн тэдгээрийн холбогдох хууль тогтоомжийн дагуу бие биедээ харилцан туслалцаа үзүүлнэ.

2. Экспортлогч Талаас тарифын хөнгөлөлттэй импортлосон бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа болох шаардлагыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох зорилгоор, импортлогч Талын гаалийн байгууллага холбогдох барааны зохих гарал үүсэлтэй холбоотой мэдээллийг гарал үүслийн гэрчилгээг үндэслэн экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагаас хүсч болно.

3.2 дахь хэсгийн зорилгоор, экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага уг хүссэн мэдээллийг, экспортлогч Талын хууль тогтоомжийн дагуу холбогдох хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 4 сарын хугацаанд гаргаж өгнө. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага шаардлагатай гэж үзвэл, тухайн барааны гарал үүсэлтэй холбоотой нэмэлт мэдээлэл хүсч болно. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллагаас нэмэлт мэдээлэл хүссэн бол экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага уг хүссэн мэдээллийг, экспортлогч Талын хууль тогтоомжийн дагуу холбогдох хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын хугацаанд гаргаж өгнө.

4.3 дахь хэсгийн зорилгоор, экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага гарал үүслийн гэрчилгээ олгогдсон экспортлогчоос, эсхүл экспортлогч Талд байгаа, 3.16 дугаар зүйлийн 8(b) дэд хэсэгт заасан бараа үйлдвэрлэгчээс уг хүссэн мэдээллийг өөрт гаргаж өгөхийг хүсч болно.

3.19 дүгээр зүйл

Газар дээр нь очиж шалгах

1. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага 3.18 дугаар зүйлийн дагуу тавьсан шалгах хүсэлтийн үр дүнг хангалтгүй гэж үзвэл экспортлогч Талд дараахь хүсэлт тавьж болно:

(a) аливаа барааны гарал үүсэлтэй холбоотой мэдээлэл цуглуулж, гаргаж өгөх, мөн энэ зорилгоор, экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага импортлогч Талын гаалийн байгууллагатай хамтран гарал үүслийн гэрчилгээ олгогдсон экспортлогч, эсхүл экспортлогч Талд байгаа, 3.16 дугаар зүйлийн 8(b) дэд хэсэгт заасан бараа үйлдвэрлэгчийн байгууламжид очих замаар тухайн барааны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг газар дээр нь шалгах;

(b) (a) дэд хэсгийн дагуу газар дээр нь очих явцад, эсхүл түүний дараа экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагын, эсхүл түүнээс томилогдсон этгээдийн эзэмшилд байгаа, тухайн барааны гарал үүсэлтэй холбоотой мэдээллээр хангах.

2. Импортлогч Талын гаалийн байгууллага экспортлогч Талд 1 дэх хэсэгт заасны дагуу газар дээр нь очих хүсэлт гаргахдаа, уг хүсэлтийг тийнхүү газар дээр нь очихоор санал болгосон өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр тавих бөгөөд экспортлогч Тал түүнийг хүлээн авсан тухайгаа баталгаажуулна. Экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага байгууламжид нь очих гэж буй экспортлогчоос, эсхүл экспортлогч Талд байгаа бараа үйлдвэрлэгчээс мөн бичгээр зөвшөөрөл авна.

3. 2 дахь хэсэгт дурдсан захидалд дараахь зүйлс тусгагдсан байна:

- (a) захидал бичсэн гаалийн байгууллагын нэр;
- (b) байгууламжид нь очих гэж буй экспортлогчийн, эсхүл экспортлогч Талд байгаа бараа үйлдвэрлэгчийн нэр;
- (c) газар дээр нь очихоор санал болгосон өдөр болон газар;
- (d) газар дээр нь очих ажлын зорилго болон хамрах хүрээ, үүнд гарал үүслийн гэрчилгээнд байгаа, шалгахар болсон барааг тодорхой заасан байна;
- (e) газар дээр нь очих явцад байлцах импортлогч Талын гаалийн байгууллагын ажилтны нэр болон албан тушаал.

4. Экспортлогч Тал 1 дэх хэсгийн дагуу газар дээр нь очих хүсэлтийг хүлээн зөвшөөрч байгаа, эсхүл татгалзаж байгаа тухайгаа импортлогч Талд 2 дахь хэсэгт дурдсан захидлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

5. Экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага 1 дэх хэсгийн дагуу олж авсан мэдээллийг шалгалт хийсэн сүүлчийн өдрөөс хойш 45 хоногийн дотор, эсхүл харилцан тохиролцсон өөр бусад хугацаанд, экспортлогч Талын холбогдох хууль тогтоомжийн дагуу импортлогч Талын гаалийн байгууллагад гаргаж өгнө.

3.20 дугаар зүйл

Гарал үүслийг тодорхойлох асуудал болон тарифын хөнгөлөлт

1. Импортлогч Талын гаалийн байгууллага тарифын хөнгөлөлтөд хамрагдахаар импортлогчоос хүссэн аливаа бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа биш болох тохиолдолд, эсхүл тухайн импортлогч энэхүү бүлгийн холбогдох аль нэг шаардлагыг дагаж мөрдөөгүй бол тухайн бараанд тарифын хөнгөлөлт олгохоос татгалзаж болно.

2. Импортлогч Талын гаалийн байгууллага экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагаас 3.16 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн дагуу тухайн бараанд гарал үүслийн гэрчилгээ олгосон шийдвэрээ цуцалсан тухай мэдэгдэл хүлээн авсан бол аливаа бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа биш болохыг тогтоож болно, мөн тарифын хөнгөлөлт олгохоос татгалзаж болно.

3. Импортлогч Талын гаалийн байгууллага дараахь тохиолдолд аливаа бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа биш болохыг тогтоож, тарифын хөнгөлөлт олгохоос татгалзаж болох бөгөөд энэ талаар бичгээр гаргасан шийдвэрээ экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагад хүргүүлнэ:

- (a) экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага холбогдох мэдээллийг 3.18 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт, эсхүл 3.19 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлээгүй;
- (b) экспортлогч Тал газар дээр нь очиж шалгалт хийхээс татгалзсан, эсхүл уг Тал 3.19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан захидлын хариуг 3.19 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд өгч чадаагүй;
- (c) 3.18 буюу 3.19 дүгээр зүйлийн дагуу импортлогч Талын гаалийн байгууллагад өгсөн мэдээлэл тухайн барааг экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа болохыг нотлоход хангалттай биш байх.

4. Импортлогч Талын гаалийн байгууллага 3.18 буюу 3.19 дүгээр зүйлийн аль тохиороод нь заасан үйл ажиллагааг явуулсны дараа тухайн бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа мөн, эсхүл биш болох талаар бичгээр гаргасан шийдвэрээ экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагад баримт нотолгоо болон тийм шийдвэр гаргах болсон эрх зүйн үндэслэлийн хамт гаргаж өгнө. Экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллага импортлогч Талын гаалийн байгууллагын гаргасан уг шийдвэрийн талаар 3.19 дүгээр зүйлийн дагуу газар дээр нь очих байсан байгууламжийн эзэн болох экспортлогчид, эсхүл экспортлогч Талд байгаа бараа үйлдвэрлэгчид мэдэгдэнэ.

3.21 дүгээр зүйл

Мэдээллийн нууцыг хамгаалах

1. Талууд энэхүү бүлэгт зааснаар өөрт нь нууц гэж гаргаж өгсөн мэдээллийг өөрсдийн хууль тогтоомжийн дагуу нууцалж, уг мэдээллийг гаргаж өгсөн этгээдүүдийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй мэдээлэл задрахаас сэргийлнэ.

2. Импортлогч Талын гаалийн байгууллагын энэхүү бүлгийн дагуу олж авсан мэдээллийг:

- (a) зөвхөн тухайн байгууллага энэхүү бүлгийн зорилгоор ашиглаж болно;

(b) импортлогч Тал, экспортлогч Талд тийм мэдээлэл авах хүсэлт тавьсан бөгөөд түүнийг тухайн импортлогч Талд дипломат шугамаар, эсхүл экспортлогч Талын холбогдох хууль тогтоомж болон дүрэм журамд заасан өөр бусад сувгаар гаргаж өгсөн байхаас бусад тохиолдолд, шүүхийн журмаар буюу шүүгчээс аливаа эрүүгийн хэрэг шүүн таслах үйл ажиллагаанд ашиглаж болохгүй.

3.22 дугаар зүйл

Жижиг алдаа

Импортлогч Талын гаалийн байгууллага бага зэргийн зөрөө гарсан, эсхүл зарим зүйл орхигдсон, алдаатай бичигдсэн, хүснэгтээс хальсан зэрэг жижиг хэмжээний алдаа нь гарал үүслийн гэрчилгээнд байгаа мэдээлэл үнэн зөв эсэхийг эргэлзээтэй болгох хэмжээнд хүргэхээргүй бол тэдгээр жижиг алдааг тоохгүй байж болно.

3.23 дугаар зүйл

Худал мэдүүлэг өгсөн тохиолдолд хүлээлгэх шийтгэл, авах арга хэмжээ

1. Талууд гарал үүслийн гэрчилгээ олгохоос өмнө экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагад, эсхүл түүнээс томилогдсон этгээдэд худал мэдүүлэг буюу хуурамч бичиг баримт гаргаж өгсөн тохиолдолд гарал үүслийн гэрчилгээ олгогдсон экспортлогч, болон экспортлогч Талд байгаа, 3.16 дугаар зүйлийн 8(b) дэд хэсэгт заасан бараа үйлдвэрлэгч нарт өөрсдийн холбогдох хууль тогтоомж болон дүрмийн дагуу зохих шийтгэл тогтоон мөрдөнө, эсхүл хариуцлагын өөр бусад арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2. Талууд гарал үүслийн гэрчилгээ олгосны дараа уг гарал үүслийн гэрчилгээг олгосон бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа биш болохыг мэдмэгцээ энэ талаар экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагад, эсхүл түүнээс томилогдсон этгээдэд бичгээр нэн даруй мэдэгдээгүй тохиолдолд гарал үүслийн гэрчилгээ олгогдсон экспортлогч, эсхүл экспортлогч Талд байгаа, 3.16 дугаар зүйлийн 8(b) дэд хэсэгт заасан бараа үйлдвэрлэгч нарт өөрсдийн холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих арга хэмжээ авна.

Тайлбар: Илүү ойлгомжтой болгох үүднээс, гарал үүслийн гэрчилгээ олгогдсон экспортлогч, эсхүл экспортлогч Талд байгаа, 3.16 дугаар зүйлийн 8(b) дэд хэсэгт заасан бараа үйлдвэрлэгч нарт хэрэв тэд гарал үүслийн гэрчилгээ олгосны дараа уг гарал үүслийн гэрчилгээг олгосон бараа экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа биш болохыг мэдмэгцээ энэ талаар экспортлогч Талын эрх бүхий төрийн байгууллагад, эсхүл түүнээс томилогдсон этгээдэд бичгээр нэн даруй мэдэгдсэн бол, Талуудын холбогдох хууль тогтоомжийн дагуу энэ хэсэгт заасан арга хэмжээг авахгүй.

3.24 дүгээр зүйл

Бусад заалт

Импортлогч Тал болон экспортлогч Тал хоорондын харилцаа англи хэлээр үйлдэгдэнэ.

3.25 дугаар зүйл

Гарал үүслийн дүрмийн дэд хороо

1. Энэ бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд Гарал үүслийн дүрмийн дэд хороо (энэ зүйлд цаашид “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо нь дараахь чиг үүрэгтэй байна:

(a) Дараахь асуудлаар бүлгийн хэрэгжилтэд хяналт тавих мөн шаардлагатай тохиолдолд зохих зөвлөмж боловсруулан Хамтарсан хороонд оруулах:

- (i) энэхүү бүлгийг хэрэгжүүлэх болон мөрдөх асуудал;
- (ii) хавсралт 2 буюу 3-т аль нэг Талаас санал болгосон нэмэлт, өөрчлөлтүүд;
- (iii) 3.26 дугаар зүйлд дурдсан Гарал үүслийн талаарх үйл ажиллагааны журам;

(b) Талуудаас тохиролцсоны дагуу энэхүү бүлэгт хамааралтай гэж үзсэн аливаа бусад асуудлыг авч үзэх;

(c) Дэд хорооны үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;

(d) Хамтарсан хорооноос даатгаж болох бусад үүргийг гүйцэтгэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу төвлөсөн хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

3.26 дугаар зүйл

Гарал үүслийн талаарх үйл ажиллагааны журам

Хамтарсан хороо, энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр, Талуудын гаалийн байгууллага, эрх бүхий төрийн байгууллага болон холбогдох бусад байгууллагууд өөрсдийн хүлээсэн үүргээ энэхүү бүлгийн хүрээнд гүйцэтгэх асуудлыг нарийвчилан зохицуулсан үйл ажиллагааны журмыг батална.

4 дүгээр бүлэг

Гаалийн үйл ажиллагаа болон худалдааг хөнгөвчлөх

4.1 дүгээр зүйл

Хамрах хүрээ болон зорилго

1. Энэхүү бүлэг нь Талуудын хооронд худалдаалсан барааны бүрдүүлэлтэд шаардагдах гаалийн үйл ажиллагаанд хамаарна.

2. Энэхүү бүлгийг Талуудын хууль тогтоомжийн дагуу болон тэдгээрийн гаалийн холбогдох байгууллагад байгаа нөөц бололцооны хүрээнд хэрэгжүүлнэ.

3. Энэхүү бүлгийн зорилго нь Талуудын хоорондын барааны худалдааг хөнгөвчлөх үүднээс ил тод байдлыг хангах, гаалийн хууль тогтоомжийг зохистой мөрдөх болон барааны бүрдүүлэлтийг шуурхай хийх үндсийг бий болгох, гаалийн үйл ажиллагааны чиглэлээрх хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжихэд оршино.

4.2 дугаар зүйл

Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор, “гаалийн хууль тогтоомж” гэх нэр томъёо нь бараа оруулах, гаргах болон дамжуулан өнгөрүүлэхтэй холбоотой Тал бүрийн гаалийн байгууллагаас хэрэгжүүлж буй гаалийн татвар, хураамж болон бусад татварт хамаарах, эсхүл Тал бүрийн гаалийн нутаг дэвсгэрийн хилээр хяналттай нэвтрүүлэх эд зүйлийн хөдөлгөөнийг зохицуулсан хориг, хязгаарлалт болон тэдгээртэй адилтгах бусад хяналтанд хамаарах хууль тогтоомжийг илэрхийлнэ.

4.3 дугаар зүйл

Ил тод байдал

1. Тал бүр өөрийн гаалийн хууль тогтоомжид хамаарах нийтлэг хэрэглээний холбогдох бүх мэдээлэл аливаа нэг сонирхогч этгээдэд нээлттэй байх явдлыг хангана.

2. Тал бүр олон нийтэд түгээсэн мэдээллийг өөрсдийн гаалийн хууль тогтоомжид өөрчлөлт орсны улмаас шинэчлэх шаардлагатай болсон тохиолдолд сонирхогч этгээд тэдгээр өөрчлөлтийг харгалзан үзэх боломжийг бүрдүүлэх үүднээс аль болох тухайн өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос өмнө уг шинэчилсэн мэдээллийг тэдэнд хялбар хүртээлтэй болгоно.

3. Тал бүр нь тэдгээрийн аливаа сонирхогч этгээдийн хүсэлтээр тэдний тавьсан болон өөрсдийн гаалийн хууль тогтоомжид хамаарах гаалийн тодорхой асуудалтай холбоотой мэдээллийг аль болох түргэн шуурхай, үнэн зөв гаргаж өгнө. Талууд зөвхөн тухайлан хүссэн мэдээллийг төдийгүй, тухайн сонирхогч этгээд мэдвэл зохино гэж үзсэн аливаа бусад зохистой мэдээллийг мөн гаргаж өгнө.

4. Тал бүр Талуудын аливаа сонирхогч этгээдээс гаалийн асуудлаар тавьсан үндэслэл бүхий асуултад хариулт өгөх үүрэгтэй нэг буюу хэд хэдэн мэдээлэл, лавлагааны төвийг томилон ажиллуулах бөгөөд эдгээр төвийн нэр, хаягийг өөрийн цахим хаягаар дамжуулан олон нийтэд нээлттэй болгоно.

4.4 дүгээр зүйл Гаалийн бүрдүүлэлт

1. Талууд өөрийн гаалийн холбогдох үйл ажиллагааг урьдчилан таамаглахуйц, тогтвортой, ил тод байдлаар явуулна.

2. Талуудын хооронд худалдаалсан барааны гаалийн бүрдүүлэлтийг шуурхай хийх үүднээс, Тал бүр:

- (a) мэдээлэл, харилцаа холбооны технологийг ашиглана;
- (b) өөрийн гаалийн үйл ажиллагааг хялбарчилна;
- (c) өөрийн гаалийн үйл ажиллагааг аль болох Гаалийн хамтын ажиллагааны зөвлөлийн хүрээнд гаргасан зэрэг олон улсын холбогдох стандарт заалт болон практик зөвлөмжтэй уялдуулна;
- (d) өөрийн гаалийн байгууллага болон дараахь байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохистой үед хөхиүлэн дэмжинэ:
 - (i) тухайн Талын дотоодын байгууллага;
 - (ii) тухайн Талын худалдааны нийгэмлэг;
 - (iii) энэхүү хэлэлцээрийн оролцогч бус талын гаалийн эрх бүхий байгууллага.

3. Тал бүр нь холбогдох Талаас гаалийн асуудлаар гаргасан тодорхой нэг шийдвэрийг шүүхийн, эсхүл захиргааны журмаар хянан үзэх ажиллагааг ашиг сонирхол нь хөндөгдсөн талууд ашиглахад хялбар дөхөм байх явдлыг хангана. Хянан үзэх уг ажиллагаа тухайн шийдвэрийн хэрэгжилтийг хариуцсан байгууллагаас хараат бус байхын зэрэгцээ алагчилалгүй, шударга байдлаар явагдана.

4.5 дугаар зүйл

Түр хугацаагаар оруулах болон дамжин өнгөрөх бараа

1. Талуудын хооронд худалдаалсан барааг түр хугацаагаар оруулах үйл ажиллагааг Тал бүр өөрийн хууль тогтоомж болон олон улсын хэмжээнд хүлээсэн үүргийнхээ дагуу хөнгөвчлөх явдлыг үргэлжлүүлнэ.

2. Тал бүр нөгөө Талаас орж ирсэн, эсхүл нөгөө Тал руу чиглэсэн дамжин өнгөрөх барааны гаалийн бүрдүүлэлтийг 1994 оны ТХЕХ-ийн 5 дугаар зүйлийн 3 дах хэсгийн дагуу хөнгөвчлөх явдлыг үргэлжлүүлнэ.

3. Талууд олон улсын хэмжээнд хүлээсэн үүргийнхээ дагуу А.Т.А. карнейг ашиглах болон Талуудад, эсхүл энэхүү хэлэлцээрт оролцогч бус талуудад байгаа дамжин өнгөрөх барааны гаалийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөх явдлыг сургалт, семинар зэрэг арга хэмжээ зохион байгуулах замаар дэмжихийг эрмэлзэнэ.

4. Энэ зүйлийн зорилгоор:

(a) “А.Т.А. карней” гэх нэр томъёог дараахь конвенцид тусгагдсан утгаар ойлгоно:

(i) Япон Улсын хувьд, 1961 оны 12 дугаар сарын 6-ны өдөр Брюссель хотноо байгуулсан Барааг түр хугацаагаар оруулах А.Т.А. карнейн тухай конвенц;

(ii) Монгол Улсын хувьд, 1990 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Стамбул хотноо байгуулсан Түр хугацаагаар оруулах тухай конвенц;

- (b) “түр хугацаагаар оруулах” гэх нэр томъёо нь зарим барааг гаалийн татвараас бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн чөлөөлж, гаалийн нутаг дэвсгэрт тодорхой нөхцөлтэйгээр оруулж болох гаалийн үйл ажиллагааг илэрхийлнэ. Уг барааг тодорхой зорилгоор оруулах бөгөөд тогтоосон хугацаанд, түүнчлэн тэдгээрийг ашиглах явцад учирсан ердийн элэгдэл хорогдлоос өөр аливаа өөрчлөлтгүйгээр буцаан гаргах зорилготой байна.

4.6 дугаар зүйл

Урьдчилан шийдвэрлэх

Импортлогч Талын баталсан, эсхүл мөрдөж байгаа холбогдох хууль тогтоомжийн дагуу бичгээр өргөдөл гаргасан тохиолдолд, мөн тухайн импортлогч Тал татгалзах зүй ёсны үндэслэл байхгүй бол, тухайн импортлогч Тал холбогдох барааг оруулахаас өмнө дараахь асуудлаар бичгээр урьдчилсан шийдвэр гаргаж өгөхийг эрмэлзэнэ:

- (a) тарифын ангилал;
- (b) гаалийн үнэлгээ;
- (c) тухайн бараа 3 дугаар бүлгийн заалтын дагуу экспортлогч Талын зохих гарал үүсэлтэй бараа байх шаардлагыг хангасан эсэх.

4.7 дугаар зүйл

Хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох

1. Талууд гаалийн үйл ажиллагааны чиглэлд, түүний дотор хориглосон бараа худалдаалах болон оюуны өмчийн эрхийн зөрчилтэй сэжиг бүхий бараа оруулах, гаргах явдалтай тэмцэх асуудлаар хамтран ажиллаж, харилцан мэдээлэл солилцоно.

2. Дээрх хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцох явдлыг Хэрэгжүүлэх хэлэлцээрт зааснаар хэрэгжүүлнэ.

3. Энэ зүйлийн дагуу мэдээлэл солилцоход 1.8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг мөрдөхгүй.

4.8 дугаар зүйл
Гаалийн үйл ажиллагааны болон худалдааг хөнгөвчлөх
дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд Гаалийн үйл ажиллагааны болон худалдааг хөнгөвчлөх дэд хороо (цаашид энэ зүйлд “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэхүү бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) Талуудын хоорондын худалдааг хөнгөвчлөх хүрээнд энэ бүлэгтэй холбоотой боловсронгуй болгох шаардлагатай асуудлыг олж тодорхойлох;
- (c) Дэд хорооны үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;
- (d) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хорооны бүрэлдэхүүнийг Хэрэгжүүлэх хэлэлцээрээр тодорхойлно.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу төвлөсөн хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

5 дугаар бүлэг

Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ

5.1 дүгээр зүйл

Хамрах хүрээ

Энэхүү бүлэг нь ЭАУЭААХХ тухай хэлэлцээрийн дагуу Талуудын хэрэгжүүлж буй Талууд хоорондын барааны худалдаанд шууд буюу шууд бусаар нөлөөлж болзошгүй Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн (цаашид “ЭАУЭА” гэх)-н бүхий л арга хэмжээнд хамаарна.

5.2 дугаар зүйл

Эрх болон үүргээ дахин баталгаажуулах

Талууд ЭАУЭААХХ тухай хэлэлцээрт заасан ЭАУЭА-н арга хэмжээнд хамаарах эрх болон үүргээ дахин нотлож байна.

5.3 дугаар зүйл

Уялдуулан зохицуулах

Талууд ЭАУЭА-н арга хэмжээгээ уялдуулан зохицуулахтай холбоотой асуудлаар ЭАУЭААХХ тухай хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасанчлан аль болох өргөн хүрээнд хамтран ажиллахыг эрмэлзэнэ. Уг хамтын ажиллагаа нь ЭАУЭААХХ тухай хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн дагуу хүн, амьтан, эсхүл ургамлын амьдрал, эсхүл эрүүл мэндийг хамгаалах зохих түвшинг өөрчлөхийг аль нэг Талаас шаардахгүйгээр явагдана.

5.4 дүгээр зүйл

Адилтган үзэх

1. Экспорлогч Тал нь өөрийн ЭАУЭА-н арга хэмжээг импортлогч Талын ЭАУЭА-н хамгаалалтын зохих ёсны түвшинд хүрсэн болохыг импортлогч Талд бодитоор харуулсан тохиолдолд импортлогч Тал нь экспортлогч Талын арга хэмжээг өөрийнхтэйгээ адилтган хүлээн зөвшөөрнө.

2. Тал бүр нөгөө Талын хүсэлтийн дагуу ЭАУЭА-н тодорхой арга хэмжээг адилтган үзэхийг хүлээн зөвшөөрөхтэй холбоотой хоёр талын тохиролцоонд хүрэх зорилгоор зөвлөлдөөн хийнэ.

5.5 дугаар зүйл

Мэдээлэл, лавлагааны төв

Тал бүр хорио цээрийн арга хэмжээний талаар нөгөө Талаас тавьсан үндэслэл бүхий бүх лавлагаанд хариулт өгөх, мөн тохиромжтой бол, нөгөө Талд холбогдох мэдээлэл өгөх үүрэг бүхий мэдээлэл, лавлагааны төвийг томилон ажиллуулна.

5.6 дугаар зүйл

Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээний дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд ЭАУЭА-н арга хэмжээний дэд хороо (цаашид энэ зүйлд “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо нь дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэхүү бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) Талууд ЭАУЭА-тай холбоотой журам болон стандартыг өөрчлөх эсхүл нэвтрүүлэх, мөн Талууд хоорондын барааны худалдаанд шууд буюу шууд бусаар нөлөөлж болзошгүй Талуудын нутаг дэвсгэрт тохиолддог ЭАУЭА-н хэрэгтэй холбоотой асуудлаар мэдээлэл солилцох;
- (c) харилцан хүлээн зөвшөөрөхүйц шийдэлд хүрэх зорилгоор ЭАУЭААХХ тухай хэлэлцээрт дурдсан уялдуулан зохицуулах, адилтган үзэх, бүс нутгийн нөхцөл байдалд зохицуулах, мөн хяналт, шалгалт болон баталгаажуулалт хийх журамтай холбоотой асуудлаар шинжлэх ухаанд суурилсан техникийн зөвлөгөөн зохион байгуулах;
- (d) ЭАУЭА-н асуудал, түүний дотор чадавхийг бэхжүүлэх, техникийн туслалцаа болон мэргэжилтэн солилцох асуудлаар Талууд хоорондын техникийн хамтын ажиллагааны талаар хэлэлцэх;
- (e) энэ бүлэгтэй холбоотой аливаа бусад асуудлыг хэлэлцэх;
- (f) Дэд хорооны үр дүн болон дүгнэлтийг холбогдох байгууллагад тайлагнах;

(g) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь холбогдох мэргэжилтнүүдийн зохих оролцоо бүхий Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

5.7 дугаар зүйл
16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай

Энэхүү бүлгийг 16 дугаар бүлэгт хэрэглэхгүй.

6 дугаар бүлэг
Техникийн зохицуулалт, стандарт болон
тохирлын үнэлгээний журам

6.1 дүгээр зүйл
Хамрах хүрээ

1. Энэхүү бүлэг нь Талуудын хоорондын барааны худалдаанд нөлөөлж болохуйц Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрт тодорхойлсон техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журамд хамаарна.

2. Энэхүү бүлэг нь дараахь зүйлд хамаарахгүй:

- (a) Засгийн газрын байгууллагаас өөрийн байгууллагын үйлдвэрлэл буюу хэрэглээний шаардлагад нийцүүлэн баталсан худалдан авалтын техникийн нөхцөл;
- (b) ЭАУЭААХХ тухай хэлэлцээрийн А хавсралтад тодорхойлсон Эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ.

6.2 дугаар зүйл
Зорилго

Энэхүү бүлгийн зорилго нь:

- (a) Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг сайжруулах замаар Талуудын хоорондын худалдааг нэмэгдүүлэх ба хөнгөвчлөх;
- (b) техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журам нь худалдаанд шаардлагагүй саад тотгорыг үүсгэхгүй байхыг бататгах;
- (c) Талуудын хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд оршино.

6.3 дугаар зүйл
Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор:

- (a) “Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр” гэх нэр томьёо нь ДХБ-ын тухай хэлэлцээрийн 1А хавсралт дахь Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (b) Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн 1 дүгээр хавсралтад тусгасан нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

6.4 дүгээр зүйл

Эрх, үүргийг дахин нотлох

Талууд Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн хүрээнд техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмын талаар хүлээсэн эрх, үүргээ үүгээр дахин нотолж байна.

6.5 дугаар зүйл

Олон улсын стандарт

1. Тал бүр Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэг болон 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн хүрээнд тусгасан олон улсын холбогдох стандарт болон заавар буюу өөрийн зөвлөмжийг техникийн зохицуулалт болон тохирлын үнэлгээний журмынхаа үндэслэл болгон хэрэглэнэ.

2. Тал бүр өөрийн үндэсний стандартчиллын байгууллагыг нөгөө Талын үндэсний стандартчиллын холбогдох байгууллагатай олон улсын стандартчиллын салбарт хамтран ажиллахыг дэмжинэ. Талуудын стандартчиллын байгууллагууд нь бүс нутгийн болон олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бол энэхүү гишүүнчлэлийн хүрээнд дээр дурдсан хамтын ажиллагааг явуулж болно.

6.6 дугаар зүйл

Техникийн зохицуулалт

1. Аль нэг Тал нөгөө Талын техникийн зохицуулалттай төстэй техникийн зохицуулалт боловсруулах сонирхолтой байгаа хүсэлт гаргасан бол нөгөө Тал өөрийнэг Тал нөгөө Талын техникийн зохицуулалттай төстэй, эсхүл баримт бичиг бүхий холбогдох мэдээллийг боломжоороо өгнө.

2. Тал бүр нөгөө Талын техникийн зохицуулалтыг өөрийнхөөс нь ялгаатай боловч өөрийн техникийн зохицуулалтын зорилгыг бүрэн хангаж буй бол түүнийг адилтган үзэж хүлээн зөвшөөрөх талаар нааштай авч үзнэ.

3. Аль нэг Тал нөгөө Талын техникийн зохицуулалтыг адилтган үзэж хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд нөгөө Тал хүсэлт гаргавал уг шалтгааныг тайлбарлана.

6.7 дугаар зүйл

Тохирлын үнэлгээний журмын үр дүнг хүлээн зөвшөөрөх

1. Талууд нөгөө Талд явуулсан тохирлын үнэлгээний журмын үр дүнг тухайн Тал хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг үзүүлэхүйц өргөн хүрээний механизм буйг хүлээн зөвшөөрнө. Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт хэрэглэж буй ийм механизмын талаарх мэдээллийг нөгөө Талын хүсэлтээр гаргаж өгнө.

2. Тал бүр нөгөө Талын тохирлын үнэлгээний журмын үр дүнг эдгээр журам нь өөрийнхөөс нь ялгаатай боловч тэдгээр журамтай нь ижил төстэй тохирох техникийн зохицуулалт буюу стандартын шаардлагад бүрэн нийцэж байгааг баталж буй бол хүлээн зөвшөөрөх явдлыг боломжоороо хангана.

3. Аль нэг Тал нөгөө Талд явуулсан тохирлын үнэлгээний журмын үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол уг шалтгаанаа нөгөө Талын хүсэлтийн дагуу тухайн Талд тохирох үедээ залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж олгох зорилгоор өөрийн хууль тогтоомжийн хүрээнд тайлбарлана.

4. Тал бүр боломжтой тохиолдолд өөрийн нутаг дэвсгэр дэх тохирлын үнэлгээний байгууллагад олгодгоос дутуугүй нөхцөлөөр нөгөө Талын тохирлын үнэлгээний байгууллагыг итгэмжлэх, томилох, эсхүл хүлээн зөвшөөрнө. Хэрэв аль нэг Тал өөрийн нутаг дэвсгэртээ тодорхой техникийн зохицуулалт буюу стандартад нийцэж буй эсэх талаар үнэлгээ хийж буй байгууллагыг итгэмжлэх, томилох, эсхүл хүлээн зөвшөөрөх бөгөөд тухайн техникийн зохицуулалт буюу стандартад нийцэж буй эсэх талаар үнэлгээ хийж буй нөгөө Талын байгууллагыг итгэмжлэх, томилох, эсхүл хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал уг шалтгаанаа хүсэлт гаргасан тохиолдолд тайлбарлана.

6.8 дугаар зүйл

Мэдээлэл, лавлагааны төв

Тал бүр техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмын талаар нөгөө Талын гаргасан үндэслэл бүхий хүсэлтэд хариу өгөх, түүнчлэн тохиромжтой үед нөгөө Тал мэдэж байх шаардлагатай гэж үзсэн бусад холбогдох мэдээллийг нөгөө Талд хүргүүлэх үүрэг бүхий мэдээлэл, лавлагааны төвийг томилон ажиллуулна.

6.9 дүгээр зүйл

Техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмын дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмын дэд хороо (цаашид энэ зүйлд “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэхүү бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмыг боловсруулах болон сайжруулахад хамтын ажиллагааг идэвхижүүлэх;
- (c) техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журмын талаар мэдээлэл солилцох;
- (d) техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журамд хамаарах асуудлаар харилцан зөвлөлдөх;
- (e) техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журамтай холбоотой бүс нутгийн болон олон талын хүрээнд хийгдэж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл солилцох;
- (f) энэ бүлэгтэй холбоотой асуудлаар Талуудын хоорондын техникийн хамтын ажиллагааг хэлэлцэх;
- (g) энэ бүлэгтэй холбоотой аливаа асуудал, түүний дотор Талуудын хооронд маргаан үүсгэж болохуйц асуудлыг харилцан хүлээн зөвшөөрөхүйц шийдлийг олох зорилгоор хэлэлцэх;
- (h) Дэд хорооны үр дүн болон дүгнэлтийг холбогдох байгууллагад тайлагнах;
- (i) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

5. Энэ зүйлийн хүрээнд Дэд хорооны зохицуулагч нь дараахь байгууллага байна:

- (a) Япон Улсын хувьд, Гадаад хэргийн яам, эсхүл түүний үүргийг залгамжлагч байгууллага;
- (b) Монгол Улсын хувьд, Аж үйлдвэрийн яам, эсхүл түүний үүргийг залгамжлагч байгууллага.

6.10 дугаар зүйл
16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай

Энэхүү бүлгийг 16 дугаар бүлэгт хэрэглэхгүй.

7 дугаар бүлэг Үйлчилгээний худалдаа

7.1 дүгээр зүйл Хамрах хүрээ

1. Энэхүү бүлэг нь аль нэг Талын баталсан буюу хэрэгжүүлж буй үйлчилгээний худалдаанд нөлөөлөхүйц арга хэмжээнд хамаарна.

2. Энэхүү бүлэг нь дараахь зүйлд хамаарахгүй:

- (a) далайн тээврийн үйлчилгээнд эргийн дагуу хийх худалдаа;
- (b) агаарын тээврийн үйлчилгээний хувьд, аливаа хэлбэрээр зөвшөөрөл олгосон тээвэрлэлтийн эрхэд нөлөөлөхүйц арга хэмжээ, эсхүл тээвэрлэлтийн эрхийг хэрэгжүүлэхтэй шууд холбоотой үйлчилгээнд нөлөөлөхүйц арга хэмжээ;
- (c) Засгийн газрын худалдан авах ажиллагаа;
- (d) аль нэг Талын, эсхүл төрийн өмчийн аж ахуйн нэгжийн олгосон буцалтгүй тусламж, Засгийн газрын хөнгөлөлттэй зээл, баталгаа болон даатгал бүхий татаас;
- (e) цагаачлал болон зорчих тухай хууль тогтоомжтой холбоотой арга хэмжээ;
- (f) нөгөө Талын хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх боломж хайж буй нэг Талын хувь хүнд нөлөөлөх арга хэмжээ, эсхүл иргэн буюу харьяат эсхүл байнга оршин суух буюу хөдөлмөр эрхлэхтэй холбоотой арга хэмжээ;
- (g) засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд нийлүүлж буй үйлчилгээ.

3. Энэхүү бүлэг нь 2(b) дэд хэсэгт заасныг үл харгалзан дараахь арга хэмжээнд үйлчилнэ:

- (a) агаарын хөлгийн засвар болон техникийн үйлчилгээ;
- (b) агаарын тээврийн үйлчилгээний борлуулалт ба зах зээл;
- (c) захиалгын цахим системийн үйлчилгээ.

4. Энэхүү бүлгийн санхүүгийн үйлчилгээ, түүний хамрах хүрээ ба нэр томъёоны тодорхойлолттой холбоотой нэмэлт заалтыг 4 дүгээр хавсралтад тусгасан.

5. Энэхүү бүлгийн харилцаа холбооны үйлчилгээ, түүний хамрах хүрээ ба нэр томъёоны тодорхойлолттой холбоотой нэмэлт заалтыг 5 дугаар хавсралтад тусгасан.

7.2 дугаар зүйл Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор:

- (a) “агаарын хөлгийн засвар болон техникийн үйлчилгээ” гэх нэр томъёо нь агаарын хөлгийг үйлчилгээнээс гаргасан үед түүнд буюу түүний хэсэгт үйлчилгээ хийх ажлыг хэлэх бөгөөд үүнд техникийн урсгал засварын үйлчилгээ хамаарахгүй;
- (b) “захиалгын цахим системийн үйлчилгээ” гэх нэр томъёо нь тийз захиалах, эсхүл худалдан авах замаар агаарын тээвэрлэгчийн нислэгийн хуваарь, боломж, үнэ болон үнийг тогтоосон журмын тухай мэдээллийг агуулсан цахим системээр үзүүлэх үйлчилгээг хэлнэ;
- (c) “мөрдөж буй” гэх нэр томъёо нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр мөрдөж байсныг хэлнэ;
- (d) “нөгөө Талын хуулийн этгээд” гэх нэр томъёо нь дараахь хуулийн этгээдийг хэлнэ:
 - (i) нөгөө Талын хуулийн дагуу байгуулсан буюу бусад байдлаар зохион байгуулсан;
 - (ii) арилжааны төлөөллөөр дамжуулан үйлчилгээ нийлүүлэх тохиолдолд дараахь этгээдийн өмчид эсхүл хяналтад байна:
 - (A) нөгөө Талын хувь хүн;
 - (B) дээрх (i) дэд хэсэгт тодорхойлсон нөгөө Талын хуулийн этгээд;

(e) “арга хэмжээ” гэх нэр томьёо нь хууль, зохицуулалт, дүрэм, журам, шийдвэр, захиргааны журам буюу бусад төрлийн аливаа арга хэмжээг хэлнэ;

Тайлбар: “арга хэмжээ” гэдэгт ДХБ-ын Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээн дэх татварын арга хэмжээ хамаарна.

(f) “аль нэг Талын баталсан буюу хэрэгжүүлж буй арга хэмжээ” гэх нэр томьёо нь дор дурдсанаар баталсан буюу хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээг хэлнэ:

(i) аль нэг Талын засгийн газрын буюу эрх бүхий байгууллагын бүх түвшинд;

(ii) аль нэг Талын засгийн газрын буюу эрх бүхий байгууллагын бүх түвшинд бүрэн эрхийнхээ хүрээнд олгосон эрхийг хэрэгжүүлж буй төрийн бус байгууллагын;

(g) “аль нэг Талын үйлчилгээний худалдаанд нөлөөлөх арга хэмжээ” гэх нэр томьёо нь дараахтай холбоотой арга хэмжээг хэлнэ.

(i) үйлчилгээний худалдан авалт, төлбөр тооцоо буюу хэрэглээ;

(ii) тухайн Талын олон нийтэд санал болгодог энгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан шаарддаг үйлчилгээнд нэвтрэх ба уг үйлчилгээг хэрэглэх;

(iii) аль нэг Талын нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэхээр нөгөө Талын этгээдүүд оршин байх, түүний дотор арилжааны төлөөлөл хамаарна.

(h) “дангаар ноёрхох үйлчилгээ үзүүлэгч” гэх нэр томьёо нь аль нэг Талын тухайн зах зээлд тухайн үйлчилгээний цорын ганц үйлчилгээ үзүүлэгч болгон албан ёсоор, эсхүл нөлөөлөх байдлын бүрэн эрх олгосон, эсхүл байгуулсан төрийн, эсхүл хувийн аливаа этгээдийг хэлнэ;

(i) “аль нэг Талын хувь хүн” гэх нэр томьёо нь тухайн Талын хуульд заасан аль нэг Талын иргэнийг хэлнэ;

- (j) “агаарын тээврийн үйлчилгээний худалдаа ба маркетинг” гэх нэр томьёо нь өөрийн агаарын тээврийн үйлчилгээ, түүний дотор зах зээл судлах, сурталчлах, түгээх зэрэг маркетингийн бүх үйлчилгээг чөлөөтэй худалдах ба борлуулах талаар холбогдох агаарын тээвэрлэгчид олгосон боломжийг хэлнэ. Агаарын тээврийн үйлчилгээний үнэлгээ, зохих нөхцөл нь эдгээр үйл ажиллагаанд үл хамаарна;
- (k) “Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд үзүүлж буй үйлчилгээ” гэх нэр томьёо нь арилжааны бус зорилгоор, нэг буюу түүнээс дээш үйлчилгээ үзүүлэгчтэй өрсөлдөхгүйгээр үзүүлж буй аливаа үйлчилгээг хэлнэ;
- (l) “үйлчилгээ үзүүлэх” гэх нэр томьёо нь үйлдвэрлэх, түгээх, маркетинг хийх, худалдан борлуулах, үйлчилгээ хүргэхэд хамаарна;
- (m) “үйлчилгээний худалдаа” гэх нэр томьёо нь дараахь төрлийн үйлчилгээ үзүүлэхийг хэлнэ:
 - (i) аль нэг Талын нутаг дэвсгэрээс нөгөө Талын нутаг дэвсгэрт (“хил дамнасан худалдаа”);
 - (ii) аль нэг Тал өөрийн нутаг дэвсгэртээ нөгөө Талын хэрэглэгчдэд үйлчлэх (“Хилийн чанад дахь үйлчилгээ”);
 - (iii) аль нэг Талын үйлчилгээ үзүүлэгч нөгөө Талын нутаг дэвсгэрт буй арилжааны төлөөллөөр дамжуулан үйлчилгээ үзүүлэх (“арилжааны төлөөлөл”);
 - (iv) аль нэг Талын үйлчилгээ үзүүлэгч нөгөө Талын нутаг дэвсгэрт буй өөрийн Талын хувь хүний төлөөллөөр дамжуулан үйлчилгээ үзүүлэх (“хувь хүний оролцоо”);

(н) “тээвэрлэлтийн эрх” гэх нэр томъёо нь үйлчлэх цэг, үйл ажиллагааны маршрут, тээвэр хийх нислэгийн төрөл, хангахуйц хүчин чадал, ногдуулах төлбөр ба нөхцөл, тоо хэмжээ, өмчлөл болон хяналт зэрэг агаарын хөлөг нисэхэд тавих шалгуурыг хангасан аль нэг Талаас нөгөө Тал руу, аль нэг Талын дотор, эсхүл аль нэг Талаар дамжуулан зорчигч, ачаа, шууданг төлбөртэйгээр, эсхүл хөлсөөр тээвэрлэх болон/буюу үйл ажиллагаа явуулах хуваарьт болон хуваарьт бус үйлчилгээ эрхлэх эрхийг хэлнэ.

7.3 дугаар зүйл Үндэсний нөхцөл

1.6 дугаар хавсралтад заасан тусгай үүрэг амлалтын жагсаалтад тусгасан салбар болон түүнд тусгасан аливаа нөхцөл, шаардлагын дагуу Тал бүр үйлчилгээ үзүүлэхэд нөлөөлөхүйц бүх арга хэмжээний хувьд нөгөө Талын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдэд өөрийн ижил төрлийн үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдэд олгосноос дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

Тайлбар: Энэ зүйлд заасны дагуу тусгай үүрэг амлалт нь тухайн үйлчилгээ, эсхүл гадаадын үйлчилгээ үзүүлэгчийн шинж чанараас үүдэн аливаа уламжлалт өрсөлдөөнд давуу талаа алдасны хохирлыг нөхөх талаар аль нэг Тал шаардлага тавих байдлаар тайлбарлаж үл болно.

2. Аль нэг Тал нь нөгөө Талын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдэд өөрийн ижил төрлийн үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдэд олгосноос албан ёсны ижил эсхүл ялгаатай нөхцөл олгох замаар 1 дэх хэсгийн шаардлагыг биелүүлж болно.

3. Албан ёсны ижил, эсхүл ялгаатай нөхцөлийг хэрэв нөгөө Талын ижил төрлийн үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчтэй харьцуулахад аль нэг Талын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчийг илүүд үзэж өрсөлдөөний нөхцөлийг ашигтайгаар өөрчилж байвал түүнийг тааламж багатайд тооцно.

7.4 дүгээр зүйл Нэн тааламжтай үндэстний нөхцөл

1. Тал бүр нөгөө Талын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчидэд энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын ижил төрлийн үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдэд олгосноос дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

2. Тал бүр дээрх 1 дэх хэсэгт нийцэхгүй арга хэмжээг 6 дугаар хавсралтад тусгасан нэн тааламжтай үндэстний нөхцөл үл үйлчлэх жагсаалтад оруулсан бөгөөд уг жагсаалтад оруулах шаардлага, нөхцөлийг хангасан тохиолдолд хэрэгжүүлж болно.

7.5 дугаар зүйл

Зах зээлд нэвтрэх

1. 7.2 дугаар зүйлийн (m) дэд хэсэгт заасан үйлчилгээний хэлбэрээр дамжин зах зээлд нэвтрэх тухайд аль нэг Тал нөгөө Талын үйлчилгээ, үйлчилгээ үзүүлэгчдэд 6 дугаар хавсралтад заасан өөрийн Талын Тусгай үүрэг амлалтын жагсаалтад тохирсон болзол, хязгаарлалт, нөхцөлийн дагуу олгож байгаагаас дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

Тайлбар: Хэрэв аль нэг Тал 7.2 дугаар зүйлийн (m) дэд хэсгийн (i)-д заасан үйлчилгээний хэлбэр бүхий үйлчилгээ үзүүлэх талаар зах зээлд нэвтрүүлэх үүрэг амлалт хүлээсэн бөгөөд хөрөнгийн хил дамнасан хөдөлгөөн нь тухайн үйлчилгээний салшгүй хэсэг бол тухайн Тал уг хөрөнгийн хөдөлгөөнийг зөвшөөрөх үүрэг хүлээнэ. Хэрэв аль нэг Тал 7.2 дугаар зүйлийн (m) дэд хэсгийн (iii)-д заасан үйлчилгээний хэлбэр бүхий үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан зах зээлд нэвтрүүлэх үүрэг амлалт хүлээсэн бол өөрийн нутаг дэвсгэрт хөрөнгийн холбогдох шилжүүлгийг зөвшөөрөх үүрэг хүлээнэ.

2. 6 дугаар хавсралтад заасан Тусгай үүрэг амлалтын жагсаалтад өөрөөр заагаагүй бол аль нэг Тал нь зах зээлд нэвтрүүлэх үүрэг амлалт хүлээсэн салбарт бүс нутгийн хэмжээнд, эсхүл өөрийн бүх нутаг дэвсгэрт дараахь арга хэмжээг баталж, эсхүл мөрдүүлж үл болно:

- (a) тоо хэмжээний хязгаар, дангаар ноёрхол, онцгой үйлчилгээ үзүүлэгч, эсхүл эдийн засгийн хэрэгцээг нотлох шаардлагын хэлбэрээр үйлчилгээ үзүүлэгчийн тоог хязгаарлах;
- (b) тоо хэмжээний хязгаар, эсхүл эдийн засгийн хэрэгцээг нотлох шаардлагын хэлбэрээр үйлчилгээний шилжүүлгийн буюу хөрөнгийн нийт үнийн дүнг хязгаарлах;

- (с) Тоо хэмжээний хязгаар, эсхүл эдийн засгийн хэрэгцээг нотлох шаардлагын хэлбэрээр үйлчилгээний ажлын нийт тоог, эсхүл үзүүлсэн үйлчилгээний ерөнхий хэмжээг тодорхой тоон нэгжээр илэрхийлсэн нийт хэмжээг хязгаарлах;

Тайлбар: Энэ заалт нь аль нэг Талын үйлчилгээний бүрдэлд тавих хязгаарлалтын арга хэмжээнд хамаарахгүй.

- (d) үйлчилгээний тодорхой салбарт ажил эрхлүүлэх эсхүл үйлчилгээ үзүүлэгч хөлсөөр ажиллуулах хувь хүний тоо, мөн тодорхой үйлчилгээ үзүүлэхэд зайлшгүй шаардлагатай бөгөөд шууд хамааралтай хувь хүний тоог хязгаарлах, эсхүл эдийн засгийн хэрэгцээний шаардлагын дагуу хязгаарлах;
- (e) үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээгээр дамжуулан хуулийн этгээд, эсхүл хамтарсан үйлдвэрийн онцгой хэлбэрийг хязгаарлах, эсхүл шаардах арга хэмжээ;
- (f) хувь хүний, эсхүл хувь нийлүүлсэн гадаадын хөрөнгө оруулалтын нийт дүн буюу гадаадын хувь эзэмшигчийн оролцооны дээд хувийг заах байдлаар гадаадын хөрөнгийн оролцоог хязгаарлах.

7.6 дугаар зүйл Нэмэлт үүрэг, амлалт

Талууд 7.3 болон 7.5 дугаар зүйлийн дагуу гаргасан жагсаалтад тусгаагүй үйлчилгээний худалдаанд нөлөөлөхүйц арга хэмжээ, түүний дотор мэргэшил, стандарт, эсхүл лицензийн асуудалтай холбоотой арга хэмжээний талаар үүрэг амлалт хүлээхээр хэлэлцээ хийж болно. Ийм үүрэг, амлалтыг 6 дугаар хавсралтад заасан Тусгай үүрэг амлалтын жагсаалтад тусгана.

7.7 дугаар зүйл Тусгай үүрэг амлалтын жагсаалт

1. Тал бүр 7.3, 7.5 болон 7.6 дугаар зүйлийн дагуу өөртөө хүлээсэн үүрэг амлалтыг жагсаалтад тусгана. Ийм үүрэг амлалт хүлээж буй салбар, эсхүл дэд салбарын хувьд 6 дугаар хавсралтад заасан Тусгай үүрэг амлалтын жагсаалтыг дараахь байдлаар тодорхойлно:

- (a) зах зээлд нэвтрүүлэхтэй холбогдсон болзол, хязгаарлалт, нөхцөл;
- (b) үндэсний нөхцөлийн талаарх нөхцөл, шаардлага;

(c) нэмэлт үүрэг амлалттай холбоотой арга хэмжээ;

(d) шаардлагатай бол, эдгээр үүрэг амлалтыг биелүүлэх цаг хугацааны хязгаар.

2. Тусгай үүрэг амлалт хүлээсэн салбар буюу дэд салбар болон “SS” тэмдэглэгээний тухайд цагаачлал болон зорчих тухай хууль тогтоомжид заасан арга хэмжээнээс бусад тохиолдолд 1(a) болон 1(b) дэд хэсэгт дурдсан аливаа болзол, хязгаарлалт, нөхцөл, мэргэжлийг хүчин төгөлдөр мөрдөж буй үл нийцэх арга хэмжээнд үндэслэн хязгаарлана.

3. 7.3 болон 7.5 дугаар зүйлтэй үл нийцэх арга хэмжээг 7.5 дугаар зүйлийн холбогдох хүснэгтэд тусгана. Энэ тохиолдолд уг бичилтийг 7.3 дугаар зүйлийн талаарх нөхцөл, эсхүл шаардлагын тайлбарын заалт гэж мөн үзнэ.

7.8 дугаар зүйл Дотоодын зохицуулалт

1. Тал бүр үйлчилгээний худалдаанд нөлөөлөх нийтлэг хэрэглээний бүх арга хэмжээг үндэслэлтэй, бодит, шударга байдлаар хэрэглэх явдлыг хангана.

2. Үйлчилгээ үзүүлэхэд аль нэг Тал зөвшөөрөл олгох шаардлагатай бол тухайн Талын эрх бүхий байгууллага нь үндэсний хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор бүрдсэн гэж үзэж болох өргөдлийг хүлээн авснаас хойш үндэслэлээ боломжийн хугацааны дотор өргөдлийн талаар гарсан шийдвэрийг өргөдөл гаргагчид мэдээлнэ. Өргөдөл гаргагчийн хүсэлтээр тухайн Талын зохих эрх бүхий байгууллага өргөдлийг авч үзэж буй явцын талаар шударга мэдээлж байна.

3. Нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл, мэргэжлийн шаардлага болон журам, техникийн стандарт, лицензийн шаардлагатай холбоотой аливаа үйлчилгээний салбарт аль нэг Талын баталсан, эсхүл хэрэгжүүлж буй аливаа арга хэмжээ нь үйлчилгээний худалдаанд шаардлагагүй саад тотгор үүсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дээрх арга хэмжээний хувьд Тал бүр дараахь шаардлагыг хангасан байна:

(a) үйлчилгээг нийлүүлэх ур чадвар, боломж зэрэг бодит, ил тод шалгуурт үндэслэсэн байх;

(b) үйлчилгээний чанарыг хангахад шаардлагатайгаас илүү хүндрэл учруулахгүй байх;

(с) үйлчилгээ үзүүлэхэд нуугдмал хязгаарлалт хийж саад учруулахгүй байх.

7.9 дүгээр зүйл Хүлээн зөвшөөрөх

1. Аль нэг Тал нь нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчид зөвшөөрөл, лиценз, эсхүл гэрчилгээ олгоход тавих стандарт, эсхүл шаардлагыг бүхлээр нь, эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлэх зорилгоор нөгөө Талд эзэмшсэн боловсрол, эсхүл хуримтлуулсан туршлага, хэрэгжүүлсэн шаардлага, эсхүл олгосон лиценз, эсхүл гэрчилгээг хүлээн зөвшөөрч болно.

2. 1 дэх хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөх явдлыг уялдуулах, эсхүл өөр аргаар хэрэгжүүлж болох бөгөөд Талуудын хооронд хэлэлцээр байгуулах, эсхүл тохиролцоонд тулгуурлах, эсхүл өөрөө дангаар олгож болно.

3. Хэрэв аль нэг Тал энэхүү хэлэлцээрийн оролцогч бус талтай хэлэлцээрээр буюу тохиролцоогоор, эсхүл өөрөө дангаар энэхүү хэлэлцээрийн оролцогч бус талд эзэмшсэн боловсрол буюу хуримтлуулсан туршлага, хэрэгжүүлсэн шаардлага, эсхүл олгосон лиценз буюу гэрчилгээг хүлээн зөвшөөрвөл:

- (a) 7.4 дүгээр зүйл нь Тухайн тал нөгөө Талд эзэмшсэн боловсрол буюу хуримтлуулсан туршлага, хэрэгжүүлсэн шаардлага, эсхүл олгосон лиценз буюу гэрчилгээг тийнхүү хүлээн зөвшөөрөхийг шаардана гэж ойлгохгүй;
- (b) тухайн Тал нь нөгөө Талыг ийм хэлэлцээр, эсхүл тохиролцоонд нэгдэх хэлэлцээ хийх, эсхүл Талуудын хооронд үүнтэй төсөөтэй хэлэлцээ хийх хангалттай боломжийг нөгөө Талд олгоно;
- (c) хэрэв тухайн Тал өөрөө дангаар хүлээн зөвшөөрсөн бол тухайн Тал нөгөө Талд эзэмшсэн боловсрол, эсхүл хуримтлуулсан туршлага, хэрэгжүүлсэн шаардлага, эсхүл олгосон лиценз буюу гэрчилгээг мөн хүлээн зөвшөөрөх ёстойг нотлох хангалттай боломжийг нөгөө Талд олгоно.

7.10 дугаар зүйл

Дангаар ноёрхол ба онцгой үйлчилгээ үзүүлэгч

1. Аль нэг Тал бүр өөрийн нутаг дэвсгэр дээр дангаар ноёлох үйлчилгээ үзүүлэгч аливаа этгээд нь тухайн зах зээл дээр дангаар үйлчилгээ үзүүлэхдээ 7.3, 7.4 болон 7.5 дугаар зүйлийн дагуу тухайн Талын хүлээсэн үүрэг амлалттай үл нийцэх байдлаар үйл ажиллагаа явуулахгүй байх явдлыг хангана.

2. Хэрэв аль нэг Талын дангаар ноёлох үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн Талын Тусгай үүрэг амлалт хүлээсэн нутаг дэвсгэр дээр дангаар ноёрхох эрх хэмжээний хүрээнээс гадуур шууд, эсхүл охин компаниараа дамжуулан үйлчилгээ үзүүлэхээр өрсөлдөж буй бол тухайн Тал өөрийн нутаг дэвсгэрт дангаар ноёлох байдлыг буруугаар ашигласнаар 7.3 болон 7.5 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэг амлалттай үл нийцэх байдлаар ажиллахгүй байх явдлыг хангана.

3. Хэрэв аль нэг Тал нөгөө Талын дангаар ноёлох үйлчилгээ үзүүлэгч нь 1, эсхүл 2 дахь хэсэгтэй нийцэхгүй байдлаар үйл ажиллагаа явуулж байгааг үндэслэл бүхий гэж үзэж байгаа бол тухайн Тал нөгөө Талыг холбогдох ажиллагааны талаар тодорхой мэдээлэл гаргаж өгөхийг хүсч болно.

4. Аль нэг Тал албан ёсоор, эсхүл нөлөөлөх байдлаар дараахь тохиолдолд энэ зүйлийг тусгай үйлчилгээ үзүүлэгчид мөн хэрэглэнэ:

- (a) цөөн тооны үйлчилгээ үзүүлэгчид эрх олгосон буюу түүнийг байгуулсан;
- (b) өөрийн нутаг дэвсгэр дээр тийм үйлчилгээ үзүүлэгчдийн дундах өрсөлдөөнийг үлэмж хэмжээгээр хязгаарладаг.

7.11 дүгээр зүйл

Бизнесийн үйл ажиллагаа

1. Үйлчилгээ үзүүлэгчдийн 7.10 дугаар зүйлд дурдсанаас бусад төрлийн зарим бизнесийн үйл ажиллагаа нь өрсөлдөөнийг сааруулж, улмаар үйлчилгээний худалдааг хязгаарлах магадлалтай гэдгийг Талууд хүлээн зөвшөөрнө.

2. Аль нэг Тал нь 1 дүгээр хэсэгт дурдсан үйл ажиллагааг арилгах зорилгоор нөгөө Талын хүсэлтээр зөвлөлдөөн хийнэ. Хүсэлт хүлээн авсан Тал нь тухайн хүсэлтэд анхааралтай, нааштай хандах бөгөөд тухайн асуудлаар олон нийтэд нээлттэй, нууц бус мэдээлэл өгөх замаар хамтран ажиллана. Хүсэлт хүлээн авсан Тал өөрийн хууль тогтоомжийнхоо дагуу түүнчлэн өөрийн мэдээллийн нууцыг хамгаалах талаар хүсэлт гаргасан Талтай хангалттай тохиролцоонд хүрсэн тохиолдолд бусад нээлттэй мэдээллийг хүсэлт гаргасан Талд өгнө.

7.12 дугаар зүйл

Төлбөр болон шилжүүлэг

1. 7.13 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд аль нэг Тал үйлчилгээний худалдаатай холбоотой урсгал гүйлгээний олон улсын шилжүүлэг, төлбөр тооцоонд хязгаарлалт хэрэглэхгүй.

2. Энэхүү бүлгийн аль ч заалт нь Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн зүйлүүдийн дагуу Олон улсын валютын сангийн гишүүны хувьд Талуудын хүлээсэн эрх үүрэг, түүний дотор Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн зүйлүүдтэй нийцсэн гүйлгээг хөндөхгүй. Гэхдээ 7.13 дугаар зүйлд дурдсан, эсхүл Олон улсын валютын сангийн хүсэлт болгосноос бусад тохиолдолд аль ч Тал өөрийн Тусгай үүрэг амлалтаа зөрчин аливаа хөрөнгийн гүйлгээнд хязгаарлалт тавихгүй байвал зохино.

7.13 дугаар зүйл

Төлбөрийн тэнцлийг хамгаалах зорилгоор хийх хязгаарлалт

1. Төлбөрийн тэнцэл, гадаад санхүүгийн байдал ноцтой хүндэрсэн буюу хүндрэх аюул тулгарсан тохиолдолд тухайн Тал үйлчилгээний худалдаанд, тухайлбал гүйлгээний төлбөр, шилжүүлгийн талаар хязгаарлалт тогтоох буюу үргэлжлүүлэн мөрдөж болно.

2. 1 дэх хэсэгт дурдсан хязгаарлалт нь:

- (a) үндэсний нөхцөл, Нэн тааламжтай үндэстний нөхцөлд үндэслэсэн байх учиртай;
- (b) Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн зүйлд нийцсэн байна;
- (c) нөгөө Талын худалдаа, эдийн засаг, санхүүгийн ашиг сонирхолд шаардлагагүй хохирол учруулахаас зайлсхийх ёстой;

(d) 1 дэх хэсэгт дурдсан нөхцөл байдлын шаардлагын хүрээнээс халих ёсгүй;

(e) түр шинжтэй бөгөөд 1 дэх хэсэгт дурдсан нөхцөл байдал сайжрахын хэрээр аажмаар арилна.

3. Ийм хязгаарлалтын үйлчлэх хүрээг тодорхойлохдоо аль нэг Тал өөрийн эдийн засгийн, эсхүл хөгжлийн хөтөлбөрт илүү чухал үйлчилгээ үзүүлэхэд түлхүү ач холбогдол өгч болно. Гэхдээ тухайн хязгаарлалтыг үйлчилгээний тодорхой салбарыг хамгаалах зорилгоор батлах эсхүл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхгүй.

4. 1 дэх хэсгийн дагуу тогтоосон, эсхүл мөрдөж буй аливаа хязгаарлалт, эсхүл тэдгээрт орсон аливаа өөрчлөлтийн талаар нөгөө Талд шуурхай мэдэгдэнэ.

7.14 дүгээр зүйл **Ил тод байдал**

Тал бүр бүх салбарт 7.3, 7.4 болон 7.5 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүрэг амлалтад нөлөөлөхүйц холбогдох бүх арга хэмжээг тусгасан эрх зүйн ямар нэг үр дагавар үүсгэхгүй жагсаалтыг гаргана. Тухайн жагсаалтыг энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш таван жилийн дотор боловсруулж, нөгөө Талтайгаа солилцохоос гадна олон нийтэд нээлттэй болгох бөгөөд шаардлагатай тохиолдолд, эсхүл Талууд харилцан тохиролцсон тохиолдолд уг жагсаалтыг дахин хянаж, өөрчилж болно. Энэ жагсаалт нь дараахь мэдээллийг агуулсан байна:

(a) салбар, дэд салбар, эсхүл хамаарах асуудал;

(b) үл нийцэж буй хэлбэр (өөрөөр хэлбэл, үндэсний нөхцөл, үндэстний нэн таатай нөхцөл, болон/эсхүл зах зээлд нэвтрэхтэй холбоотой);

(c) тухайн арга хэмжээг бий болгосон хуулийн эх сурвалж, эсхүл эрх бүхий байгууллага;

(d) уг арга хэмжээний талаарх товч танилцуулга.

Тайлбар: Энэ зүйлийн дагуух жагсаалтыг зөвхөн ил тод байдлыг хангах зорилгоор гаргаж буй бөгөөд энэ бүлгийн дагуу Талуудын хүлээсэн эрх болон үүрэг, амлалтыг хөндөхгүй. Энэхүү зүйлийн дагуу тухайн жагсаалтыг цаашид ямар нэг байдлаар дахин хянаж, өөрчлөх явдал нь зөвхөн тухайн жагсаалтыг шинэчлэх зорилгоор авч буй хэрэг юм.

7.15 дугаар зүйл **Ашгаас татгалзах**

1. Аль нэг Тал нөгөө Талын хуулийн этгээд болох нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчийг энэхүү хэлэлцээрийн оролцогч бус талын хуулийн этгээд эзэмшдэг, эсхүл хяналтад байж болохыг тогтоосон бөгөөд татгалзагч тал нь дор дурдсан нөхцөлийг хангаж буй бол тухайн хуулийн этгээдэд энэ бүлгийн хүрээнд ашиг олгохоос татгалзаж болно:

- (a) энэхүү хэлэлцээрт оролцогч бус талтай дипломат харилцаа тогтоогоогүй;
- (b) энэхүү хэлэлцээрт оролцогч бус Талтай холбогдуулан дараахь арга хэмжээг баталсан, эсхүл мөрдөн хэрэгжүүлж буй бол:
 - (i) дурдсан хуулийн этгээдтэй гүйлгээ хийхийг хориглосон;
 - (ii) дурдсан хуулийн этгээд энэ бүлгийн хүрээнд ашиг хүртсэн бол энэхүү арга хэмжээг зөрчсөн, эсхүл зайлсхийсэн болох.

2. Нөгөө Талын хуулийн этгээд болох нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчийг энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хуулийн этгээд эзэмшдэг, эсхүл хяналтад байдаг, улмаар нөгөө Талын нутаг дэвсгэр дээр дорвитой бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй болохыг тогтоосон тохиолдолд урьдчилан мэдэгдэж, зөвлөлдсөн нөхцөлд тухайн Тал дурдсан хуулийн этгээдэд энэ бүлгийн ашгийг олгохоос татгалзаж болно.

7.16 дугаар зүйл **Үйлчилгээний худалдааны дэд хороо**

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд үйлчилгээний худалдааны дэд хороо (цаашид энэ зүйлд “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэхүү бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) энэхүү бүлэгтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэх;
- (c) Дэд хорооны хэлэлцүүлгийн үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;
- (d) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

7.17 дугаар зүйл **Үүрэг амлалтыг хянан үзэх**

1. Талуудын хоорондын үйлчилгээний худалдааг цаашид илүү чөлөөлөх, түүний дотор үүрэг амлалтын жагсаалтын хэлбэрийн талаар дахин хэлэлцээ хийх боломжийг бүрдүүлэх зорилгоор Талууд харилцан тохиролцсон тохиолдолд энэ бүлэг, түүний холбогдох хавсралтыг дахин хянан үзэх талаар зохих хугацаанд авч үзнэ.

2. Хэрэв энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа аль нэг Тал өөрийн аливаа үйлчилгээний салбар, дэд салбар, эсхүл үйл ажиллагааг илүү чөлөөлөх арга хэмжээг дангаар авч хэрэгжүүлэх бол тэрээр нөгөө Талаас энэхүү хэлэлцээрт ийнхүү улам чөлөөтэй болгохыг тусгах хүсэлтийг зохих хугацаанд харгалзан үзнэ.

8 дугаар бүлэг

Хувь хүний шилжилт хөдөлгөөн

8.1 дүгээр зүйл

Ерөнхий зарчим

1. Талууд хоорондын давуу эрх олгосон худалдааны харилцаа, түүнчлэн харилцан ашигтай байдалд үндэслэн хувь хүний хилээр нэвтрэх, түр оршин суух явдлыг хөнгөвчлөх болон хилээр нэвтрэх, түр оршин суухад тавих шаардлага, журмыг ил тод болгох, мөн Талуудын хилийн аюулгүй байдлыг хангах, Тал бүрийн дотоодын ажиллах хүч, байнгын хөдөлмөр эрхлэлтийг хамгаалах хэрэгцээ зэрэг Талуудын эрмэлзлэлийг энэхүү бүлэгт тусгасан.

2. Тал бүр энэхүү бүлгийн заалттай холбоотой арга хэмжээг 1 дэх хэсэгт дурдсан ерөнхий зарчмын дагуу хэрэгжүүлэх бөгөөд ялангуяа энэхүү хэлэлцээрийн хүрээнд барааны буюу үйлчилгээний худалдаа, эсхүл хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зүй бусаар хохирол учруулах, эсхүл саатуулах явдлаас сэргийлэх үүднээс тэдгээр арга хэмжээг шуурхай хэрэгжүүлнэ.

8.2 дугаар зүйл

Хамрах хүрээ

1. Энэхүү бүлэг нь нөгөө Талын хилээр нэвтэрч буй бөгөөд 8.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан ангилалд хамаарах аль нэг Талын хувь хүний хилээр нэвтрэх, түр оршин суухтай холбоотой арга хэмжээнд үйлчилнэ.

2. Энэхүү бүлэг нь нөгөө Талын хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх боломж эрэлхийлж буй аль нэг Талын хүвч хүнд нөлөөлөхүйц арга хэмжээ, түүнчлэн иргэн буюу харьяат, эсхүл байнга оршин суух буюу хөдөлмөр эрхлэхтэй холбоотой арга хэмжээнд хамаарахгүй.

3. Энэхүү бүлэг нь аль нэг Тал өөрийн хилийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, хилээр нэвтрэх хувь хүний шилжилт хөдөлгөөний эмх замбараатай байдлыг хангах зэргээр нөгөө Талын хувь хүнийг хилээр нэвтрүүлэх, түр оршин суух асуудлыг зохицуулах арга хэмжээ авахад саад учруулахгүй бөгөөд эдгээр арга хэмжээг авахдаа 7 дугаар хавсралтад дурдсан тусгай үүрэг амлалтын нөхцөлийн дагуу нөгөө Талд олгож буй ашгийг үгүйсгэх, эсхүл бууруулах байдлаар хэрэгжүүлж болохгүй.

Тайлбар: Энэхүү хэлэлцээрт оролцогч бус зарим талын хувь хүнийг виз авах шаардлагаас чөлөөлж, нөгөө Талын хувь хүнд виз авах шаардлага тавих дан ганц нөхцөлийг 7 дугаар хавсралтад дурдсан тусгай үүрэг амлалтын нөхцөлийн дагуу олгож буй ашгийг үгүйсгэсэн, эсхүл бууруулсанд тооцохгүй.

8.3 дугаар зүйл Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор “аль нэг Талын хувь хүн” гэх нэр томьёо нь аль нэг Талд, эсхүл өөр бусад газар оршин суудаг хувь хүн болон тухайн Талын хуулийн дагуу иргэн нь болох хүнийг хэлнэ.

8.4 дүгээр зүйл Тусгай үүрэг амлалт

1. Тал бүр дараахь этгээдийн талаар хүлээсэн тусгай үүрэг амлалтыг 7 дугаар хавсралтад тусгав:

- (a) нөгөө Талын богино хугацаагаар зорчих бизнес эрхлэгчид;
- (b) нөгөө Талын корпорацийн дотор шилжин ажиллагсад;
- (c) нөгөө Талын хөрөнгө оруулагч нар;
- (d) нөгөө Талын мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч хувь хүн;
- (e) төрийн, эсхүл хувийн байгууллагатай хийсэн гэрээний дагуу ахисан түвшний технологи, эсхүл мэдлэг шаардсан үйлчилгээг тухайн Талд үзүүлдэг нөгөө Талын хувь хүн;
- (f) дээр дурдсан (b)-гээс (e) хүртэлх дэд хэсэгт заасан эдгээр хувь хүнийг дагалдан яваа эхнэр, нөхөр, хүүхэд.

2. 7 дугаар хавсралтад заасан нөхцөл, болзолын дагуу 1 дэх хэсэгт дурдсан ангилалд хамаарах хувь хүнийг энэ бүлгийн заалттай үл нийцэх цагаачлал болон зорчих тухай холбогдох хууль тогтоомжийн дагуу хилээр нэвтрэх, түр оршин суух боломжтой гэж үзвэл тухайн хувь хүнд хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрлийг олгоно.

3. Аль ч Тал 1 дэх хэсгийн дагуу хилээр нэвтрэх, түр оршин суух зөвшөөрөл олгохдоо хувь хүний тоонд ямар нэгэн хязгаарлалт тогтоох, эсхүл мөрдүүлэх арга хэмжээ авахгүй.

8.5 дугаар зүйл Шаардлага болон журам

1. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр Тал бүр нөгөө Талд 7 дугаар хавсралтаар тухайн Талын хүлээсэн тусгай үүрэг амлалтад хамрах хувь хүний талаар дараахь зорилгоор нөгөө Талын хувь хүн хууль ёсны өргөдөл гаргахад хэрэгтэй шаардлага, журамтай холбоотой мэдээллийг нийтлэх, эсхүл нөгөө талын олон нийтэд нээлттэй болгоно:

- (a) тухайн Талд хилээр нэвтрэх;
- (b) тухайн Талд эхний удаад түр оршин суух;
- (c) тухайн Талд түр оршин суух зөвшөөрлөө шинэчлэх;
- (d) зохистой тохиолдолд тухайн Талд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсэх;
- (e) тухайн Талд түр оршин суух зөвшөөрлийн хэлбэрээ өөрчлөх.

2. Тал бүр нөгөө Талын хувь хүний хүсэлтийн дагуу 1 дэх хэсэгт дурдсан шаардлага, журамтай холбоотой мэдээллээр хангахыг эрмэлзэнэ.

3. Тал бүр дээр дурдсан (a)–аас (e) хүртэлх дэд хэсгийн дагуу нөгөө Талын хувь хүн хилээр нэвтрэх, түр оршин суух, эсхүл зөвшөөрөл хүсэх талаар хүчинтэй өргөдөл гаргахтай холбоотой шаардлага, журмыг шинээр тогтоосон, эсхүл 1 дэх хэсэгт дурдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй аливаа шаардлага, журамд өөрчлөлт оруулсан бол энэ тухайгаа нөгөө Талд нэн даруй мэдэгдэхийг эрмэлзэнэ.

4. Тал бүр 1 дэх хэсэгт дурдсан өргөдөлд холбогдох эрх бүхий байгууллагын ногдуулж буй төлбөр нь дангаар энэ бүлгийн дагуу нөгөө Талын хувь хүн тухайн Талын хилээр нэвтрэх, түр оршин суухад үндэслэлгүй саад тотгор учруулахгүй байх явдлыг хангаж ажиллана.

5. Тал бүр өөрийн хууль тогтоомжийн хүрээнд нөгөө Талын хувь хүний хилээр нэвтрэх, түр оршин суухтай холбоотой шаардлагыг хялбарчлах, журмыг хөнгөвчлөх, шат дамжлагыг шуурхай болгоход чиглэсэн арга хэмжээг боломжийн хирээр хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

8.6 дугаар зүйл

Хувь хүний шилжилт хөдөлгөөний дэд хороо

1. Энэ бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд хувь хүний шилжилт хөдөлгөөний дэд хороо (цаашид энэ зүйлд “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэ бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) хувь хүний хилээр нэвтрэх, түр оршин суухыг харилцан хөхиүлэн дэмжихэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэх;
- (c) 7 дугаар хавсралтад дурдсан хувь хүний хилээр нэвтрэх, түр оршин суухтай холбоотой арга хэмжээний талаар мэдээлэл солилцох;
- (d) харилцан тохиролцсон энэ бүлэгтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэх;
- (e) Дэд хорооны хэлэлцүүлгийн үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;
- (f) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

8.7 дугаар зүйл

Маргаан шийдвэрлэх

1. 16 дугаар бүлэгт дурдсан маргаан шийдвэрлэх журам энэ бүлэгт дараахаас бусад тохиолдолд хамаарахгүй:

- (a) үйл ажиллагааны шинжтэй хэрэг;
- (b) аль нэг Талын тодорхой асуудалд өртсөн хувь хүн нь нөгөө Талын дотоодын захиргааны хамгаалалтын боломжтой бүх арга хэмжээг хэрэглэсэн.

2. 1(b) дэд хэсэгт дурдсан хамгаалалтын арга хэмжээг нөгөө Талын холбогдох эрх бүхий байгууллага захиргааны арга хэмжээг хэрэгжүүлснээс хойш нэг жилийн дотор тухайн асуудалтай холбоотой эцсийн шийдвэр гараагүй ба ийм шийдвэрийг гаргаж чадаагүй явдал нь хувь хүнээс үл хамааралтай бол тухайн бүх хамгаалалтын арга хэмжээг авсан гэж үзнэ.

9 дүгээр бүлэг Цахим худалдаа

9.1 дүгээр зүйл Ерөнхий заалт

1. Талууд цахим худалдаанаас бий болсон эдийн засгийн өсөлт болон боломжууд, мөн түүний ашиглалт болон хөгжилд учирч буй саад бэрхшээлээс зайлсхийхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч байна.

2. Энэхүү бүлгийн зорилго нь цахим худалдааг ашиглахад найдвартай болон итгэлтэй орчин бий болгох, мөн Талуудын хооронд цахим худалдаа хийх болон цахим худалдааг дэлхий дахинд өргөнөөр ашиглах явдалд дэмжлэг үзүүлэхэд оршино.

3. Талууд цахим худалдаанд технологиос үл хамаарах зарчим мөрдөхийг хүлээн зөвшөөрч байна.

4. Энэ бүлэг нь 2, 7, 10, эсхүл 12 дугаар бүлэгтэй үл нийцэх аливаа тохиолдолд нийцэхгүй буй асуудлын хүрээнд энэхүү бүлгээс бусад Бүлгийг дагаж мөрдөнө.

9.2 дугаар зүйл Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор:

- (a) “тоон бүтээгдэхүүн” гэх нэр томьёо нь тээгч хэрэгсэлд суулгасан, эсхүл цахим хэлбэрээр дамжуулсан эсэхээс үл хамааран, тоон хувиргалт хийгдсэн компьютерийн програм хангамж, текст, дүрс бичлэг, зураг, дуу бичлэг болон бусад бүтээгдэхүүнийг хэлнэ;
- (b) “цахим гэрчилгээ” гэх нэр томьёо нь хэрэглэгч цахим гарын үсэг хэрэглэснийг баталгаажуулахад ашигласан мэдээлэл нь тухайн хэрэглэгчид хамааралтай болохыг гэрчлэх зорилгоор бэлтгэсэн цахилгаан соронзон бичлэгийг хэлнэ;
- (c) “цахим гарын үсэг” гэх нэр томьёо нь цахилгаан соронзон бичлэгт хадгалах боломжтой мэдээллийн хувьд авч хэрэгжүүлсэн болон дараахь хоёр шаардлагыг хангаж буй арга хэмжээг хэлнэ:

- (i) тухайн арга хэмжээ нь түүнийг авч хэрэгжүүлсэн этгээд баталгаажуулсан мэдээллийг илтгэж байх;
- (ii) тухайн арга хэмжээ нь уг мэдээлэл өөрчлөгдөөгүй болохыг батлан илэрхийлж байх;
- (d) “худалдааны мэдээлэл хөтлөх бичиг баримт” гэх нэр томъёо нь аль нэг Талаас олгодог, эсхүл хянадаг бөгөөд бараа оруулах, гаргахтай холбогдуулан импортлогч, эсхүл экспортлогч өөрөө, эсхүл тэдний нэрийн өмнөөс хэн нэгэн бөглөх ёстой маягыг хэлнэ.

9.3 дугаар зүйл Гаалийн татвар

Талуудын хооронд цахим дамжуулалтад гаалийн татвар ногдуулдаггүй туршлагаа Тал бүр үргэлжлүүлэн мөрдөнө.

9.4 дүгээр зүйл Тоон бүтээгдэхүүнийг үл ялгаварлах нөхцөл

1. Аль ч Тал дараахь арга хэмжээг авч батлахгүй, эсхүл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхгүй:

- (a) нөгөө Талын тоон бүтээгдэхүүнд түүнтэй адилтгах өөрийн тоон бүтээгдэхүүнд олгодог нөхцөлөөс тааламжгүй нөхцөл олгох арга хэмжээ;
- (b) нөгөө Талын тоон бүтээгдэхүүнд энэхүү хэлэлцээрийн оролцогч бус талын түүнтэй адилтгах тоон бүтээгдэхүүнд олгодог нөхцөлөөс тааламжгүй нөхцөл олгох арга хэмжээ.

2. 1 дэх хэсэг нь дараахь зүйлд хамаарахгүй:

- (a) Засгийн газрын худалдан авах ажиллагаа;
- (b) аль нэг Талын, эсхүл аль нэг төрийн өмчит аж ахуйн нэгжийн олгосон буцалтгүй тусламж болон, засгийн газрын дэмжлэгтэй зээл, баталгаа болон даатгал;
- (c) аль нэг Талаас 7.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ;

(d) аль нэг Талаас 7.3, эсхүл 7.5 дугаар зүйлийн үйлчлэх хүрээнд авч хэрэгжүүлсэн буюу баталсан дараахь арга хэмжээ:

(i) 6 дугаар хавсралтад байгаа өөрийн Тусгай үүрэг амлалтын жагсаалтаар үүрэг амлалт аваагүй салбарт хамаарах;

(ii) 6 дугаар хавсралтад байгаа өөрийн Тусгай үүрэг амлалтын жагсаалтаар тохиролцсон болон түүнд заасан хугацаа, хязгаарлалт, нөхцөл болзол болон шаардлагад нийцээгүй.

(e) 10.8 дугаар зүйлийн дагуу авч хэрэгжүүлсэн буюу баталсан үл нийцэх арга хэмжээ.

3. Тал бүр 1 дэх хэсэгт заасан үүргээ хэрэгжүүлэхдээ, шаардлагатай бол, аливаа нэг тоон бүтээгдэхүүн нь аль нэг Талын, эсхүл нөгөө Талын, эсхүл энэхүү хэлэлцээрийн оролцогч бус талын тоон бүтээгдэхүүн байна гэдгийг бодитоор тодорхойлно. Ийнхүү тодорхойлох нь ил тод, бодит баримттай, учир шалтгаантай, шударга байх замаар явагдана.

4. Талууд хэрэв 1 дэх хэсэгт заасан үүргээ хэрэгжүүлэх явцад аливаа нэг тоон бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлсон бол, нөгөө Талын хүсэлтээр, уг гарал үүслийг хэрхэн тодорхойлсноо тайлбарлана.

5. Талууд аливаа нэг тоон бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох шалгуур үзүүлэлт боловсруулах ажилд тус дэм үзүүлж, тийм шалгуур үзүүлэлтийг энэхүү хэлэлцээрт тусгах зорилгоор олон улсын байгууллага болон нийгэмлэгтэй хамтран ажиллана.

9.5 дугаар зүйл Цахим гарын үсэг

1. Аль ч Тал цахим гарын үсэгт холбогдох дараахь арга хэмжээг батлах эсхүл үргэлжлүүлэн хэрэгжүүлэхгүй:

(a) цахим хэлцэлд оролцогч талууд өөрсдийн хэлцэлд тохирох цахим гарын үсгийн аргыг харилцан тодорхойлохыг хориглох;

(b) цахим хэлцэлд оролцогч талууд өөрсдийн цахим хэлцлийг хууль эрх зүйн аливаа шаардлагад нийцсэн гэдгийг шүүх дээр нотлох боломжгүй болох.

2. Тал бүр 1 дэх хэсгийг үл харгалзан тодорхой төрлийн цахим хэлцлийн хувьд холбогдох цахим гарын үсэг нь үйлдлийн тодорхой стандартыг хангасан байх, эсхүл тухайн Талын хууль тогтоомжийн дагуу магадлан итгэмжлэгдсэн буюу хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээжүүлэх үйлчилгээ үзүүлэгч этгээдээс тусгайлан олгосон цахим гэрчилгээнд суурилсан байх шаардлага тавьж болно. Гэхдээ уг шаардлага нь:

(a) хууль ёсны бодлогын зорилтод нийцсэн байна;

(b) уг зорилтод хүрэхэд ихээхэн хамааралтай байна.

9.6 дугаар зүйл **Хэрэглэгчийг хамгаалах**

1. Талууд цахим худалдаанд хэрэглэгчийг хамгаалах ил тод болон үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх болон батлахын зэрэгцээ хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэхэд түлхэц болохуйц арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрнө.

2. Талууд хэрэглэгч хамгаалах ажлыг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор цахим худалдаанд хамаарах үйл ажиллагааны талаар тэдгээрийн хэрэглэгчийг хамгаалах асуудал эрхэлсэн холбогдох эрх бүхий байгууллагууд хоорондоо хамтран ажиллахын ач холбогдлыг хүлээн зөвшөөрнө.

3. Талууд өөрийн хууль тогтоомжийн дагуу цахим худалдаа ашиглагчийн хувийн мэдээллийг хамгаалах арга хэмжээг батлах эсхүл хэрэгжүүлнэ.

9.7 дугаар зүйл **Худалдааны сайн дурын цахим шуудан**

Тал бүр сурталчилгааны зорилготой худалдааны сайн дурын цахим шууданг зохицуулах зохистой болон шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

9.8 дугаар зүйл **Цаасгүй худалдаа удирдан явуулах**

1. Тал бүр худалдааны мэдээлэл хөтлөх бүх бичиг баримтыг цахим хэлбэрээр олон нийтэд хүртээлтэй болгохыг эрмэлзэнэ.

2. Тал бүр цахим хэлбэрээр илгээсэн худалдааны мэдээлэл хөтлөх бичиг баримтыг эрх зүйн хувьд тийм бичиг баримтын цаасан хувилбартай адил хүчин чадалтай гэж хүлээн зөвшөөрөхийг эрмэлзэнэ.

3. Талууд худалдааны мэдээлэл хөтлөх бичиг баримтын цахим хувилбарыг хүлээн зөвшөөрөх явдлыг бэхжүүлэх үүднээс хоёр талын хүрээнд болон олон улсын салбарт хамтран ажиллана.

9.9 дүгээр зүйл Дотоодын зохицуулалт

Тал бүр тэдний цахим худалдаанд хамаарах бүх арга хэмжээ нь ил тод, бодитой, үндэслэлтэй, шударга байдлаар хэрэгжих, мөн хууль ёсны бодлогын зорилтыг хангахад шаардагдахаас илүү хүндрэл учруулахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

9.10 дугаар зүйл Тооцооллын хэрэгслийн байршилд хамаарах шаардлагад хориглох зүйл

1. Талууд:

- (a) нөгөө Талын үйлчилгээ үзүүлэгчээс;
- (b) нөгөө Талын хөрөнгө оруулагчаас;
- (c) нэг Талын нутаг дэвсгэрт нөгөө Талын хөрөнгө оруулагчаас хийж буй хөрөнгө оруулалт,

өөрийн Талын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах нөхцөл болгон өөрийн Талын нутаг дэвсгэр дэх тооцооллын хэрэгслийг ашиглах эсхүл тооцооллын хэрэгслээ тэнд байршуулахыг шаардахгүй.

2. 1 дэх хэсгийг үл харгалзан, энэ зүйлийн аль ч заалтыг аль нэг Тал нийтийг хамарсан хууль ёсны бодлогын зорилтод хүрэхийн тулд тооцооллын хэрэгсэл ашиглах, эсхүл байршуулахад хамаарах арга хэмжээ авч хэрэгжүүлэх буюу батлахыг хориглосон мэтээр тайлбарлахгүй. Гэхдээ тийм арга хэмжээг бодит бусаар, эсхүл үндэслэлгүйгээр ялгаварлан гадуурхах, эсхүл худалдааг далд байдлаар хязгаарлах арга хэрэгсэл болгон хэрэглэхгүй байна.

9.11 дүгээр зүйл

Эх код

1. Талууд нөгөө Талын хэн нэгэн этгээдийн өмчлөлд байгаа програм хангамжийг, эсхүл тийм програм хангамж агуулсан бүтээгдэхүүнийг өөрийн нутаг дэвсгэрт оруулах, түгээх, борлуулах, эсхүл ашиглах нөхцөл болгон уг програм хангамжийн эх кодыг шилжүүлэн өгөх, эсхүл түүнд нэвтрэх шаардлага тавихгүй.

2. Энэ зүйлийн зорилгоор, 1 дэх хэсэгт хамаарах програм хангамж нь нийтийн хэрэглээний програм хангамж, эсхүл энэ төрлийн програм хангамж агуулсан бүтээгдэхүүнээр хязгаарлагдах бөгөөд онц чухал дэд бүтцийн зориулалттай програм хангамж түүнд хамаарахгүй.

9.12 дугаар зүйл

Хамтын ажиллагаа

1. Талууд тохиромжтой бол цахим худалдааны хөгжлийг дэмжих зорилгоор хоёр талын хүрээнд хамтран ажиллаж, бүс нутгийн болон олон талт чуулга уулзалтад идэвхитэй оролцоно.

2. Талууд тохиромжтой үед тухайлбал хэрэглэгчийн итгэл үнэмшил, кибер аюулгүй байдал, худалдааны сайн дурын цахим шуудантай тэмцэх, оюуны өмч, цахим засаглал болон хувийн өгөгдөл хамгаалахтай холбогдсон мэдээлэл болон туршлагаасаа, түүний дотор цахим худалдаанд хамаарах хууль тогтоомж, сайн туршлагаасаа хуваалцана.

3. Талууд цахим худалдаа ашиглахад жижиг, дунд үйлдвэрт тулгарч буй саад бэрхшээлийг даван туулах чиглэлээр хамтран ажиллана.

4. Тал бүр өөрийн Талд байгаа ашгийн бус байгууллагын цахим худалдааг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг, түүний дотор мэдээлэл, үзэл бодол солилцох явдлыг өөрт байгаа арга хэрэгслийг ашиглан дэмжинэ.

5. Тал бүр мэдээллийн хил дамнасан урсгалыг дэмжиж ажиллах нь цахим худалдааны идэвхтэй орчинг бүрдүүлэх чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг хүлээн зөвшөөрнө.

6. Талууд тоон бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэн хөгжүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрнө.

9.13 дугаар зүйл

Цахим худалдааны дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд Цахим худалдааны дэд хороо (цаашид энэ зүйлд “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэхүү бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) энэ бүлэгт хамаарах аливаа асуудлыг, түүний дотор, тохиромжтой бол, 9.4 дүгээр зүйлийг хянан үзэх боломжийг хэлэлцэх;
- (c) тоон бүтээгдэхүүний худалдааг өргөжүүлэн хөгжүүлэх шинэ боломжийг эрэлхийлэх;
- (d) Дэд хорооны үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;
- (e) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

10 дугаар бүлэг Хөрөнгө оруулалт

10.1 дүгээр зүйл Хамрах хүрээ

1. Энэ бүлэг нь аль нэг Тал дараахь зүйлтэй холбоотой батлах эсхүл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээнд хамаарна:

- (a) нөгөө Талын хөрөнгө оруулагчид;
- (b) Аль нэг Талын нутаг дэвсгэрт хийсэн нөгөө Талын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалт;
- (c) 10.7 болон 10.17 дугаар зүйлийн хувьд аль нэг Талын нутаг дэвсгэр дэх бүх хөрөнгө оруулалт.

Тайлбар 1: Илүү тодорхой болгох зорилгоор, энэ бүлэг нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө нэг Талын нутаг дэвсгэр дэх нөгөө Талын хөрөнгө оруулагчдын хийсэн хөрөнгө оруулалттай холбоотойгоор тухайн Талын батлах эсхүл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээний хувьд мөн хэрэглэгдэнэ.

Тайлбар 2: Илүү тодорхой болгох зорилгоор, энэ бүлэг нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос өмнө болсон үйл явдлаас үүссэн маргааны асуудалд хэрэглэгдэхгүй.

2. Энэхүү бүлэг болон 7 дугаар бүлэг хооронд ямар нэгэн зөрүүтэй байдал гарсан тохиолдолд:

- (a) 10.3, 10.4 болон 10.7 дугаар зүйлийн хүрээнд хамаарах асуудлын хувьд зөрүүтэй байдал үүсвэл 7 дугаар бүлгийг дагаж мөрдөнө;
- (b) дээрх (a) дэд хэсэгт хамаарахгүй бусад асуудлаар зөрүүтэй байдал үүсвэл энэ Бүлгийг дагаж мөрдөнө.

3. Энэхүү бүлгийн аль ч заалт нь цагаачлал, зорчих тухай хууль тогтоомжийнхоо дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээний хувьд аль нэг Талд аливаа үүрэг хүлээлгэхгүй.

10.2 дугаар зүйл Тодорхойлолт

Энэхүү бүлгийн зорилгоор:

- (a) “Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр” гэх нэр томъёо нь 2001 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Токио хотод гарын үсэг зурсан Монгол Улс, Япон Улс хоорондын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрийг хэлнэ;
- (b) аж ахуйн нэгж гэж:
 - (i) хэрэв аль нэг хөрөнгө оруулагч нь түүний хувь нийлүүлсэн хөрөнгийн 50-иас дээш хувийг эзэмшдэг бол хөрөнгө оруулагчийн “эзэмшлийн”;
 - (ii) хэрэв аль нэг хөрөнгө оруулагч нь захирлуудынхаа дийлэнх олонхийг томилох, эсхүл хуулийн дагуу үйл ажиллагааг нь удирдах эрх мэдэлтэй бол хөрөнгө оруулагчийн “хяналтын” аж ахуйн нэгж гэнэ;
- (c) “мөрдөж буй” гэх нэр томъёо нь энэхүү хэлэлцээрийг хүчин төгөлдөр болох өдөр үйлчилж байгааг хэлнэ;
- (d) “чөлөөтэй ашиглаж болохуйц валют” гэх нэр томъёо нь Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн холбогдох зүйлд тодорхойлсон чөлөөтэй ашиглаж болохуйц валютыг хэлнэ;
- (e) “хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа” гэх нэр томъёо нь байгуулах, худалдан авах, өргөжүүлэх, үйл ажиллагаа явуулах, удирдах, үйлчилгээ үзүүлэх, ашиглах, хэрэглэх болон худалдах, эсхүл хөрөнгө оруулалтын бусад зохицуулалтыг хэлнэ;
- (f) “арга хэмжээ” гэх нэр томъёо нь хууль, дүрэм, журам, шийдвэр, захиргааны арга хэмжээ зэрэг бүх төрлийн арга хэмжээг хэлнэ;

10.3 дугаар зүйл Үндэсний нөхцөл

1. Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор, ижил төстэй нөхцөлд, өөрийн хөрөнгө оруулагч, тэдний хөрөнгө оруулалтад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөлийг нөгөө Талын хөрөнгө оруулагч болон тэдний хөрөнгө оруулалтад олгоно.

2. 1 дэх хэсгийг аль нэг Тал өөрийн нутаг дэвсгэр дээрх нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой тусгай журам батлах, хэрэгжүүлэхийг хориглосон байдлаар тайлбарлахгүй бөгөөд тэрхүү тусгай журам нь энэ бүлэгт заасан тухайн хөрөнгө оруулагчийн эрхийн агуулгыг хөндөхгүй байх нөхцөлтэй байна.

10.4 дүгээр зүйл **Нэн тааламжтай үндэстний нөхцөл**

Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотойгоор, ижил төстэй нөхцөлд, энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагч, тэдний хөрөнгө оруулалтад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөлийг нөгөө Талын хөрөнгө оруулагч болон тэдний хөрөнгө оруулалтад олгоно.

10.5 дугаар зүйл **Ерөнхий нөхцөл**

1. Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр нөгөө Талын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад олон улсын эрх зүйн дагуу тухайлбал, шударга, эрх тэгш хандах нөхцөл, мөн бүрэн хамгаалалт болон аюулгүй байдлын нөхцөлийг олгоно.

Тайлбар 1: Энэ хэсэг нь олон улсын заншлын эрх зүйн хүрээнд гадаад хүмүүст олгодог хамгийн доод стандартыг нөгөө Талын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтад хамгийн доод нөхцөл болгон олгохыг тодорхойлсон болно. “Шударга, эрх тэгш хандах нөхцөл”, мөн “бүрэн хамгаалалт болон аюулгүй байдал” гэсэн ойлголтууд нь олон улсын заншлын эрх зүйн дагуу хэвшмэл болсон гадаад хүмүүст тавьдаг хамгийн доод стандартаас илүү нэмэлт, эсхүл түүнээс хэтэрсэн шаардлагыг тавихгүй. Энэхүү хэлэлцээрийн өөр нэг заалт эсхүл өөр тусдаа олон улсын бусад хэлэлцээрийг зөрчсөн нь тогтоогдсон ч тэр нь энэ хэсгийг зөрчигдсөнд тооцогдохгүй болно.

Тайлбар 2: “Шударга, эрх тэгш хандах нөхцөл” гэдэгт хуулийн зохих журмын дагуу явагдаж байгаа эрүүгийн, иргэний, эсхүл захиргааны шүүхийн үйл ажиллагаанд шударга байдлыг үгүйсгэхгүй байх Талуудын үүргийг хамааруулна.

2. Тал бүр нөгөө Талын хөрөнгө оруулагчийн тодорхой хөрөнгө оруулалттай холбоотойгоор аливаа бичгээр хүлээсэн үүргээ биелүүлэх бөгөөд энэхүү үүрэг нь хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтаа хийх, худалдан авах, эсхүл өргөтгөх үед нь үндэслэл болсон байж болно.

3. Энэ зүйл нь татварын арга хэмжээнд хамаарна.

10.6 дугаар зүйл **Шүүхэд хандах боломж**

1. Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр хөрөнгө оруулагчийн эрхийг мөрдөх болон өмгөөлөх явцад шүүх болон шүүхийн бүх шатны захиргааны байгууллагад хандахтай холбоотойгоор, ижил төстэй нөхцөлд, өөрийн хөрөнгө оруулагчид, эсхүл энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагчид олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөлийг нөгөө Талын хөрөнгө оруулагчид олгоно.

2. Энэ зүйл нь татварын арга хэмжээнд хамаарна.

10.7 дугаар зүйл **Үйл ажиллагааны шалгуурт тавигдах хориг**

1. Аль ч Тал нь өөрийн нутаг дэвсгэр дээр аль нэг Талын эсхүл энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан дараахь шаардлагуудыг, эсхүл аливаа үүрэг амлалт буюу даалгаврын алийг нь ч оноох, эсхүл хэрэгжүүлэхгүй:

- (a) бараа бүтээгдэхүүн, эсхүл үйлчилгээг өгөгдсөн түвшин, эсхүл хувь хэмжээгээр экспортлох;
- (b) дотоод агууламжийг өгөгдсөн түвшин, эсхүл хувь хэмжээнд хүргэх;
- (c) өөрийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, эсхүл үзүүлсэн үйлчилгээг худалдан авах, ашиглах, эсхүл сонгох давуу эрх олгох, эсхүл өөрийн нутаг дэвсгэр дэх хувь хүнээс бараа, эсхүл үйлчилгээ худалдан авах;
- (d) импортын тоо хэмжээ буюу үнийн дүнг экспортын тоо хэмжээ буюу үнийн дүнтэй, эсхүл тухайн хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалттай холбогдох гадаад валютын орох урсгалтай ямар нэг байдлаар хамааруулах;

- (e) экспортынх нь, эсхүл гадаад валютын арилжааны ашгийнх нь тоо хэмжээ буюу үнийн дүнд нь нөлөөлөх хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтаар үйлдвэрлэж, эсхүл нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүн буюу үзүүлж буй үйлчилгээний борлуулалтыг өөрийн нутаг дэвсгэрт хязгаарлах;
- (f) экспортыг, эсхүл экспортын борлуулалтыг хязгаарлах;
- (g) гүйцэтгэх захирал, менежер, эсхүл захирлуудын зөвлөлийн гишүүдийг тодорхой нэг иргэний харьяалалтай хувь хүмүүсээс томилох;
- (h) тухайн хөрөнгө оруулагчийн тодорхой бүс нутаг, эсхүл дэлхийн зах зээл рүү чиглэсэн үйл ажиллагааны төв оффисыг өөрийн нутаг дэвсгэр дээр байрлуулах;
- (i) өөрийн иргэдийг тодорхой тоо, эсхүл хувиар ажилд авах;
- (j) хөрөнгө оруулагчийн үйлдвэрлэдэг бараа бүтээгдэхүүн, эсхүл нийлүүлдэг үйлчилгээний нэг буюу түүнээс дээш хэсгийг тодорхой нэг бүс нутаг, эсхүл дэлхийн зах зээл рүү зөвхөн тухайн Талын нутаг дэвсгэрээс нийлүүлэх;
- (k) Холбогдох Талын засгийн газрын эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг хэрэгжүүлсэн, эсхүл оноосон үүрэг амлалтыг биелүүлсэн хөрөнгө оруулагч болон тухайн нутаг дэвсгэр дээрх хувь хүн хооронд чөлөөтэйгөөр байгуулсан /хэрэгжиж эхэлсэн, эсхүл эхлээгүй/ лицензийн гэрээний хувьд:
 - (i) лицензийн гэрээнд төлбөрийн хувь буюу хэмжээ тогтоох;
 - (ii) лицензийн гэрээнд тодорхой хугацаа заах.

Тайлбар: Энэ заалт дахь “лицензийн гэрээ” гэдэг нь технологи, үйлдвэрлэлийн үйл явц, эсхүл бусад өмчийн эрх шилжүүлэхтэй холбоотой аливаа лицензийн гэрээг хэлнэ.

2. Аль ч Тал өөрийн нутаг дэвсгэр дээрх аль нэг Талын, эсхүл энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан дараахь шаардлагыг хэрэгжүүлэхэд нэг удаа, эсхүл тогтмол давуу тал олж авахад нөхцөл тавьж болохгүй:

- (a) дотоод агууламжийг өгөгдсөн түвшин, эсхүл хувь хэмжээнд хүргэх;

- (b) өөрийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн, эсхүл үзүүлсэн үйлчилгээг худалдан авах, ашиглах, эсхүл сонгох давуу эрх олгох, эсхүл өөрийн нутаг дэвсгэрийн хувь хүнээс бараа эсхүл үйлчилгээг худалдан авах;
 - (c) импортын тоо хэмжээ буюу үнийн дүнг экспортын тоо хэмжээ буюу үнийн дүнтэй, эсхүл тухайн хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалттай холбогдох гадаад валютын орох урсгалтай ямар нэг байдлаар хамааруулах;
 - (d) экспортынх нь, эсхүл гадаад валютын арилжааны ашгийнх нь тоо хэмжээ буюу үнийн дүнд нь нөлөөлөх хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтаар үйлдвэрлэж, эсхүл нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүн буюу үзүүлж буй үйлчилгээний борлуулалтыг өөрийн нутаг дэвсгэрт хязгаарлах.
 - (e) экспортыг, эсхүл экспортын борлуулалтыг хязгаарлах;
3. (a) 2 дахь хэсэг нь аль нэг Талын, эсхүл энэхүү хэлэлцээрт оролцогч бус хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан, өөрийн нутаг дэвсгэр дээр үйлдвэрлэл байршуулах, үйлчилгээ үзүүлэх, ажилчдыг сургах буюу ажилд авах, тодорхой байгууламжийг барих буюу өргөтгөх, эсхүл судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэхтэй холбоотой шаардлагуудыг хэрэгжүүлэн нэг удаа эсхүл тогтмол давуу тал олж авах нөхцөлийг хязгаарлах байдлаар тайлбарлагдахгүй.
- (b) 1(k) дэд хэсэг нь шүүх, эсхүл өрсөлдөөний байгууллагаас өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагааг зохицуулах хуулиудыг зөрчсөн хэмээн тогтоосон бөгөөд түүнийг залруулах зорилгоор тавигдсан шаардлага буюу оноосон үүрэг амлалтыг хэрэгжүүлэхэд хамаарахгүй.
 - (c) 1(a), 1(b), 1(c), 2(a) болон 2(b) дэд хэсэг нь гадаадын тусламжийн хөтөлбөртэй холбоотой бараа, эсхүл үйлчилгээнд тавигдах шаардлагуудад хамаарахгүй.
 - (d) 2(a) болон 2(b) дэд хэсэг нь тусгай хөнгөлөлттэй тариф буюу тусгай квотын шалгуурт нийцэх учиртай бараа бүтээгдэхүүний агууламжтай холбоотой импортлогч Талын тавьсан шаардлагад хамаарахгүй.
4. 1 болон 2 дахь хэсэг нь эдгээр хэсэгт заасан шаардлагаас бусад аливаа шаардлагад хамаарахгүй.

10.8 дугаар зүйл

Үл нийцэх арга хэмжээ

1. 10.3, 10.4 болон 10.7 дугаар зүйл нь дараахь нөхцөлд хамаарахгүй:

- (a) 8 дугаар хавсралт дахь жагсаалтдаа заасан аль нэг Талын төв засгийн газраас үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй аливаа үл нийцэх арга хэмжээ;
- (b) аль нэг Талын орон нутгийн засаг захиргаанаас үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй аливаа үл нийцэх арга хэмжээ;
- (c) (a) болон (b) дэд хэсэгт дурдсан аливаа үл нийцэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, эсхүл яаралтай шинэчлэх үед;
- (d) (a) болон (b) дэд хэсэгт дурдсан аливаа үл нийцэх арга хэмжээнд нэмэлт, өөрчлөлт буюу засвар оруулахаас өмнөхөн үеийнхтэй адил буюу 10.3, 10.4 болон 10.7 дугаар зүйлтэй нийцэх байдлыг нь бууруулахгүй байхаар нэмэлт, өөрчлөлт буюу засвар оруулсан бол.

2. Хэрэв аль нэг Тал нь нөгөө Талын муж, эсхүл Улаанбаатар хот, эсхүл аймгаас 1(b) дэд хэсэгт заасны дагуу баталсан, эсхүл хэрэгжүүлсэн үл нийцэх арга хэмжээ нь өөрийн Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд саад учруулж байна гэж үзвэл харилцан тааламжтай шийдэлд хүрэх зорилгоор тухайн арга хэмжээг хэрэглэх талаар зөвлөлдөх хүсэлт гаргаж болно.

3. 10.3, 10.4 болон 10.7 дугаар зүйл нь хавсралт 9 дэх жагсаалтдаа заасан салбар, дэд салбар, эсхүл үйл ажиллагаатай холбоотой аль нэг Талын баталсан эсхүл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх аливаа арга хэмжээнд хамаарахгүй.

4. Аль ч Тал нь энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш батлагдсан болон хавсралт 9 дэх жагсаалтдаа хамаарах аливаа арга хэмжээний хүрээнд нөгөө Талын хөрөнгө оруулагчийн иргэний харьяаллаас шалтгаалан тухайн арга хэмжээ хүчин төгөлдөр болоход байсан хөрөнгө оруулалтыг нь зарах, эсхүл бусад байдлаар салгахыг хөрөнгө оруулагчаас шаардахгүй.

5. Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш аль нэг Тал нь 8 дугаар хавсралтын жагсаалтдаа заасан одоо мөрдөж буй аливаа үл нийцэх арга хэмжээнд нэмэлт, өөрчлөлт буюу засвар оруулах, эсхүл хавсралт 9 дэх жагсаалтдаа заасан салбар, дэд салбар, эсхүл үйл ажиллагаатай холбоотойгоор шинээр, эсхүл илүү хязгаарласан аливаа арга хэмжээг батлах бол тухайн Тал нь нэмэлт, өөрчлөлт буюу засвар шинээр, эсхүл илүү хязгаарласан арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө, эсхүл онцгой нөхцөл байдалд дараахь зүйлийг нэн даруй хэрэгжүүлнэ:

(a) нөгөө Талд тухайн нэмэлт, өөрчлөлт, засвар, эсхүл арга хэмжээний тухай дэлгэрэнгүй мэдээллийг мэдэгдэх;

(b) нөгөө Талын хүсэлтээр хоёр тал харилцан сэтгэл ханамжтай байдалд хүрэх чин эрмэлзэлтэйгээр зөвлөлдөөн хийх.

6. Тал бүр өөрийн хавсралт 8 болон хавсралт 9 дэх жагсаалт тус бүрт заасан үл нийцэх арга хэмжээг тохиромжтой тохиолдолд аль болох багасгах, эсхүл арилгахад хүчин чармайлт гаргана.

7. 10.3 болон 10.4 дүгээр зүйл нь Оюуны өмчийн эрхийн худалдаатай холбогдсон асуудлын тухай хэлэлцээрийн 3 болон 4 дүгээр зүйлээр хүлээсэн үүрэг, ялангуяа уг хэлэлцээрийн 3-аас 5 дугаар зүйлд зааснаар дээрх хүлээсэн үүрэгт хамаарахгүй буюу хүлээсэн үүргийг зөрчихтэй холбоотой аливаа арга хэмжээнд хамаарахгүй.

8. 10.3, 10.4 болон 10.7 дугаар зүйл нь аль нэг Талын засгийн газрын худалдан авах ажиллагаатай холбоотой баталсан, эсхүл хэрэгжүүлсэн аливаа арга хэмжээнд хамаарахгүй.

10.9 дүгээр зүйл

Албадан хураах болон нөхөн төлбөр олгох

1. Аль нэг Тал нь өөрийн нутаг дэвсгэр дэх нөгөө Талын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтыг дараахаас бусад тохиолдолд албадан хураах, эсхүл төрийн өмчид авах, эсхүл албадан хураах, төрийн өмчид авахтай ижил төстэй аливаа арга хэмжээ (цаашид “албадан хураах” гэх) авахгүй:

(a) нийтийн ашиг сонирхлын зорилгоор;

(b) үл ялгаварлах зарчмаар;

(c) 2-оос 4 дэх хэсэгт заасны дагуу нөхөн төлбөрийг нэн даруй, хангалттай болон үр дүнтэйгээр хийвэл;

(d) 10.5 дугаар зүйл болон хуулийн зохих журмыг дагуу аливаа арга хэмжээ авахгүй.

2. Нөхөн төлбөрийн хэмжээ нь албадан хураах арга хэмжээ авах тухай нийтэд мэдэгдсэн, эсхүл хураан авах үйл ажиллагаа хэрэгжсэн үеийн аль түрүүлж биелсэн цаг хугацааны албадан хураасан хөрөнгө оруулалтын зах зээлийн бодит үнэ өртөгтэй тэнцүү байна. Зах зээлийн бодит үнэ өртөг нь албадан хураах тухай мэдээлэл нийтэд урьдчилан мэдэгдсэнээс болж үнэ өртөгт орсон өөрчлөлтөд нөлөөлөхгүй.

3. Нөхөн төлбөрийг хойшлуулалгүйгээр хийх бөгөөд төлбөр хийгдэх хүртэлх хугацааны уртыг харгалзан арилжааны тохирох хүүг тооцон төлнө. Энэ нь мөнгөн хэлбэрт оруулах болон чөлөөтэй шилжих боломжтой, мөн холбогдох хөрөнгө оруулагчийн Талын мөнгөн тэмдэгт рүү болон чөлөөтэй ашиглаж болохуйц бусад валют руу албадан хураасан өдрийн мөрдөгдөж байсан зах зээлийн ханшаар чөлөөтэй хөрвөхөөр байна.

4. 10.13 дугаар зүйлийг хөндөхгүйгээр, хөрөнгөө албадан хураалгасан хөрөнгө оруулагчид энэ зүйлд заасан зарчмын дагуу албадан хураасан Талын шүүх, эсхүл захиргааны байгууллагуудад хандан тухайн хөрөнгө оруулагчийн хэргийн талаар болон нөхөн олговрын хэмжээний асуудлаар шуурхай хэлэлцүүлэх эрхтэй байна.

5. Энэ зүйл нь аливаа татварын арга хэмжээ нь албадан хураалт агуулсан тохиолдолд үйлчилнэ.

6. Энэ зүйлийг хавсралт 10-ын дагуу тайлбарлана.

10.10 дугаар зүйл Мөргөлдөөнөөс хамгаалах

1. Тал бүр зэвсэгт мөргөлдөөн, эсхүл хувьсгал, бослого, иргэний үймээн, эсхүл эдгээртэй ижил төстэй бусад үйл явдал гэх мэт онц байдлаас үүдэн нэг Талын нутаг дэвсгэр дээрх нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтад учирсан хохирол буюу алдагдлыг барагдуулахдаа, сэргээн босгох, хохирол арилгах, нөхөн төлөх, эсхүл бусад хэлбэрээр төлөх үйл явцад, өөрийн, эсхүл энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй буюу нөгөө Талын хөрөнгө оруулагчдад аль илүү байгаа тааламжтай нөхцөлийг нөгөө Талын хөрөнгө оруулагчдад олгоно.

2. 1 дэх хэсэгт дурдсан төлбөр барагдуулах арга хэрэгсэл нь мөнгөн хэлбэрт оруулах, чөлөөтэй шилжих боломжтой, мөн холбогдох хөрөнгө оруулагчийн Талын мөнгөн тэмдэгт рүү болон чөлөөтэй ашиглаж болохуйц бусад валют руу чөлөөтэй хөрвөхөөр байна.

3. 1.10 дугаар зүйлийн заалтыг үл харгалзан, аль ч Тал тухайн 1.10 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээ авч хэрэгжүүлсэн шалтгаанаар дээрх 1 дэх хэсэгт хүлээсэн үүрэг хариуцлагаасаа чөлөөлөгдөхгүй.

10.11 дүгээр зүйл Шилжүүлэг

1. Тал бүр өөрийн нутаг дэвсгэрт нөгөө Талын хөрөнгө оруулагчийн хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой тухайн нутаг дэвсгэрт орох, гарах бүхий л шилжүүлгийг ямар нэг саадгүйгээр чөлөөтэй явуулах байдлыг хангана. Эдгээр шилжүүлэгт дараахь зүйл түлхүү хамаарах хэдий ч зөвхөн түүгээр хязгаарлагдахгүй:

- (a) хөрөнгө оруулалтаа хэрэгжүүлэх, эсхүл нэмэх зорилготой анхны хөрөнгө болон нэмэлт хэмжээ;
- (b) хөрөнгө оруулалтаас хуримтлуулсан ашиг, хүү, хөрөнгийн орлого, ногдол ашиг, роялти, хураамж болон бусад орлого;
- (c) гэрээний дагуу хийгдсэн төлбөрүүд, тэр дундаа хөрөнгө оруулалттай холбоотой зээлийн төлбөр;
- (d) хөрөнгө оруулалтыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн борлуулсан эсхүл санхүүжүүлсэн орлого;
- (e) нэг Талын нутаг дэвсгэрт хийсэн хөрөнгө оруулалттай холбоотой үйл ажиллагаанд оролцох нөгөө Талын боловсон хүчний цалин хөлс болон урамшуулал;
- (f) 10.9 болон 10.10 дугаар зүйлийн дагуу хийгдсэн төлбөр;
- (g) 10.13 дугаар зүйлийн дагуу маргаан шийдвэрлэлтээс үүссэн төлбөр.

2. Тал бүр тухайн шилжүүлэг хийх өдөр мөрдөж буй зах зээлийн ханшид чөлөөтэй хэрэглэж болохуйц мөнгөн тэмдэгтээр хугацаа алдалгүй хийж болох тийм шилжүүлгээр цаашид хангана.

3. 1 болон 2 дахь хэсгийг үл харгалзан аль нэг Тал доорх тохиолдолд өөрийн хууль тогтоомжийг эрх тэгш, үл ялгаварласан, үнэн зөв хэрэглэх байдлаар шилжүүлгийг саатуулах буюу саад хийж болно:

- (a) дампуурал, төлбөрийн чадваргүй байдал, эсхүл зээлдүүлэгчийн эрхийг хамгаалах;
- (b) үнэт цаас гаргах, худалдаалах, эсхүл арилжаалах;
- (c) эрүүгийн, эсхүл гэмт хэргийн нөхцөл;
- (d) шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны тогтоол эсхүл шүүхийн шийдвэрийг биелүүлэх.

10.12 дугаар зүйл **Даатгагдсан төлөөлөл**

Хэрэв аль нэг Тал, эсхүл түүний эрх олгосон байгууллага нөгөө Талын нутаг дэвсгэр дээрх тухайн нэг Талын хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтад хамаарах нөхөн олговор, баталгаа, эсхүл даатгалын гэрээний дагуу тухайн хөрөнгө оруулагчид төлбөр хийх тохиолдолд тухайн нөгөө Тал тухайн төлбөр хийх шалтгаан болсон хөрөнгө оруулагчийн аливаа эрх, эсхүл нэхэмжлэлийг тухайн нэг Тал, эсхүл түүний эрх олгосон байгууллага төлөөлөх эрхтэйг хүлээн зөвшөөрнө. Мөн тухайн нөгөө Тал нь тухайн нэг Тал, эсхүл түүний эрх олгосон байгууллага нь хөрөнгө оруулагчийн үндсэн эрх, эсхүл нэхэмжлэлийг даатгагдсан төлөөллийн үндсэн дээр бүрэн гүйцэтгэх эрхтэйг хүлээн зөвшөөрнө. Харин тухайн нэг Тал, эсхүл түүний эрх олгосон байгууллагад эрх, эсхүл нэхэмжлэл, мөн тухайн төлбөрийн шилжүүлгийг олгосон эрхийн дагуу төлөх төлбөрийн хувьд 10.9, 10.10 болон 10.11 дүгээр зүйл *mutatis mutandis* зарчмаар хэрэглэгдэнэ.

10.13 дугаар зүйл **Нэг Тал болон нөгөө Талын хөрөнгө оруулагч хоорондын хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг шийдвэрлэх**

1. Энэ зүйлийн зорилгоор:

- (a) “Маргалдагч хөрөнгө оруулагч” гэх нэр томъёо нь хөрөнгө оруулалтын маргаанд оролцогч тал болох хөрөнгө оруулагчийг хэлнэ;

- (b) “Маргалдагч Тал” гэх нэр томьёо нь хөрөнгө оруулалтын маргаанд оролцогч тал болох нэг Талыг хэлнэ;
- (c) “Маргалдагч талууд” гэх нэр томьёо нь Маргалдагч хөрөнгө оруулагч болон Маргалдагч Талыг хэлнэ;
- (d) “ХОМШОУТ (ИКСИД)-ийн конвенц” гэх нэр томьёо нь 1965 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Вашингтонд байгуулсан Улс болон гадаад улсын иргэд хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцийг хэлнэ;
- (e) “ХОМШОУТ (ИКСИД)-ийн Нэмэлт хэрэгслийн дүрэм” гэх нэр томьёо нь Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн Нарийн бичгийн дарга нарын газрын үйл ажиллагааг явуулах нэмэлт хэрэгслийг зохицуулах дүрмийг хэлнэ;
- (f) “Хөрөнгө оруулалтын маргаан” гэх нэр томьёо нь аль нэг Тал болон нөгөө Талын хөрөнгө оруулагч хооронд нөгөө Талын хөрөнгө оруулагч, эсхүл нэг Талын нутаг дэвсгэрт хийсэн дээрх хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор нэг Талыг энэхүү бүлгийн дагуу хүлээсэн аливаа үүргээ зөрчсөнөөс шалтгаалсан буюу үүнээс үүдэн нөгөө Талын хөрөнгө оруулагчид учирсан гэж үзсэн алдагдал буюу хохирлоос үүдсэн маргааныг хэлнэ;
- (g) “Нью-Йоркийн конвенц” гэх нэр томьёо нь 1958 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотод байгуулсан Гадаадын арбитрын байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон биелүүлэх тухай конвенцийг хэлнэ.

2. 6 (a)(i) дэд хэсгийн дагуу, энэхүү зүйлээр маргалдагч Талын нутаг дэвсгэрийн хүрээнд захиргааны болон шүүхийн шийдвэр гаргуулахаас маргалдагч хөрөнгө оруулагчийг хамгаална гэж ойлгохгүй.

3. Хөрөнгө оруулалтын маргааныг Маргалдагч талууд аль болох зөвлөлдөөн хийх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

4. Хэрэв хөрөнгө оруулалтын маргаан нь маргалдагч хөрөнгө оруулагч маргалдагч Талд зөвлөлдөх тухай хүсэлтээ бичгээр мэдэгдсэнээс хойш 120 хоногийн дотор зөвлөлдөөн хийх замаар шийдвэрлэгдээгүй тохиолдолд маргалдагч хөрөнгө оруулагч 6 дахь хэсэгт нийцүүлэн хөрөнгө оруулалтын маргааныг дараахь олон улсын арбитра шилжүүлж болно:

- (a) Талуудын хувьд ХОМШОУТ (ИКСИД)-ийн конвенц хүчин төгөлдөр байгаа тохиолдолд түүний дагуу байгуулагдсан арбитра;
- (b) Аль нэг Тал нь ХОМШОУТ (ИКСИД)-ийн конвенцийн тал бол ХОМШОУТ (ИКСИД)-ийн Нэмэлт хэрэгслийн дүрмээр байгуулагдсан арбитра;
- (c) Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Арбитрын дүрмээр байгуулагдсан арбитра;
- (d) Маргалдагч Талтай тохиролцсон тохиолдолд арбитрайн бусад дүрмийн дагуу аль ч арбитра.

5. 4 дэх хэсэгт заасан арбитраг энэ зүйлд зааснаар өөрчилснөөс бусад тохиолдолд тохирох арбитрайн дүрмээр зохицуулна.

6. (a) 4 болон 8 дахь хэсгийг үл харгалзан, дараахь тохиолдлоос бусад үед 4 дэх хэсэгт заасан арбитра хандах боломжгүй:

- (i) маргалдагч хөрөнгө оруулагч нь маргалдагч Талын зүгээс хэрэгжүүлсэн арга хэмжээг 1(f) дэд хэсэгт заасан зөрчил гэж үзсэнтэй холбоотойгоор маргалдагч Талд аль нэг Талын хуульд заасан аливаа шүүхэд, эсхүл Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх журам зэрэг маргаан шийдвэрлэх бусад журмын дагуу нэхэмжлэл гаргах эрхээсээ татгалзсан тухайгаа бичгээр мэдэгдсэн бол;
- (ii) маргалдагч хөрөнгө оруулагч нь Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх журмын дагуу маргалдагч Талын зүгээс хэрэгжүүлсэн арга хэмжээг 1(f) дэд хэсэгт заасан зөрчил гэж үзсэнтэй холбоотойгоор ямар нэг үйл ажиллагаа эхлүүлээгүй бол.

(b) дээрх (a) дэд хэсгийг үл харгалзан, Маргалдагч хөрөнгө оруулагч нь маргалдагч Талын эрх бүхий шүүхээс хохирлын мөнгөн төлбөртэй холбоогүй тусламж авах урьдчилсан хориг шийдвэр гаргуулах ажлыг эхэлж, эсхүл үргэлжлүүлж болно.

7.4 дэх хэсгийн дагуу хөрөнгө оруулалтын маргааныг арбитра мэдүүлэхээр төлөвлөж байгаа Маргалдагч хөрөнгө оруулагч нь энэ талаараа маргалдагч Талд хүсэлтээ арбитра хүргүүлэхээс доод тал нь 90 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд дараахь зүйлийг тодорхой заасан байна:

- (a) маргалдагч хөрөнгө оруулагчийн нэр болон хаяг;
- (b) маргалдагч Талын асуудал үүсгээд буй тодорхой арга хэмжээ болон энэ бүлгээр хүлээсэн үүргээ зөрчсөн гэж үзсэн асуудлын тайлбарыг агуулсан асуудлыг хангалттай, тодорхой танилцуулахуйц хуулийн үндэслэл, баримт бүхий хөрөнгө оруулалтын маргааны товч танилцуулга;
- (c) маргалдагч хөрөнгө оруулагчаас хэрэглэхийг санал болгож буй 4 дэх хэсэгт заасан арбитра;
- (d) хүссэн тусламж болон нэхэмжилсэн хохирлын ойролцоо хэмжээ.

8. (a) Тал бүр Маргалдагч хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалтын маргааныг 4 дэх хэсэгт заасан арбитраас Маргалдагч хөрөнгө оруулагчийн сонгосон арбитра хүргүүлэхийг үүгээр зөвшөөрөв.

(b) дээрх (a) дэд хэсэгт дурдсан зөвшөөрөл болон Маргалдагч хөрөнгө оруулагч хөрөнгө оруулалтын маргааныг арбитра хүргүүлэхэд дараахь шаардлагыг хангасан байна:

- (i) Маргалдагч талуудын бичгээр гаргасан зөвшөөрлийг авахад ХОМШОУТ (ИКСИД)-ийн конвенцийн 2 дугаар бүлэг, эсхүл ХОМШОУТ (ИКСИД)-ийн Нэмэлт хэрэгслийн дүрэм;
- (ii) бичгээр хэлэлцээр хийхэд Нью-Йоркийн конвенцийн 2 дугаар зүйл.

9. 8 дахь хэсгийг үл харгалзан, хэрэв Маргалдагч хөрөнгө оруулагч нь 1(f) дэд хэсэгт дурдсан Маргалдагч хөрөнгө оруулагчийн алдагдал буюу хохирлын талаарх мэдээллийг олж авсан, эсхүл олж авах ёстой байсан, аль түрүүлсэн өдрөөс хойш 3-аас дээш өнгөрсөн бол 4 дэх хэсэгт заасан арбитрарт өгөх боломжгүй.

10. Маргалдагч талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд 4 дэх хэсгийн дагуу байгуулагдсан арбитрарын шүүх нь гурван арбитрачаас бүрдэх бөгөөд Маргалдагч тал тус бүр нэг арбитрачийг томилж, гурав дахь буюу даргалагч арбитрачийг Маргалдагч талууд тохиролцсоны үндсэн дээр сонгоно. Хэрэв Маргалдагч хөрөнгө оруулагч, эсхүл маргалдагч Тал арбитрач буюу арбитрачдыг хөрөнгө оруулалтын маргааныг арбитрарт өгсөн өдрөөс хойш 60 хоногийн дотор томилоогүй тохиолдолд Маргалдагч талуудын аль нэг талын хүсэлтийн дагуу 4 (a) эсхүл 4(b) дэд хэсэгт заасан арбитрарын хувьд Олон улсын хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх төвийн Ерөнхий нарийн бичгийн дарга, 4(c) эсхүл 4(d) дэд хэсэгт заасан арбитрарын хувьд Гааг дахь Арбитраын байнгын шүүхийн Ерөнхий нарийн бичгийн дарга хараахан томилогдоогүй арбитрач буюу арбитрачдыг 11 дэх хэсгийн шаардлагын дагуу тус тус томилж болно.

11. Маргалдагч талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд гурав дахь арбитрач нь аль нэг Талын иргэн, аль нэг Талд байнга оршин суугч, Маргалдагч талуудын аль нэгэнд ажил эрхэлдэг байж болохгүйгээс гадна мөн өмнө нь тухайн хөрөнгө оруулалтын маргаантай ямар нэг хэмжээгээр холбогдсон байж болохгүй.

12. Маргалдагч талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд арбитрарыг Нью-Йоркийн конвенцид оролцогч тал болох аль нэг улсад явуулна.

13.4 дэх хэсгийн дагуу байгуулагдсан арбитрарын шүүх нь маргаантай асуудлыг энэ бүлэг болон энэхүү хэлэлцээрийн тохирох бусад заалт мөн олон улсын эрх зүйн тохирох дүрмийн дагуу шийдвэрлэнэ.

14. Маргалдагч Тал нь нөгөө Талд дараахь зүйлийг хүргүүлнэ:

(a) хөрөнгө оруулалтын маргааныг арбитрарт хүргүүлсэн тухай бичгээр үйлдсэн мэдэгдлийг тухайн маргааныг хүргүүлсэн өдрөөс хойш 30 хоногоос хэтрүүлэлгүй;

(b) арбитрарт гаргасан нэхэмжлэлтэй холбоотой бүх баримт бичгийн хуулбар.

15.Маргалдагч бус Тал нь энэ бүлгийн болон энэхүү хэлэлцээрийн тохирох бусад заалтын ойлголтын тухай асуудлаар маргалдагч талуудад бичгээр мэдэгдсэний үндсэн дээр арбитрын шүүхэд тайлбар өгч болно.

16.Арбитрын шүүх нь Маргалдагч хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, эсхүл арбитрын үйл ажиллагааны явцыг хөнгөвчлөх зорилгоор маргалдагч талуудын аль нэгийг эзэмшилд буюу хяналтад байгаа нотлох баримтыг өөрт нь байлгах зэрэг түр зуурын хамгаалалтын арга хэмжээ авах шийдвэр гаргаж болно. Арбитрын шүүх нь барьцаалах, эсхүл 1(f) дэд хэсэгт заасан зөрчил гэж үзсэн арга хэмжээг хориглох тухай шийдвэр гаргахгүй.

17.Арбитрын шүүх нь шүүх ажиллагаа явуулахаас өмнө маргалдагч Талаас гаргасан арбитрын шүүхийн харьяалал болон Маргалдагч хөрөнгө оруулагчийн нэхэмжлэлийг хүлээн авахыг эсэргүүцсэн аливаа гомдлыг эхний ээлжинд хэлэлцэн, түүнийг үндэслэлтэй гэж үзвэл шийдвэрлэнэ. Арбитрын шүүх дээрх гомдлыг эхний ээлжинд шийдвэрлэсэн бол гомдлыг хэлэлцүүлэхтэй холбоотой гарсан зохих зардал болон өмгөөлөгчийн хөлсийг шийдвэр нь түүний эсрэг гарсан маргалдагч талаас гаргуулж болно. Ийм шийдвэр гаргах үндэслэлтэй эсэхийг тодорхойлохдоо арбитрын шүүх нь Маргалдагч хөрөнгө оруулагчийн нэхэмжлэл, эсхүл маргалдагч Талын гомдлын аль нэг нь үндэслэлтэй эсэхийг нягтлана. Энэ явцдаа арбитрын шүүх нь маргалдагч талуудад байр сууриа тайлбарлах зохих бололцоо олгоно.

18.Арбитрын шүүх нь зөвхөн дараахь шийдвэрийг гаргаж болно:

- (a) маргалдагч Талын зүгээс Маргалдагч хөрөнгө оруулагч болон түүний хөрөнгө оруулалттай холбоотой энэ бүлгээр хүлээсэн аливаа үүргээ зөрчсөн эсэх талаарх шийдвэр;
- (b) зөвхөн зөрчсөн тохиолдолд дараахь хамгаалалтын арга хэмжээний аль нэгийг, эсхүл хоёуланг нь авна:
 - (i) мөнгөн хохирол болон холбогдох хүү;
 - (ii) эд хөрөнгийг буцаан олгох, энэ тохиолдолд маргалдагч Тал төлбөрийг төлөхдөө буцаан олгохын оронд мөнгөн хохирол болон холбогдох хүүгээр нь барагдуулж болох эсэхийг шийдвэрт заана.

Арбитрын шүүх нь энэ зүйл болон арбитрын тохирох журмын дагуу зардал, өмгөөлөгчийн хөлсийг мөн тогтоож болно.

19. Маргалдагч Тал нь 4 дэх хэсгийн дагуу байгуулагдсан арбитраын шүүхэд хүргүүлсэн, эсхүл уг шүүхээс гаргасан дараахаас бусад бүх материал, шийдвэрийг цаг тухайд нь олон нийтэд нээлттэй болгоно:

- (a) бизнесийн нууц мэдээлэл;
- (b) Тал бүрийн тохирох хууль тогтоомжийн дагуу давуу эрхтэй, эсхүл задруулахыг хориглосон мэдээлэл;
- (c) арбитраын холбогдох журмын дагуу нууцлах ёстой мэдээлэл.

20. Арбитраын шүүхээс гаргасан шийдвэр нь Маргалдагч талуудын хувьд эцсийнх бөгөөд түүнийг заавал биелүүлнэ. Уг шийдвэрийг хэрэгжүүлэхдээ шийдвэрийг хэрэгжүүлэхээр заасан тухайн улсын тохирох хууль тогтоомж болон ХОМШОУТ (ИКСИД)-ийн конвенц, Нью-Йоркийн конвенц зэрэг холбогдох олон улсын хуулийг баримтална.

21. Аль ч Тал нь нөгөө Тал болон өөрийн Талын хөрөнгө оруулагчийн зүгээс 4 дэх хэсэгт заасан арбитра хөрөнгө оруулалтын маргааныг хүргүүлэхээр тохирсон эсхүл хүргүүлсэнтэй холбогдуулан, хөрөнгө оруулалтын маргааны шийдвэрийг нөгөө Тал дагаж мөрдөөгүй буюу биелүүлээгүйгээс бусад тохиолдолд дипломат хамгаалалт олгох, эсхүл олон улсын нэхэмжлэл гаргахгүй. Энэ хэсгийн хувьд дипломат хамгаалалтад тухайн хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэхэд дөхөм үзүүлэх зорилгоор албан бус дипломат яриа хэлэлцээ явуулахыг хамруулахгүй болно.

22. Энэ зүйл нь 10.5, 10.6 дугаар зүйл эсхүл 10.9 дүгээр зүйлд хамаарах татварын арга хэмжээтэй холбоотой үүссэн маргаанд хэрэглэгдэнэ.

10.14 дүгээр зүйл

Түр хамгаалах арга хэмжээ

1. Аль нэг Тал нь дараахь тохиолдолд хөрөнгө оруулалттай холбоотой хил дамнасан хөрөнгийн гүйлгээ болон хөрөнгө оруулалттай холбоотой төлбөр, шилжүүлгийг хязгаарласан арга хэмжээ авч, эсхүл хэрэгжүүлж болно:

- (a) төлбөрийн тэнцэлд ноцтой нөхцөл байдал болон гадаад санхүүгийн хүндрэл үүссэн, эсхүл эдгээрээс үүсэх аюул учрах тохиолдолд;

(b) хөрөнгийн хөдөлгөөн нь макро эдийн засгийн удирдлага, тухайлбал мөнгөний болон валютын ханшны бодлогод ноцтой хүндрэл учруулсан, эсхүл учруулж болзошгүй байгаа онцгой тохиолдолд.

2. 1 дэх хэсэгт дурдсан хязгаарлах арга хэмжээ нь:

(a) Үндэсний нөхцөл болон Нэн тааламжтай үндэстний нөхцөлд үндэслэн хэрэглэгдэх;

(b) Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн холбогдох зүйлүүдтэй нийцсэн байх;

(c) нөгөө Талын худалдаа, эдийн засаг, санхүүгийн ашиг сонирхолд шаардлагагүй хохирол учруулахаас зайлсхийсэн байх;

(d) 1 дэх хэсэгт тодорхойлсон нөхцөл байдлыг шийдвэрлэхэд шаардагдах арга хэмжээнээс хэтрэхгүй байх;

(e) түр зуурынх байх, мөн 1 дэх хэсэгт дурдсан нөхцөл байдал сайжрахын хэрээр аажмаар арилгахаар байх.

3. 1 дэх хэсгийн дагуу баталсан, эсхүл хэрэгжүүлсэн аливаа хязгаарлалтыг, эсхүл тэдгээрийн өөрчлөлтийг нөгөө Талд нэн даруй мэдэгдэнэ.

4. Энэ зүйлийн аль ч заалтыг аль нэг Талын Олон улсын валютын сангийн хэлэлцээрийн дагуу оролцогчийн хувьд эдлэх эрх болон хүлээх үүргийг өөрчилж байгаагаар тайлбарлахгүй.

10.15 дугаар зүйл **Урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

1. Энэхүү бүлгийн бусад аль нэг заалтыг үл харгалзан, аль нэг Тал урьдчилан сэргийлэх шалтгаанаар санхүүгийн үйлчилгээтэй холбоотой тухайлбал, хөрөнгө оруулагч, мөнгө хадгалуулагч, даатгуулагч, эсхүл санхүүгийн үйлчилгээг нийлүүлэгч компаниас итгэмжлэгдсэн хувь хүнийг хамгаалах, эсхүл өөрийн санхүүгийн системийн бүрэн бүтэн, тогтвортой байдлыг хангах зорилгоор батлах, авч хэрэгжүүлэх арга хэмжээгээр хязгаарлахгүй.

2. 1 дэх хэсгийн дагуу аль нэг Талын баталсан, эсхүл хэрэгжүүлсэн арга хэмжээ нь энэ бүлэгтэй нийцэхгүй бол тэдгээр нь энэхүү бүлгээр тухайн Талын хүлээсэн үүрэг хариуцлагаас зайлсхийх арга хэрэгсэл болохгүй.

10.16 дугаар зүйл Ашгаас татгалзах

1. Аль нэг Тал нь нөгөө Талын хөрөнгө оруулагч болох аж ахуйн нэгжийг энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагч эзэмшдэг, эсхүл хяналтад буй бөгөөд татгалзагч тал нь дор дурдсан нөхцөлийг хангаж буй бол нөгөө Талын тухайн аж ахуйн нэгж болон түүний хөрөнгө оруулалтад энэ бүлгийн ашгийг олгохоос татгалзаж болно:

- (a) энэхүү хэлэлцээрт оролцогч бус талтай дипломат харилцаа тогтоогоогүй;
- (b) энэхүү хэлэлцээрт оролцогч бус Талын аж ахуйн нэгжтэй хийх гүйлгээг хориглосон, эсхүл нөгөө Талын аж ахуйн нэгж болон түүний хөрөнгө оруулалтад энэ бүлгийн дагуу олгосон давуу талыг зөрчсөн, эсхүл хүчингүй болгох арга хэмжээг баталсан эсхүл хэрэгжүүлсэн.

2. Аль нэг Тал нь нөгөө Талын хөрөнгө оруулагч болох аж ахуйн нэгжийг энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагч эзэмшдэг, эсхүл хяналтад буй бөгөөд тухайн аж ахуйн нэгж нөгөө Талын нутаг дэвсгэрт дорвитой бизнесийн үйл ажиллагаа явуулдаггүй бол нөгөө Талын тухайн хөрөнгө оруулагч болон түүний хөрөнгө оруулалтад энэ бүлгийн давуу талыг олгохоос татгалзаж болно.

10.17 дугаар зүйл Эрүүл мэнд, Аюулгүй байдал, Хүрээлэн буй орчны арга хэмжээ болон Хөдөлмөрийн стандарт

Талууд өөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, эсхүл хүрээлэн буй орчны арга хэмжээнүүдийг сулруулах, эсхүл хөдөлмөрийн стандартаа бууруулах замаар Тал тус бүрийн, эсхүл энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжихээс зайлсхийнэ. Энэ хүрээнд Тал бүр өөрийн нутаг дэвсгэр дээр Талуудын, эсхүл энэхүү хэлэлцээрт оролцогч бус талын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтыг байршуулах, худалдан авах, эсхүл өргөтгөхийг дэмжихэд зориулан дээр дурдсан арга хэмжээ, эсхүл стандартыг хэрэгсэхгүй байх, эсхүл бууруулах ёсгүй.

10.18 дугаар зүйл

Хөрөнгө оруулалтын дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд Хөрөнгө оруулалтын дэд хороо (энэ зүйлд цаашид “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэ бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) энэ бүлэгтэй холбоотой аливаа асуудлаар мэдээлэл солилцох;
- (c) энэ бүлэгтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэх;
- (d) Дэд хорооны хэлэлцүүлгийн үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;
- (e) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Талуудын Засгийн газраас гадна холбогдох аж ахуйн нэгжийн шаардлагатай мэргэжлийн туршлагатай төлөөлөгчдийг урьж болно.

5. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

6. Энэ зүйл нь 10.5, 10.6, эсхүл 10.9 дүгээр зүйлд хамаарах татварын арга хэмжээтэй холбоотой асуудалд хэрэглэгдэнэ.

10.19 дүгээр зүйл

Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрт хамаарах байдал

1. Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үл харгалзан энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдөр Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр цуцлагдана.

2. Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээр цуцлагдах өдрөөс өмнөх хөрөнгө оруулалт болон олсон ашгийн хувьд Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн 1-ээс 16 дугаар зүйл нь Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн 17 дугаар зүйлийн 3 дугаар хэсэгт заасны дагуу дээрх өдрөөс хойш 15 жилийн турш хүчин төгөлдөр байхыг Талууд нотлов.

3. 2 дахь хэсгийн зорилгоор энэхүү хэлэлцээрийн аль ч заалт Хоёр талт хөрөнгө оруулалтын хэлэлцээрийн холбогдох заалтын дагуу аль нэг Талын хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.

10.20 дугаар зүйл

Үргэлжлэх хугацаа болон хүчингүй болгох хугацаа

Энэхүү хэлэлцээрийг цуцлахаас өмнө хийсэн хөрөнгө оруулалтын хувьд энэ бүлгийн заалтууд болон энэ бүлэгтэй шууд холбоотой тус хэлэлцээрийн заалтууд нь хэлэлцээрийг цуцалсан өдрөөс хойш 10 жилийн хугацаанд хүчинтэй байна.

11 дүгээр бүлэг Өрсөлдөөн

11.1 дүгээр зүйл Өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаа

1. Тал бүр өөрийн хууль тогтоомжид нийцүүлэн тэдгээрийн зах зээлийн үр ашигтай байдлыг хангах үүднээс Талууд хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын урсгалыг хөнгөвчлөх зорилгоор өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааны эсрэг зохистой гэж үзсэн арга хэмжээг авна.

2. Энэ бүлгийн хувьд “өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаа” гэх нэр томъёо нь Талуудын өрсөлдөөний хууль тогтоомжийн дагуу торгуулах, эсхүл хөнгөлөлт үзүүлэхэд хамаарах аливаа байдал, эсхүл үйл ажиллагааг хэлнэ.

11.2 дугаар зүйл Өрсөлдөөний эсрэг үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хамтран ажиллах

1. Талууд өөрийн хууль тогтоомжийн дагуу өрсөлдөөнийг хязгаарласан үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр байгаа нөөц боломжийнхоо хүрээнд хамтран ажиллаж, харилцан тусална.

2. Энэ зүйлийн хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагаатай холбоотой нарийвчилсан зүйл болон журмыг Хэрэгжүүлэх хэлэлцээрт тодорхой заана.

11.3 дугаар зүйл Үл ялгаварлах

Тал бүр өрсөлдөөний тухай өөрийн хууль тогтоомжийг ижил нөхцөл байдалд байгаа аливаа этгээдийг тэдгээрийн харьяалалд нь үндэслэн ялгаварлахгүй байхаар хэрэгжүүлнэ.

11.4 дүгээр зүйл Журмын шударга байдал

Тал бүр өөрийн холбогдох хууль тогтоомжийн дагуу өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг хянах асуудалд захиргааны болон шүүхийн журмыг шударгаар хэрэгжүүлнэ.

11.5 дугаар зүйл
Ил тод байдал

Тал бүр өөрийн өрсөлдөөний хууль тогтоомж болон өрсөлдөөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг дэмжинэ.

11.6 дугаар зүйл
1.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон
16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай

Энэхүү бүлгийг 1.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 16 дугаар бүлэгт хэрэглэгдэхгүй.

12 дугаар бүлэг Оюуны өмч

12.1 дүгээр зүйл Ерөнхий заалт

1. Талууд энэ бүлэг болон хоёр Талын нэгдэн орсон оюуны өмчид хамаарах олон улсын хэлэлцээрийн дагуу оюуны өмчийн зохистой, үр дүнтэй болон үл ялгаварласан хамгаалалт олгож, оюуны өмчийн эрхийг зөрчихийн эсрэг арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2. Талууд оюуны өмчийн тогтолцооны удирдлагын үр ашигтай болон ил тод байдлыг мөн хөхиүлэн дэмжинэ.

3. Энэхүү бүлгийн аль ч заалт Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр болон хоёр Талын нэгдэн орсон оюуны өмчид хамаарах олон улсын бусад хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.

12.2 дугаар зүйл Тодорхойлолт

Энэхүү бүлэгт дурдсан “оюуны өмч” гэх нэр томьёонд Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрт заасан оюуны өмчийн бүх төрлийг ойлгоно.

12.3 дугаар зүйл Үндэсний нөхцөл

Тал бүр Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн 3 болон 5 дугаар зүйлийн дагуу оюуны өмчийн хамгаалалтын хувьд өөрийн иргэнд олгодоогоос дутуугүй тааламжтай нөхцөлийг нөгөө Талын иргэнд олгоно.

Тайлбар: Энэ зүйлийн зорилгоор:

- (a) “иргэн” гэх нэр томьёо нь Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрт дурдсантай адил утгатай байна;
- (b) “хамгаалалт” гэх нэр томьёонд оюуны өмчийн эрхийг хүртээмжтэй байлгах, олж авах, хүчинтэй байлгах, хэрэгжилтийг нь хангах, түүний хүрээ болон энэ бүлэгт тусгайлан заасан оюуны өмчийн эрхийг ашиглахад нөлөөлөх асуудлуудыг хамруулна;

- (с) “оюуны өмчийн хамгаалалт” гэх нэр томъёог илүү тодорхой болгох зорилгоор түүнд 12.12 дугаар зүйлд заасан шударга бус өрсөлдөөнийг хориглох асуудлыг хамруулна.

12.4 дүгээр зүйл

Журмын асуудал

1. Оюуны өмчийн тогтолцооны үр ашигтай удирдлагыг хангах зорилгоор Тал бүр оюуны өмчийн эрхэд хамаарах захиргааны журмыг боловсронгуй болгох талаар зохих арга хэмжээ авна.

2. Патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдгийн мэдүүлэг гаргах журам, эсхүл эдгээртэй холбоотой захиргааны бусад үйл ажиллагааны явцад өөрийн Талын эрх бүхий байгууллагад гаргасан баримт бичиг, үүнд өргөдөл, давамгайлах огнооны эрх хүссэн бол өмнөх аливаа мэдүүлгийн тухайн байгууллагад хүлээн зөвшөөрөгдсөн хэлээр үйлдсэн орчуулга, итгэмжлэл ба эрх шилжүүлсэн баталгаа зэрэгт зурсан гарын үсэг, эсхүл өөрийгөө тодорхойлох бусад тэмдэглэгээг жинхэнэ болох тухай нотолгоог шаардахгүй.

3. Аль нэг Тал нь 2 дахь хэсгийг үл харгалзан:

(a) патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, эсхүл барааны тэмдгийн бүртгэлээс татгалзах тохиолдолд нэг Талын хуульд энэ тухай заасан бол гарын үсэг, эсхүл өөрийгөө тодорхойлох бусад тэмдэглэгээг жинхэнэ болох тухай нотолгоог шаардаж болно;

(b) өөрийн Талын эрх бүхий байгууллагад гаргасан баримт бичигт зурсан гарын үсэг, эсхүл өөрийгөө тодорхойлох бусад тэмдэглэгээ жинхэнэ эсэхэд үндэслэл бүхий эргэлзэл байвал нотолгоо шаардаж болно. Эрх бүхий байгууллага тухайн этгээдэд нотолгоо ирүүлэх тухай мэдэгдэх бол мэдэгдэлдээ нотолгоо гаргуулах болсон шалтгааныг заана.

4. Аль ч Тал мэдүүлгийн хамт итгэмжлэл өгөхийг шаардаж, түүний анхдагч огноог тогтоох нөхцөл болгохгүй.

5. Тал бүр патентийн зуучлагч, эсхүл бүртгэгдсэн оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тогтолцоог боловсронгуй болгохыг эрмэлзэнэ.

6. Тал бүр оюуны өмчийн эрхийг олгох буюу бүртгэхэд мэдүүлгийг үндэсний журмаар, эсхүл олон улсын тохирох хэлэлцээрийн дагуу гаргасан эсэхээс үл шалтгаалж, оюуны өмчийн эрхийг олж авах үндсэн нөхцөлд нийцүүлэн хамгаалалтын хугацааг шаардлагагүйгээр богиносгохоос сэргийлж эрх олгох, эсхүл бүртгэх ажиллагааг зохистой хугацаанд гүйцэтгэх явдлыг хангана.

7. Тал бүр барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар, патентын бүртгэлийн тогтолцоотой байх бөгөөд үүнд:

- (a) мэдүүлэгт татгалзах шийдвэр гаргах тохиолдолд энэ тухай мэдүүлэг гаргагчид үндэслэлийг нь зааж бичгээр (цахим хэлбэрээр байж болно) мэдэгдэх шаардлага тавигдах;
- (b) захиргааны журмаар татгалзах шийдвэр гаргасан тохиолдолд мэдүүлэг гаргачид давж заалдах боломж олгох;
- (c) захиргааны эцсийн шийдвэрт мэдүүлэг гаргагч шүүхэд гомдол гаргах боломж олгох;
- (d) хууль тогтоомжид энэ тухай заасан бол сонирхогч этгээдэд:
 - (i) мэдүүлэг, эсхүл бүртгэлийн талаар эсэргүүцэл гаргах;
 - (ii) бүртгэлийг хүчингүй болгох, эсхүл хүчингүйд тооцуулах хүсэлт гаргах боломж олгоно.

12.5 дугаар зүйл **Ил тод байдал**

Тал бүр оюуны өмчийн тогтолцооны удирдлагын ил тод байдлыг цаашид хөхиүлэн дэмжих зорилгоор өөрийн хууль тогтоомжоор заасан хэмжээнд дараахь зохих арга хэмжээ авна:

- (a) наад зах нь дараахь мэдээллийг нийтэлнэ:
 - (i) патент олгох тухай шийдвэр, эсхүл гаргасан патентын мэдүүлэг болон олгосон патент;
 - (ii) бүртгэгдсэн ашигтай загвар;
 - (iii) бүтээгдэхүүний загварын эрх олгох тухай шийдвэр, эсхүл бүртгэгдсэн бүтээгдэхүүний загвар;

(iv) бүртгэгдсэн барааны тэмдэг болон/эсхүл барааны тэмдгийн мэдүүлэг;

мөн эдгээрийн хавтаст хэрэгт байгаа мэдээллийг наад зах нь сонирхогч этгээдэд түүний хүсэлт гаргасны дагуу гаргаж өгөх;

(b) оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг үр ашигтай хангах талаар авч буй арга хэмжээ болон оюуны өмчийн тогтолцоонд хамаарах бусад мэдээллийг нийтэд нээлттэй болгоно.

12.6 дугаар зүйл

Оюуны өмчийг хамгаалах талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх

Талууд оюуны өмчийг ашиглах болон оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх талаар боловсролын болон мэдээлэл түгээх төсөл хэрэгжүүлэх зэргээр оюуны өмчийг хамгаалах тухай олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авна.

12.7 дугаар зүйл

Патент

1. Патентийн мэдүүлгийн мөн чанар нь компьютерийн програмд хамааралтай гэх дан ганц үндэслэлээр түүнд татгалзах шийдвэр гаргахгүй байхыг Тал бүр хангана. Тийм боловч энэ зүйлийн уг хэсэг нь Тал бүрийн өөрийн хууль тогтоомжийн дагуу компьютерийн програмыг дангаар нь патентлагдах чадваргүй гэж заах эрхийг хөндөхгүй.

2. Мэдүүлэг гаргагч нэгээс илүү шинэ бүтээл агуулсан патентийн мэдүүлгийг тухайн Талын хууль тогтоомжид заасан хугацаанд өөрийн санаачилгаар хэд хэдэн патентийн мэдүүлэг болгон салгаж болохыг Тал бүр хангана.

12.8 дугаар зүйл

Бүтээгдэхүүний загвар

Тал бүр бүтээгдэхүүний загварт бүхэлд нь буюу зохих тохиолдолд хэсэгчлэн зохистой болон үр дүнтэй хамгаалалт олгоно.

12.9 дүгээр зүйл

Барааны тэмдэг

1. Аль ч Талд тухайн эзэмшигчийн бараа, үйлчилгээний хувьд нийтэд түгээмэл болсон барааны тэмдэгтэй ижил, эсхүл төсөөтэй барааны тэмдгийг шударга бус ашиг олох, эсхүл эзэмшигчид хохирол учруулах зэрэг шударга бус санаа агуулж ашиглах гэж байгаа болон/эсхүл ийнхүү ашиглах нь хэрэглэгчдийг төөрөгдөлд оруулж болзошгүй бол Тал бүр уг барааны тэмдгийг бүртгэхээс татгалзах, эсхүл бүртгэлийг хүчингүй болгоно.

Тайлбар: Тал бүр барааны тэмдгийг нийтэд түгээмэл болсныг өөрийн хууль тогтоомжийн дагуу тогтоож болно.

2. Барааны тэмдгийг бүртгүүлэх тухай мэдүүлгийн шүүлтийг зохих үндэслэл болон журмын шаардлагад нийцүүлэн шуурхай журмаар хийлгэх хүсэлтийг эрх бүхий байгууллагад гаргаж болохыг Тал бүр хангана. Ийм хүсэлт гаргасан бол эрх бүхий байгууллага мэдүүлгийн шүүлтийг зохих тохиолдолд шуурхай журмаар хийнэ.

12.10 дугаар зүйл

Зохиогчийн эрх ба түүнд хамаарах эрх

1. Тал бүр зохиогч, уран бүтээлч, фонограмм бүтээгчид тэдний бүтээл, фонограммд буулгасан тоглолт болон фонограммыг олон нийт өөрсдийн сонгосон цаг болон газраас хүртэх боломжтой байдлаар утсан болон утасгүй холбоогоор нийтэд хүртээл болгохыг зөвшөөрөх эрх олгоно.

2. Тал бүр өргөн нэвтрүүлгийн телевизийн байгууллагад түүний зөвшөөрөлгүйгээр дараахь үйлдлийг хийхийг хориглох эрх олгоно:

- (a) тэдний нэвтрүүлгийг дахин нэвтрүүлэх;
- (b) тэдний нэвтрүүлгийг бичлэгт буулгах;
- (c) тэдний нэвтрүүлгийн бичлэгийг хуулбарлах.

3. Тал бүр өөрийн хууль тогтоомжийн дагуу зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн хамтын удирдлагын байгууллагын үйл ажиллагааг дэмжих талаар зохих арга хэмжээ авна.

12.11 дүгээр зүйл Газар зүйн заалт

Тал бүр газар зүйн заалтын зохистой болон үр дүнтэй хамгаалалтыг өөрийн хууль тогтоомж болон Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн дагуу хангана.

12.12 дугаар зүйл Шударга бус өрсөлдөөн

1. Тал бүр Парисийн конвенцийн 10 *bis* зүйлийн дагуу шударга бус өрсөлдөөний үйлдлийн эсрэг үр дүнтэй хамгаалалт олгоно.

2. Тал бүр Парисийн конвенцийн 10 *bis* зүйлийн заалтыг үйлчилгээний хувьд *mutatis mutandis* зарчмаар хэрэглэнэ.

3. Энэ зүйлийн зорилгоор “Парисийн конвенц” гэх нэр томъёо нь 1900 оны 12 дугаар сарын 14-нд Брюссель хотноо, 1911 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Вашингтон хотноо, 1925 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр Гааг хотноо, 1934 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Лондон хотноо, 1958 оны 10 дугаар сарын 31-ний өдөр Лиссабон хотноо, болон 1967 оны 7 дугаар сарын 14-нд Стокгольм хотноо тус тус өөрчлөлт оруулсан бөгөөд 1979 оны 9 дүгээр сарын 28-нд нэмэлт, өөрчлөлт оруулсан, 1883 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисийн конвенцийг хэлнэ.

12.13 дугаар зүйл Хаалттай мэдээллийг хамгаалах

Тал бүр өөрийн хууль тогтоомжийн хүрээнд Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хаалттай мэдээллийг зохистой болон үр дүнтэй хамгаалалтаар хангах бөгөөд хувийн гэрээнд заасан хаалттай мэдээллийн хамгаалалтын хугацааг хязгаарлах, эсхүл хууль ёсны үндэслэлгүйгээр хаалттай мэдээллийг задлахыг шаардах арга хэмжээ авахгүй.

12.14 дүгээр зүйл Хэрэгжилтийг хангах – Хил дээр авах арга хэмжээ

1. Тал бүр импортын тээвэрлэлтэд хамаарах журмыг тогтоох буюу хэрэгжүүлэх бөгөөд үүний дагуу:

(a) гаалийн байгууллага нь барааны тэмдэг болон/эсхүл зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчилтэй байж болзошгүй барааг (цаашид “сэжигтэй бараа” гэх) өөрийн санаачилгаар саатуулж болох;

(b) эрх эзэмшигч сэжигтэй барааг саатуулах тухай хүсэлтийг Талын эрх бүхий байгууллагад гаргаж болно.

2.1 дэх хэсэгт заасан журмыг мөрдөж эхэлсний дараа эрх бүхий байгууллага зохих хугацаанд сэжигтэй барааг барааны тэмдэг болон/эсхүл зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчсөн эсэхийг тогтоож болох журмыг Тал бүр тогтоох буюу хэрэгжүүлнэ.

3. Импортын тээвэрлэлтийг 1 дэх хэсгийн дагуу саатуулах тохиолдолд энэ тухай импортлогч болон эрх эзэмшигчид нэн даруй мэдэгдэх бөгөөд сэжигтэй барааны талаарх байгаа бүх мэдээллээр хангана.

12.15 дугаар зүйл **Хэрэгжилтийг хангах – Иргэний арга хэмжээ**

Оюуны өмчийн эрхийг зөрчиж байгааг мэдсээр байж эсхүл мэдэх боломжтой байсаар атал эрх зөрчсөн үйл ажиллагаа явуулсны улмаас оюуны өмчийн эрх эзэмшигчид хохирол учирсан бол Тал бүр эрх эзэмшигчийг тухайн хохирлыг барагдуулахад хангалттай нөхөн төлбөрийг зөрчигчөөс гаргуулан авах эрхээр хангана.

12.16 дугаар зүйл **Хэрэгжилтийг хангах – Эрүүгийн арга хэмжээ**

1. Арилжааны ашиг олох зорилгоор наад зах нь барааны тэмдгийн зөрчилтэй хуурамч барааг санаатайгаар үйлдвэрлэх, эсхүл зохиогчийн эрхийг зөрчих тохиолдолд Тал бүрийн явуулах эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа болон ногдуулах шийтгэлийг Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн 61 дүгээр зүйлийн дагуу зохицуулна.

2. Тал бүр 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хувьд өөрийн хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагадаа зөрчилтэй бүх барааг хураах, эсхүл устгах арга хэмжээ авах эрх мэдлийг олгоно.

12.17 дугаар зүйл

Хэрэгжилтийг цахим орчинд хангах

Хэрэгжилтийг хангах Тал бүрийн журамд зохиогчийн эрх буюу түүнд хамаарах эрхийг цахим сүлжээнд зөрчих асуудлыг хамруулах бөгөөд үүнд зөрчил үйлдэх зорилгоор олон нийтэд түгээх хэрэгслийг хууль бусаар ашиглахыг хамруулж болно. Энэ журмыг хууль ёсны үйл ажиллагаанд, үүнд цахим худалдаанд, саад учруулахгүйгээр хэрэгжүүлэх бөгөөд тухайн Талын хууль тогтоомжид нийцүүлэн өөрийгөө илэрхийлэх эрх чөлөө, шударга ёс болон хувийн амьдралыг хамгаалах үндсэн зарчмыг баримтална.

12.18 дугаар зүйл

Оюуны өмчийн дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд Оюуны өмчийн дэд хороо (цаашид “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

(a) энэ бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;

(b) энэ бүлгийн заалтуудын хүрээнд оюуны өмчийн хамгаалалтыг сайжруулах, оюуны өмчийн эрхийн хэрэгжилтийг хангах болон оюуны өмчийн тогтолцооны удирдлагын ил тод ба үр дүнтэй байдлыг хөхиүлэн дэмжих зорилгоор оюуны өмчид хамаарах асуудлыг хэлэлцэх;

(c) Дэд хорооны хэлэлцүүлгийн үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;

(d) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

12.19 дүгээр зүйл

Аюулгүй байдалтай холбоотой үл хэрэглэх тохиолдол

Энэхүү бүлгийн зорилгоор Худалдаанд хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээрийн 73 дугаар зүйлийг энэхүү хэлэлцээрт нийлүүлэх бөгөөд

энэ нь *mutatis mutandis* зарчмын дагуу хэлэлцээрийн бүрэлдэхүүн хэсэг болно.

13 дугаар бүлэг

Засгийн газрын худалдан авах ажиллагаа

13.1 дүгээр зүйл

Худалдан авах ажиллагааны зарчим

Үйлдвэрлэл худалдааг өргөжүүлэх болон эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжихэд Засгийн газрын худалдан авах ажиллагаа чухал болохыг хүлээн зөвшөөрч, талуудын хууль тогтоомжийн дагуу Засгийн газрын худалдан авах ажиллагаатай холбоотой арга хэмжээний ил тод байдлыг хангана. Түүнчлэн талуудын хөгжлийн, санхүүгийн болон худалдааны хэрэгцээг харгалзан үзэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч байна. Талууд Засгийн газрын худалдан авах ажиллагаатай холбоотой арга хэмжээг шударга, үр дүнтэй хэрэгжүүлэх явдлыг хангана.

13.2 дугаар зүйл

Мэдээлэл солилцох

Талууд Засгийн газрын түвшинд Засгийн газрын худалдан авах ажиллагааны талаарх холбогдох хууль тогтоомж, бодлого, туршлага, мөн түүнчлэн одоо мөрдөж буй Засгийн газрын худалдан авах ажиллагааны тогтолцоонд хийх аливаа шинэчлэлт өөрчлөлтийн тухай мэдээллийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн аль болох англи хэлээр тухай бүр харилцан солилцоно.

13.3 дугаар зүйл

Нэмэлт хэлэлцээ

Монгол Улс ДХБ-ын хэлэлцээрийн 4 дүгээр хавсралтын Засгийн газрын худалдан авах ажиллагааны хэлэлцээр (цаашид энэ бүлэгт “ЗГХААХ” хэлэлцээр” гэх)-ийн тал болох хүсэлтээ илэрхийлсэн үед Засгийн газрын худалдан авах ажиллагааны тухай иж бүрэн бүлэг бий болгох зорилгоор Талууд энэхүү бүлгийг дахин хэлэлцэх хэлэлцээ хийнэ.

Тайлбар: ЗГХААХ-т нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл өөр хэлэлцээрээр түүнийг хүчингүй болгосон тохиолдолд энэ бүлгийн зүйлийн зорилгод нийцүүлэн ЗГХААХ гэдэг нь тухайн нэмэлт, өөрчлөлт оруулсан, эсхүл шинэ хэлэлцээрийг хэлнэ.

13.4 дүгээр зүйл

Үл ялгаварлах талаарх хэлэлцээ

Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш аль нэг Тал энэхүү хэлэлцээрт оролцогч бус талд өөрийн Засгийн газрын худалдан авах ажиллагааны зах зээлд нэвтрэх аливаа давуу тал, эсхүл Засгийн газрын худалдан авах ажиллагаатай холбоотой арга хэмжээнд аливаа давуу нөхцөл олгохоор санал болгосон тохиолдолд уг тал нь нөгөө талын хүсэлтээр эдгээр давуу тал, эсхүл давуу нөхцөлийг харилцан адил байх зарчимд тулгуурлан олгох зорилгоор хэлэлцээ хийх зохих боломжийг нөгөө талд олгоно.

13.5 дугаар зүйл

Засгийн газрын худалдан авах ажиллагааны дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд Засгийн газрын худалдан авах ажиллагааны дэд хороо (цаашид энэ бүлэгт "Дэд хороо" гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

- (a) энэ бүлгийн хэрэгжилтийг хянан үзэх, хяналт тавих;
- (b) талуудын Засгийн газрын худалдан авах ажиллагааны зах зээлийн талаарх боломжит бэлэн мэдээлэлд дүн шинжилгээ хийх;
- (c) цахим худалдан авах ажиллагаа болон хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр хамтран ажиллах;
- (d) дэд хорооны үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;
- (e) хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

14 дүгээр бүлэг Бизнесийн орчныг сайжруулах

14.1 дүгээр зүйл Үндсэн зарчим

1. Тал бүр өөрийн холбогдох хууль тогтоомжийн дагуу өөрийн Талд бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа нөгөө Талын этгээдэд зориулан бизнесийн орчныг илүү сайжруулах зохих арга хэмжээг авна.

2. Талууд өөрийн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд холбогдох Талуудын бизнесийн орчныг сайжруулах чиглэлээр хамтын ажиллагаагаа хөгжүүлнэ.

14.2 дугаар зүйл Бизнесийн орчныг сайжруулах дэд хороо

1. Энэхүү бүлэгт заасан үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор Талууд Бизнесийн орчныг сайжруулах дэд хороо (цаашид энэ бүлэгт “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо нь дараахь чиг үүрэгтэй:

- (a) Тал тус бүрээс энэ бүлгийн 14.3 дугаар зүйлийн дагуу томилох Бизнесийн орчныг сайжруулах харилцах газар (цаашид энэ бүлэгт “харилцах газар” гэх)-аас тайлагнасан дүгнэлтийг хянан үзэх;
- (b) Харилцах газраас тайлагнасан дүгнэлтийг, эсхүл өөрийн санаачилгаар бизнесийн орчинтой холбоотой асуудлыг яаралтай шийдвэрлэх арга замыг хайх, анхаарлаа хандуулах;
- (c) Талуудын авах арга хэмжээний талаар зөвлөмж болон үр дүн, дүгнэлтийг Талуудад тайлагнах;
- (d) шаардлагатай тохиолдолд (c) дэд хэсэгт дурдсан зөвлөмжтэй холбогдуулан Талуудын авсан арга хэмжээг хянан үзэх;
- (e) (c) дэд хэсэгт дурдсан зөвлөмж болон (d) дэд хэсэгт дурдсан хяналт шалгалтын үр дүнг боломжтой хэлбэрээр олон нийтэд нээлттэй байлгах;

(f) Ажлыг давхардуулахгүй байх үүднээс энэхүү хэлэлцээрийн дагуу байгуулагдсан бусад Дэд хороотой зохих байдлаар хамтран ажиллах. Уг хамтын ажиллагаа нь дараахь хэлбэртэй байж болно:

(i) бусад Дэд хороонд холбогдох ажлын үр дүнг мэдээллэх;

(ii) бусад Дэд хорооны саналыг авах;

(iii) Дэд хороонд бусад Дэд хорооны гишүүдийг урих;

(iv) шаардлагатай тохиолдолд бусад Дэд хороонд тухайн асуудлыг шилжүүлэх;

(g) заалтад дурдсан зөвлөмж болон дүгнэлтийг Хамтарсан хороонд шуурхай тайлагнах;

(h) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад ажил үүргийг гүйцэтгэх.

3. Дэд хороо нь тухайн асуудлыг хариуцсан холбогдох яам, эсхүл агентлагын албан тушаалтныг оролцуулсан Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Дэд хороо нь Засгийн газрын холбогдох байгууллагаас гадна тухайн асуудалтай холбоотой байгууллага болон мэргэжлийн хүмүүсийг урьж оролцуулж болно.

4. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт эсхүл, тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ.

14.3 дугаар зүйл Харилцах газар

1. Тал бүр энэ бүлгийн зорилгоор Харилцах газрыг томилон ажиллуулна.

2. Энэхүү Харилцах газрын чиг үүрэг болон бусад дэлгэрэнгүй зүйлийг Хэрэгжүүлэх хэлэлцээрт тусгана.

14.4 дүгээр зүйл 16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай

Энэхүү бүлгийг 16 дугаар бүлэгт хэрэглэгдэхгүй.

15 дугаар бүлэг Хамтын ажиллагаа

15.1 дүгээр зүйл Үндсэн зарчим

Талууд өөрсдийн холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Талуудын хоорондын барааны болон үйлчилгээний худалдаа, хөрөнгө оруулалтыг цаашид чөлөөлөх, хөнгөвчлөх бөгөөд Талуудын ард түмний сайн сайхан, тогтвортой хөгжлийг дэмжих зорилгоор энэхүү хэлэлцээрт тусгасан хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжинэ. Энэ зорилтын хүрээнд Талууд тэдгээрийн Засгийн газар хоорондын цаашдын хамтын ажиллагааг идэвхжүүлж, Талуудын холбогдох байгууллага, түүний дотор аль нэг тал, эсхүл хоёулаа Талуудын Засгийн газрын бус байгууллага хоорондын дараахь салбар дахь хоёр талын хамтын ажиллагааг дэмжинэ:

- (a) хөдөө аж ахуй, ойн аж ахуй болон загасны аж ахуй, мөн 5 дугаар бүлэгт дурдсан эрүүл ахуй, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээнд холбоотой асуудал;
- (b) аж үйлдвэрлэл, түүний дотор 6 дугаар бүлэгт дурдсан техникийн зохицуулалт, стандарт болон тохирлын үнэлгээний журамд хамаарах асуудал;
- (c) жижиг болон дунд үйлдвэрлэл;
- (d) худалдаа болон хөрөнгө оруулалт;
- (e) дэд бүтэц, барилга, хот байгуулалт;
- (f) шинжлэх ухаан, технологи болон оюуны өмч;
- (g) санхүүгийн үйлчилгээ;
- (h) боловсрол болон хүний нөөцийн хөгжил;
- (i) аялал жуулчлал;
- (j) байгаль орчин;
- (k) уул уурхай болон эрчим хүч;
- (l) эрүүл мэнд;
- (m) өрсөлдөөн;

(n) мэдээлэл, харилцаа холбооны технологи;

(o) Талуудын Засгийн газар харилцан тохиролцсон бусад салбар.

15.2 дугаар зүйл

Хамтын ажиллагааны салбар болон хэлбэр

Энэхүү бүлгийн хүрээнд заасан хамтын ажиллагааны салбар болон хэлбэрийг Хэрэгжүүлэх хэлэлцээрт тусгана.

15.3 дугаар зүйл

Хамтын ажиллагааны зардал

1. Талууд энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа 15.1 дүгээр зүйлд дурдсан салбарт хамтын ажиллагаа өрнүүлэх бололцоог эрэлхийлэх болон энэ бүлгийн хүрээнд явуулах хамтын ажиллагааг цаг хугацаанд нь, үр ашигтай бөгөөд үр дүнтэй хэрэгжүүлэх явдлыг хангах яриа хэлэлцээг эхлүүлнэ.

2. Талууд өөрийн холбогдох хууль тогтоомжийн дагуу энэ бүлэгт заасан хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө болон бусад нөөцийг бүрдүүлэх талаар хүчин чармайлт гаргана.

3. Хөрөнгө болон нөөцийг үр дүнтэй, үр ашигтай ашиглах замаар энэ бүлгийн хүрээнд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зардлыг Талууд харилцан тохиролцох байдлаар шийдвэрлэнэ.

15.4 дүгээр зүйл

Хамтын ажиллагааны дэд хороо

1. Энэхүү бүлгийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилгоор Талууд Хамтын ажиллагааны дэд хороо (цаашид энэ зүйлд “Дэд хороо” гэх)-г үүгээр байгуулав.

2. Дэд хороо дараахь чиг үүрэгтэй байна:

(a) энэхүү бүлгийн үр дүнтэй хэрэгжилт, үйл ажиллагааг хянан үзэх, хяналт тавих;

(b) 15.1 дүгээр зүйлд дурдсан салбар тус бүрийн хамтын ажиллагааны талаар мэдээлэл солилцох;

- (c) Талуудын цаашдын хамтын ажиллагааны арга замыг тодорхойлох;
- (d) энэхүү бүлэгтэй холбоотой аливаа асуудлыг хэлэлцэх;
- (e) энэхүү хэлэлцээрийн дагуу байгуулагдсан бусад Дэд хорооноос гаргасан хамтын ажиллагааны саналыг хэлэлцэх;
- (f) энэхүү бүлэгт заасан хамтын ажиллагааны үйл ажиллагааны талаар зохих үед Хамтарсан хороонд зөвлөмж гаргах;
- (g) энэхүү бүлгийн хэрэгжилт, тухайлбал Талуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбоотойгоор Дэд хорооны хэлэлцүүлгийн үр дүн болон дүгнэлтийг Хамтарсан хороонд тайлагнах;
- (h) Хамтарсан хорооноос даалгаж болох бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

3. Дэд хороо нь зохих үед Талуудын одоогийн хэрэгжүүлж буй Хөгжлийн албан ёсны тусламжийн асуудлаарх зөвлөлдөх механизм болон энэхүү хэлэлцээрийн хамтын ажиллагааг цаг хугацаанд нь, үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны бусад хэлбэрийг хүлээн зөвшөөрч, тэдэнтэй мэдээлэл солилцно.

4. Дэд хороо нь Талуудын Засгийн газрын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Дэд хороо нь хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан тухайн асуудлаар мэргэшсэн Талуудын Засгийн газрын бус холбогдох байгууллагын төлөөллийг урьж болно.

5. Дэд хороо нь хурлаа Талуудын харилцан тохиролцсоны дагуу товлосон хугацаанд болон газарт, эсхүл тохиролцсон бусад хэлбэрээр хийнэ. Дэд хороо нь анхны хуралдаанаа энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор зохион байгуулах талаар хүчин чармайлт гаргахыг эрмэлзэнэ.

15.5 дугаар зүйл **16 дугаар бүлгийг үл хэрэглэх тухай**

Энэхүү бүлгийг 16 дугаар бүлэгт хэрэглэхгүй.

16 дугаар бүлэг Маргаан шийдвэрлэх

16.1 дүгээр зүйл Хамрах хүрээ

Энэхүү хэлэлцээрт өөрөөр зохицуулаагүй бол энэ бүлэгт дурдсан маргаан шийдвэрлэх журам нь хэлэлцээрийг тайлбарлах болон/эсхүл хэрэглэх үед гарсан маргааныг шийдвэрлэх, маргаан үүсэхээс зайлсхийх зорилготой байна.

16.2 дугаар зүйл Ерөнхий зарчим

Талууд энэхүү хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэглэх талаар нэгдсэн ойлголтод хүрэх чармайлт гаргана. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах болон/эсхүл хэрэглэх явцад гарсан аливаа асуудлыг хамтран ажиллах, зөвлөлдөх болон бусад бүхий л аргаар түргэн шуурхай, харилцан тааламжтай шийдвэрт хүрэх боломжийг эрэлхийлнэ.

16.3 дугаар зүйл Шүүхийн сонголт

1. Энэхүү бүлгийн зохицуулалт нь хоёр талын нэгдэн орсон ДХБ-ын хэлэлцээр зэрэг олон улсын аливаа хэлэлцээрийн маргаан шийдвэрлэх журмыг хэрэглэх Талуудын эрхийг хязгаарлахгүй. Гомдол гаргагч Тал нь маргааныг шийдвэрлэх шүүхийг сонгох эрхтэй.

2. Дээрх 1 дэх хэсэгт зааснаас үл хамаарч хэрэв Гомдол гаргагч Тал аливаа маргааныг шийдвэрлүүлэх үүднээс энэ бүлгийн дагуу, эсхүл хоёр талын нэгдэн орсон олон улсын аливаа хэлэлцээр болон ДХБ-ын хэлэлцээрийн 2 дугаар хавсралт дахь Маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах дүрмийн тухай харилцан ойлголцох баримт бичгийн дагуу маргаан шийдвэрлэх арбитр байгуулах хүсэлт гаргасан тохиолдолд дээрх хэсгийг үл хамаарч, тухайн маргааныг эцэслэн шийдвэрлэхэд зөвхөн сонгосон журам үйлчилж, аливаа бусад журмыг хэрэглэх боломжгүй болно.

16.4 дүгээр зүйл Зөвлөлдөх

1. Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах болон/эсхүл хэрэглэхтэй холбоотой аливаа асуудлаар зөвлөлдөх хүсэлтийг Талууд бичгээр хүргүүлэхийг хүсэж болно.

2. Дээрх 1 дэх хэсгийн дагуу гаргасан зөвлөлдөх хүсэлтэд Гомдол гаргагч Тал хүсэлт гаргаж буй шалтгаан, түүний дотор асуудал үүсгэж буй арга хэмжээ, эрх зүйн болон бодит үндэслэлийг дурдана.

3. Гомдол хариуцагч Тал нь дээр дурдсан хүсэлтэд шуурхай хариу өгч, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 40 хоногийн дотор Гомдол гаргагч Талтай сайн санааны үндсэн дээр зөвлөлдөөн хийнэ. Түргэн гэмтэх бараатай холбоотой зэрэг яаралтай тохиолдолд Гомдол хариуцагч Тал хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор зөвлөлдөөн хийнэ.

4. Талууд энэхүү зүйлд дурдсаны дагуу зөвлөлдөж, харилцан хүлээн авч болохуйц шийдвэрт хүрэх бүхий л хүчин чармайлтыг гаргана. Зөвлөлдөөний үед Талууд асуудлыг бүрэн судлахад хангалттай мэдээллийг харилцан өгнө.

5. Энэ зүйлд дурдсаны дагуу зөвлөлдөх үед Талууд зөвлөлдөж буй асуудлаар мэргэшсэн ажилтнуудыг холбогдох агентлаг болон байгууллагуудаас татан оролцуулахыг чармайна.

6. Энэ зүйлд дурдсаны дагуу хийж буй зөвлөлдөөн нь нууц байх бөгөөд Талуудын цаашдын бусад эрх үүргийг хөндөхгүй.

7. Энэ зүйлд дурдсаны дагуу хийж буй зөвлөлдөөнийг биечлэн уулзах буюу Талуудын тохиролцсоны дагуу аливаа технологийн шийдлийг ашиглан явуулж болно. Хэрэв Талууд зөвлөлдөөнийг биечлэн уулзах хэлбэрээр явуулах тохиолдолд хоёр талын харилцан тохиролцсон газарт, тохиролцоогүй бол Гомдол хариуцагч Талын нийслэл хотод явуулна.

16.5 дугаар зүйл

Сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх буюу зуучлах

1. Сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх буюу зуучлуулах хүсэлтийг аль ч Тал ямар ч үед гаргаж болно. Эдгээр үйл ажиллагаа нь Талууд тохиролцсоны дагуу ямар ч үед эхэлж, нөгөө Талын хүсэлтийн дагуу ямар ч үед дуусч болно.

2. Хэрэв Талууд тохиролцвол сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх буюу зуучлах үйл ажиллагаа нь энэ бүлэгт дурдсан арбитрын шүүхийн үйл ажиллагаатай давхцан явагдаж болно.

3. Сайн дурын үйлчилгээ үзүүлэх, эвлэрүүлэх буюу зуучлах үйл ажиллагаа болон энэхүү үйл ажиллагааны үед Талуудын илэрхийлсэн байр суурь нь нууц байх бөгөөд Талуудын цаашдын бусад эрх үүргийг хөндөхгүй.

16.6 дугаар зүйл **Арбитрын шүүх байгуулах**

1. Гомдол гаргагч Тал дор дурдсан тохиолдолд бичгээр арбитрын шүүх байгуулах тухай хүсэлтийг Гомдол хариуцагч Талд гаргаж болно. Үүнд:

(a) Гомдол хариуцагч Тал 16.4 дүгээр зүйлд заасны дагуу зөвлөлдөх хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 40 хоног буюу түргэн гэмтэх бараатай холбоотой зэрэг яаралтай тохиолдолд 20 хоногийн дотор зөвлөлдөөгүй; эсхүл

(b) Талууд 16.4 дүгээр зүйлд заасны дагуу зөвлөлдсөний үндсэн дээр маргааныг зөвлөлдөх хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 60 хоног буюу түргэн гэмтэх бараатай холбоотой зэрэг яаралтай тохиолдолд 30 хоногийн дотор шийдвэрлэж чадаагүй,

мөн Гомдол гаргагч Тал нь энэхүү хэлэлцээрийн дагуу шууд болон шууд бусаар хүртэж буй ямарваа нэг үр ашиг Гомдол хариуцагч Талын энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас, эсхүл энэхүү хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэгтэй зөрчилдсөн арга хэмжээ авснаас үүдэн цуцлагдсан буюу багассан гэж үзсэн тохиолдолд.

2. Энэ зүйлийн дагуу арбитрын шүүх байгуулах тухай аливаа хүсэлт нь ийнхүү хүсэлт гаргах болсон доорх шалтгаануудыг дурдсан байх ёстой. Үүнд:

(a) зөрчигдсөн гэж үзэж буй энэхүү хэлэлцээрийн тодорхой заалт болон холбогдох олон улсын эрх зүйн заалтыг дурдсан нэхэмжлэлийн хууль зүйн үндэслэл;

(b) нэхэмжлэлийн бодит үндэслэл.

16.7 дугаар зүйл

Арбитрын шүүхийн бүрэлдэхүүн

1. Арбитрын шүүх нь холбогдох техникийн болон эрх зүйн мэдлэг бүхий гурван арбитрчаас бүрдэнэ.

2. Арбитрын шүүх байгуулах хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Тал тус бүр өөрийн улсын иргэн байж болох нэг арбитрчийг томилох бөгөөд арбитрын шүүхийг даргалах гурав дахь арбитрчаар сонгогдох гурав хүртэлх нэр дэвшигчийг санал болгоно. Гурав дахь арбитрч нь аль нэг Талын иргэн биш, аль нэг Талд байнга оршин суудаггүй, мөн Аль нэг талд хөдөлмөр эрхэлдэггүй байхаас гадна уг маргааныг шийдвэрлэхэд ямар нэгэн байдлаар оролцож байгаагүй байх ёстой.

3. Арбитрын шүүх байгуулах хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор Талууд гурав дахь арбитрчийг 2 дахь хэсгийн дагуу санал болгосон нэр дэвшигчдээс сонгон томилохыг эрмэлзэнэ.

4. Хэрэв аль нэг Тал 2 дахь хэсгийн дагуу нэг арбитрч томилоогүй, эсхүл Талууд 3 дугаар хэсэгт дурдсаны дагуу гурав дахь арбитрч дээр тохиролцож чадаагүй бол арбитрч буюу арбитрчдыг 2 дахь хэсгийн дагуу санал болгосон нэр дэвшигчдээс 10 хоногийн дотор сугалааны зарчмаар сонгоно.

5. Арбитрын шүүхийн байгуулагдсан огноо нь арбитрын шүүхийн даргыг томилсон огноо байна.

6. Энэ ззүйлийн дагуу томилогдсон аль нэгэн арбитрч огцорсон, нас барсан буюу бусад байдлаар үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд тус арбитрчийг томилсонтой ижил байдлаар оронд нь томилогдох арбитрчийг томилно. Оронд нь томилогдсон арбитрч анхдагч арбитрчийн бүхий л эрх үүргийг өвлөнө. Арбитрын шүүхийн үйл ажиллагаа нь өөр арбитрч томилогдтол түр зогсоно.

16.8 дугаар зүйл

Арбитрийн шүүхийн чиг үүрэг

1. Дээрх 16.6 болон 16.7 дугаар зүйлийн дагуу байгуулагдсан арбитрын шүүх дор дурдсан чиг үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- (a) шийдвэрлэх хэргийн хувьд тухайн асуудалд бодит үнэлгээ дүгнэлт хийсэн, энэхүү хэлэлцээрийн үйлчлэл болон хэлэлцээрт нийцсэн байдал зэргийг багтаасан бодит дүгнэлт гаргах;
- (b) Талуудтай байнга зөвлөлдөж, тэдэнд ийнхүү зөвлөлдөх тэнцүү боломж олгох бөгөөд харилцан хүлээн авч болохуйц шийдвэр гаргах хангалттай боломжоор хангах;
- (c) арбитрын шийдвэрээ энэхүү хэлэлцээр болон олон улсын хуулийн дагуу гаргах;
- (d) арбитрын шийдвэрт хууль зүйн болон бодит нөхцөл байдлын дүгнэлтийг дүгнэлтэд хүрсэн учир шалтгааны хамт тусгах;
- (e) хэрэв аль нэг Талаас хүсэлт гаргасан тохиолдолд арбитрын шийдвэрт Талууд 16.11 дүгээр зүйлтэй холбогдуулан авч үзэх шийдвэр хэрэгжүүлэхэд шаардагдах хугацааны тухай санал бүхий хэрэгжүүлэх арга замуудыг санал болгон хавсаргах.

2. Арбитрийн шүүх Талуудаас шаардлагатай болон зохимжтой гэж үзсэн холбогдох мэдээллийг авч болно. Талууд арбитрийн шүүхээс ирүүлсэн шаардлагатай болон зохимжтой гэж үзсэн холбогдох мэдээлэл авах тухай аливаа хүсэлтэд түргэн шуурхай, бүрэн хариулт өгөх үүрэгтэй.

3. Арбитрийн шүүх нь мэдээллийг холбогдох ямар ч эх сурвалжаас авч болох бөгөөд асуудалтай холбоотой тодорхой зүйлийн талаар мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдөж, тэдний саналыг авч болно. Арбитрийн шүүх нь Талуудаас гаргаж тавьсан шинжлэх ухаан, техникийн холбогдолтой баримт мэдээллийн талаар мэргэжлийн хүмүүсээс бичгээр зөвлөгөө мэдээлэл авч болно.

4. Арбитрын шүүхээс дээрх 3 дахь хэсгийн дагуу авсан аливаа мэдээллийг Талуудад нээлттэй болгоно.

16.9 дүгээр зүйл **Арбитрийн шүүхийн үйл ажиллагаа**

1. Арбитрын шүүх нь хаалттай хуралдана. Талууд зөвхөн арбитрын шүүхээс хуралдаанд урилгын дагуу хуралдаанд оролцоно.

2. Арбитрын шүүхийн үйл ажиллагаа явуулах газрыг Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр сонгох бөгөөд ийнхүү тохиролцож чадаагүй тохиолдолд арбитрын шүүхийн эхний хуралдааныг Гомдол хариуцагч Талын нийслэл хотод хийж, цаашид Талуудын нутаг дэвсгэрт ээлжлэн хуралдана.

3. Арбитрын бүрэлдэхүүний шийдвэр гаргах хэлэлцүүлэг болон арбитрын шүүхэд хүргүүлсэн баримт бичгүүд нууц байна.

4. Дээрх 3 дахь хэсэгт зааснаас үл хамаарч аль ч Тал маргааны талаарх өөрийн байр суурийг илэрхийлсэн мэдэгдлийг олон нийтэд хийж болох боловч нөгөө Талын нууц гэж тогтоосон, арбитрын шүүхэд хүргүүлсэн мэдээлэл болон бичгэн мэдүүлгийн нууц байдлыг хадгална. Аль нэг Тал нууц гэж үзэж, арбитрын шүүхэд мэдээлэл болон бичгэн мэдүүлгийг хүргүүлвэл, нөгөө Тал нь олон нийтэд мэдэгдэж болох мэдээллийн нууц бус хураангуйг, эсхүл бичгээр ирүүлсэн мэдүүлгийг хүсэж болно. Ийм хүсэлт хүлээн авсан Тал нь хүсэлтийн дагуу нууц бус хураангуйг ирүүлж болох ч, мөн ямар нэгэн шалтгаан буюу үндэслэл тайлбар хийхгүйгээр хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж болно.

5. Талуудад арбитрын үйл ажиллагааны үеэр аливаа танилцуулга, мэдүүлэг болон эсрэг талын мэдүүлгийн үед байлцах боломжийг олгоно. Аль нэг Талын арбитрын шийдвэрийн төслийн тайлбар хэсэгт өгсөн аливаа тайлбар мэдээлэл болон арбитрын шүүхийн асуулгын хариулт зэрэг мэдээлэл болон бичгэн мэдүүлгийг нөгөө Талд мэдэгдэнэ.

6. Арбитрын шүүхийн шийдвэрийг Талуудыг байлцуулахгүйгээр төлөвлөнө.

7. Арбитрын шүүх нь байгуулагдсан өдрөөсөө хойш 120 хоногийн дотор буюу түргэн гэмтэх бараатай холбоотой зэрэг яаралтай тохиолдолд 60 хоногийн дотор Талуудад тайлбар хэсэг, магадлагаа, дүгнэлт бүхий хэсэгтэй шийдвэрийн төслийг хянуулах зорилгоор хүргүүлнэ. Хэрэв арбитрын шүүх дээр дурдсан 120 буюу 60 хоногийн дотор шийдвэрийн төслийг хүргүүлэх боломжгүй гэж үзвэл Талууд зөвшөөрсний үндсэн дээр энэ хугацааг сунгаж болно. Гэхдээ ямар ч тохиолдолд Талуудад шийдвэрийн төсөл хүргүүлэх хугацаа нь арбитрын шүүх байгуулагдсан өдрөөс хойш 150 хоногоос хэтрэхгүй. Тал тус бүр шийдвэрийн төслийг тэдэнд хүргүүлснээс хойш 30 хоногийн дотор шийдвэрийн төсөлд бичгээр тайлбар өгч болно.

8. Арбитрын шүүх Талуудад шийдвэрийн төслийг хүргүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн дараа шийдвэрээ танилцуулна.

9. Арбитрын шүүх нь гаргаж буй бүх шийдвэрээ зөвшилцлийн үндсэн дээр гаргахыг эрмэлзэх боловч олонхийн саналаар мөн шийдвэрлэж болно.

10. Арбитрын шүүхийн шийдвэр нь Талуудын хувьд эцсийнх байх бөгөөд түүнийг заавал дагаж мөрдөнө.

16.10 дугаар зүйл

Арбитрын шүүхийн үйл ажиллагааг зогсоох

Талууд арбитрын шүүхийн шийдвэр гарахаас өмнө хэдийд ч харилцан тохиролцож, шүүх бүрэлдэхүүнийг даргалагчид хамтран мэдэгдсэнээр арбитрын шүүхийн үйл ажиллагааг зогсоож болно. Энэ тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг даргалагч арбитрын шүүхийн үйл ажиллагааг даруй зогсооно.

16.11 дүгээр зүйл

Шийдвэр хэрэгжүүлэх

1. Талууд өөрөөр тохиролцоогүй тохиолдолд Гомдол хариуцагч Тал нь 16.8 болон 16.9 дүгээр зүйлийн дагуу гарсан арбитрын шүүхийн шийдвэрийг даруй биелүүлэх үүрэгтэй. Хэрэв энэ нь боломжгүй бол Гомдол хариуцагч Тал арбитрын шийдвэрийг боломжит хугацааны дотор биелүүлнэ.

2. Дээрх 1 дэх хэсэгт дурдсан боломжит хугацааг Талууд арбитрын шүүхийн шийдвэрт хавсаргасан санал болгосон хугацааг харгалзан харилцан тохиролцоно. Хэрэв Талууд арбитрын шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш 45 хоногийн дотор боломжит хугацааг харилцан тохиролцож чадахгүй тохиолдолд аль ч Тал боломжит хугацааг тогтоолгохоор арбитрын шүүхэд хандаж болно.

3. (a) хэрэв Гомдол хариуцагч Тал боломжит хугацаанд багтаан арбитрын шийдвэрийг биелүүлэх боломжгүй гэж үзвэл тэрхүү хугацааг дуусахаас өмнө Гомдол хариуцагч Тал харилцан хүлээн авч болохуйц нөхөн төлбөр, эсхүл аливаа бусад тохиролцоонд хүрэх талаар Гомдол хариуцагч Талтай зөвлөлдөөнийг эхлүүлнэ.

(b) хэрэв боломжит хугацааг дуусгавар болсноос хойш 30 хоногийн дараа аливаа харилцан хүлээн авч болохуйц нөхөн төлбөр, эсхүл орлох бусад тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд Гомдол гаргагч Тал Гомдол хариуцагч Талд энэхүү хэлэлцээрийн дагуу олгож буй хөнгөлөлт буюу хэлэлцээрээр хүлээж буй бусад үүргийг энэ тухай 30 хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр түдгэлзүүлж болно.

4. Хэрэв Гомдол гаргагч Тал Гомдол хариуцагч Талыг боломжит хугацаанд багтан арбитрын шийдвэрийг гүйцэтгээгүй болон дээрх 3 (а) дэд хэсэгт заасны дагуу зөвлөлдөөн хийгээгүй гэж үзвэл Гомдол хариуцагч Талд энэхүү хэлэлцээрийн дагуу олгож буй хөнгөлөлт буюу хэлэлцээрээр хүлээж буй бусад үүргийг энэ тухай 30 хоногийн өмнө мэдэгдэл хүргүүлсний үндсэн дээр түдгэлзүүлж болно.

5. Дээрх 3, эсхүл 4 дүгээр зүйлийн дагуу энэхүү хэлэлцээрийн дагуу олгож буй хөнгөлөлт буюу хэлэлцээрээр хүлээж буй бусад үүргийг түдгэлзүүлэх нь:

- (a) уг асуудалтай холбоотой маргааны талаар зөвлөлдөөн буюу арбитрын шүүхээр хэлэлцэх үйл ажиллагаа явагдаж байгаа бол хэрэгжихгүй;
- (b) түр зуурынх байх бөгөөд Талууд харилцан хүлээн авч болохуйц шийдвэрт хүрсэн буюу арбитрын шийдвэрийг биелүүлсэн бол зогсоно;
- (c) арбитрын шийдвэрийг хэрэгжүүлээгүйн улмаас үүссэн цуцлалт буюу хохирлын хэмжээгээр хязгаарлагдана;
- (d) цуцлалт буюу хохирол үүссэн салбар, эсхүл холбоотой салбаруудад хөнгөлөлт буюу бусад үүргийг түдгэлзүүлэх нь боломжгүй буюу үр дүнгүй байхаас бусад тохиолдолд зөвхөн тухайн салбар, эсхүл салбаруудаар хязгаарлагдана.

6. Хэрэв Гомдол хариуцагч Тал дээрх 3, 4 болон 5 дахь хэсгийн дагуу энэхүү хэлэлцээрийн дагуу олгож буй хөнгөлөлт буюу хэлэлцээрээр хүлээж буй бусад үүргийг түдгэлзүүлэх шаардлага хангагдаагүй байсан гэж үзвэл Гомдол гаргагч Талтай зөвлөлдөх хүсэлт гаргаж болно. Гомдол гаргагч Тал хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор зөвлөлдөөн хийнэ. Хэрэв Талууд энэ заалтын дагуу асуудлыг хүсэлт хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шийдвэрлэж чадахгүй бол Гомдол хариуцагч Тал дээрх шаардлага хангагдсан байсан эсэхийг тогтоолгохоор арбитрын шүүхэд хандаж болно.

7. Энэ зүйлд заасны дагуу байгуулагдах арбитрын шүүхийн арбитрчид нь боломжтой бол анхдагч арбитрын шүүхийн арбитрчид байна. Хэрэв энэ нь боломжгүй бол энэ зүйлд заасны дагуу байгуулагдах арбитрын шүүхийн арбитрчид 16.7 дугаар зүйлийн 2, 3 болон 4 дэх хэсгийн дагуу томилогдоно. Талууд хэрэв өөр хугацаан дээр тохиролцоогүй бол энэ зүйлд заасны дагуу байгуулагдах арбитрын шүүх нь асуудлыг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор дүгнэлтээ гаргана. Ийнхүү гаргасан дүгнэлт нь Талуудын хувьд эцсийнх байх бөгөөд түүнийг заавал дагаж мөрдөнө.

16.12 дугаар зүйл Хугацаанд өөрчлөлт оруулах

Энэхүү бүлэгт заасан бүх хугацааг тодорхой маргаантай холбогдуулан Талууд харилцан тохиролцсоноор өөрчилж болно.

16.13 дугаар зүйл Зардал

Тал бүр арбитрын шүүхийн үйл ажиллагааны турш өөрсдийн томилсон арбитрч болон төлөөлөгчдийн зардлыг хариуцна. Арбитрын шүүхийн бусад зардлыг Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд эн тэнцүү хуваан гаргана.

16.14 дүгээр зүйл Хэл

Арбитрын шүүхийн бүх үйл ажиллагаа болон арбитрын шүүхэд хүргүүлэх бүх баримт бичиг, мэдээлэл англи хэлээр байна.

17 дугаар бүлэг Төгсгөлийн заалт

17.1 дүгээр зүйл Агуулга болон гарчиг

Энэхүү хэлэлцээрийн бүлэг, хэсэг болон зүйлүүдийн агуулга, гарчигийг зөвхөн ашиглахад дөхөм болгох зорилгоор оруулсан бөгөөд хэлэлцээрийг тайлбарлахад нөлөөлөхгүй.

17.2 дугаар зүйл Хавсралт болон тайлбар

Энэхүү хэлэлцээрийн хавсралт болон тайлбарууд нь түүний салшгүй хэсэг байна.

17.3 дугаар зүйл Нэмэлт, өөрчлөлт оруулах

1. Талууд бичгээр тохиролцсоны дагуу энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2. Дээрх нэмэлт, өөрчлөлтийг Талууд өөрийн хууль тогтоомжийн шаардлагын дагуу батлах бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай өөрийн хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухай Талуудын Засгийн газар хооронд дипломат ноот бичиг солилцох замаар харилцан мэдэгдсэнээр Талуудын тохиролцсон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

3. 2 дахь хэсгийг үл харгалзан зөвхөн дараахь зүйлд хамаарах нэмэлт, өөрчлөлтийг Талуудын Засгийн газрууд дипломат ноот бичиг солилцсоноор оруулж болно:

- (a) 1 дүгээр хавсралт буюу нэмэлт, өөрчлөлт нь Уялдуулсан системд оруулах нэмэлт, өөрчлөлтийн дагуу байх бөгөөд нөгөө Талын зохих гарал үүсэлтэй бараанд 1 дүгээр хавсралтын дагуу ногдуулах гаалийн татварын хэмжээнд өөрчлөлт орохгүй;
- (b) 2 дугаар хавсралт;
- (c) 3 дугаар хавсралт.

17.4 дүгээр зүйл Хүчин төгөлдөр болох

Энэхүү хэлэлцээр Талуудын Засгийн газрууд хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай өөрийн хууль тогтоомжийн шаардлагыг биелүүлсэн тухай дипломат ноот бичиг солилцон мэдэгдсэн өдрөөс хойш 30 дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. хэлэлцээр нь 17.5 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцээрийг цуцлахаас бусад тохиолдолд хүчин төгөлдөр үйлчилнэ.

17.5 дугаар зүйл Цуцлах

Аль нэг Тал хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлийг нөгөө Талдаа дипломат шугамаар нэг жилийн өмнө урьдчилан бичгээр хүргүүлж, хэлэлцээрийг цуцалж болно.

17.6 дугаар зүйл Хүчинтэй эх бичвэр

1. Энэхүү хэлэлцээрийн монгол, япон, англи хэлээрх эх бичвэр нь адил хүчинтэй байна.

2. 1 дэх хэсгийг үл харгалзан:

- (a) (i) 1 дүгээр хавсралтын 2 дугаар хэсэг япон, англи хэлээр байх ба эдгээр эх бичвэр адил хүчинтэй;
- (ii) 1 дүгээр хавсралтын 3 дугаар хэсэг монгол, англи хэлээр байх ба эдгээр эх бичвэр адил хүчинтэй;
- (b) (i) 6 дугаар хавсралтын 1А болон 2 дугаар хэсэг япон, англи хэлээр байх ба эдгээр эх бичвэр адил хүчинтэй;
- (ii) 6 дугаар хавсралтын 1В хэсэг монгол, англи хэлээр байх ба эдгээр эх бичвэр адил хүчинтэй;
- (c) (i) 7 дугаар хавсралтын 1 дүгээр хэсэг япон, англи хэлээр байх ба эдгээр эх бичвэр адил хүчинтэй;
- (ii) 7 дугаар хавсралтын 2 дугаар хэсэг монгол, англи хэлээр байх ба эдгээр эх бичвэр адил хүчинтэй;

(d) (i) 8 дугаар хавсралтын 1, 9 дүгээр хавсралтын 1 дүгээр хэсэг тус тус япон, англи хэлээр байх ба эдгээр эх бичвэр адил хүчинтэй;

(ii) 8 дугаар хавсралтын 2, 9 дүгээр хавсралтын 2 дугаар хэсэг монгол, англи хэлээр байх ба эдгээр эх бичвэр адил хүчинтэй.

3. Эх бичвэрүүд хооронд зөрүү үүсвэл англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

ДЭЭРХИЙГ НОТОЛЖ доор дурдсан нэр бүхий төлөөлөгчид тус тусын Засгийн газраас олгогдсон бүрэн эрхийнхээ дагуу энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурав.

Энэхүү хэлэлцээрийг Токио хотноо 2015 оны 2 дугаар сарын 10-ны өдөр монгол, япон, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдэв.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЯПОН УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ: